



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ

2020

Ядуурлыг бууруулахад ахиц
дэвшил гаргасан болон
зогсонги байдалд орсон
арван жил





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО




THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

ЯДУУРЛЫН ДҮР ТӨРХ

2020

Ядуурлыг бууруулахад ахиц дэвшил
гаргасан болон зогсонги байдалд
орсон арван жил



© 2022 Дэлхийн Банк
Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.

Энэ тайлан нь Дэлхийн банк (ДБ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны хамтын бүтээл юм. Энэхүү бүтээлд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь ДБ, ҮСХ болон Монгол Улсын Засгийн газрын үзэл баримтлалын илэрхийлэл болохгүй.


Энэхүү бүтээлийн агуулга, үзэл санаа, дүгнэлт нь зөвхөн зохиогчдынх бөгөөд ДБ нь тоо мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах үүрэг хүлээгээгүй болно. Энэхүү бүтээлд дурдсан газар зүйн бүс нутаг, хил хязгаар, ашигласан өнгө, нэр томъёо болон бусад мэдээлэл нь аливаа нутаг дэвсгэрийн эрх зүйн байдлын талаар ДБ, ҮСХ-ны зүгээс баримталж буй үзэл санааг илэрхийлээгүй болно.


Эрх ба зөвшөөрөл

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан болно. Эх сурвалжийг тодорхой дурдсан тохиолдолд ашгийн бус зорилгоор энэхүү бүтээлээс иш татаж эсвэл хэсэгчлэн хуулбарлан ашиглаж болно.

Эрх, лицензтэй холбоотой асуудлаар The World Bank Group, 1818 H Street NW, Washington, DC 20433, USA; fax: 202-522-2625; e-mail: pubrights@worldbank.org хаягаар хандана уу.


ДЭЛХИЙН БАНК


 1818 H Street NW,
Washington DC 20433

 202-473-1000;

 www.worldbank.org

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

 Засгийн газрын III байр Бага тойруу-44
Улаанбаатар -11, Монгол Улс

 (976-11)-321433 | 1900-1212

 www.nso.mn

ӨМНӨХ ҮГ (ҮСХ)



Монгол Улс дэлхий дахинаа ядуурлыг устгах, эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалах, энх тайван, хөгжил цэцэглэлтэд хүрэх боломжийг олгоход дуудсан “Хөгжлөөс хэн ч үлдэх, хоцрох ёсгүй” уриалгад нэгдэн Тогтвортой хөгжлийн зорилтуудыг өөрийнхөө орны хөрсөнд буулгаж “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгээ батлан хэрэгжүүлж байна. Тогтвортой хөгжлийн зорилт нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн нэгдмэл, тэнцвэрт, тогтвортой хөгжилд хүрэх гурван тулгууртай бөгөөд ирээдүйд биелүүлэхээр зорьж буй багц зорилтуудын нэгдэл юм.

Монгол Улс үндэсний онцлог шинжээ тусгайлан анхаарч Монголын эзэнт гүрний түүх, нүүдэлчин соёл иргэншил, үндэсний давтагдашгүй ижилсэл ба ондоошилд суурилж, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын дэвшилтэт үзэл баримтлалтай хослуулсан “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгээ боловсруулан 9 зорилго, 47 зорилтоос бүрдэх гурван 10 жилээр хэмжигдэх хөгжлийн үе шатуудаа тодорхойлон урагшилж байна.

Дээрх зорилтуудын хүрэх суурь нь ядуурал, өлсгөлөнгийн бүх хэлбэрийг эцэс болгох, хүний эрхийг дээдлэх, эрх тэгш байдлыг бүрдүүлэх юм. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах, цаашид шаардлагатай бодлого, хөтөлбөрийг боловсруулахад ядуурлын талаарх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцогдсон, хугацааны хувьд харьцуулагдах боломжтой тоо мэдээллийг бий болгоход Монгол Улсын Үндэсний

статистикийн хороо хүчин чармайлт гарган ажилласаар ирсэн.

Хүн амын амьжиргааны байдал нь дан ганц ядуурлын үзүүлэлтүүдээр хэмжигдэхгүй өргөн цар хүрээтэй асуудал бөгөөд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалд “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” хэмээн баталгаажуулсан байдаг. Гэтэл дэлхий дахинаа олон зуун сая хүн нэн ядуу аж төрж, эрүүл мэндээр доройтож, сурч боловсрох эрхээр хязгаарлагдаж, цэвэр ус, ариун цэврийн байгууламж зэрэг нийгмийн суурь үйлчилгээг хүртэж чадахгүй байсаар байна. Ядуурал нь ажилгүйдэл, нийгмийн гадуурхал, байгалийн гамшиг, өвчлөл зэрэг олон шалтгаанаас үүдэлтэй ба хүн амын дунд тэгш бус байдал ихсэх нь хүний үнэ цэнэ, сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх, урт хугацаандаа улс орны нийгмийн болон эдийн засгийн хөгжилд саад тушаа болох талтай байдаг. Тэгш бус байдал нь бидний хэн байх, хаана амьдрахаас үл шалтгаалан бид бүхэнд хамаатай юм.

ҮСХ-ноос хүн амын хэрэглээний мэдээлэлд үндэслэн ядуурлын үзүүлэлтийг тооцох боломжтойгоор “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-г Дэлхийн Банкны техникийн дэмжлэгтэйгээр зохион байгуулан явуулдаг бөгөөд энэ удаагийн үр дүнг ядууралд гарсан өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг өмнөх жилүүдтэй харьцуулан судлах боломжийг хангах үүднээс “Судалгааг-судалгаанд” орлуулах “SWIFT PLUS” аргачлалыг ашиглан Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн техникийн тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны мэдээллийг олон улсын аргачлалын дагуу тооцоход техникийн дэмжлэг үзүүлсэн, тоо мэдээлэл, тайлан боловсруулахад хамтран ажилласан Дэлхийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Андрей Михнев, эдийн засагч хатагтай Икүко Уочи, Лидия Ким болон ядуурлын судалгааны мэргэжилтнүүд, Монгол Улс дахь Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрын хамт олонд талархал илэрхийлье.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТДАВАА

ӨМНӨХ ҮГ (ДЭЛХИЙН БАНК)



Дэлхийн банк Монгол Улсын Үндэсний статистикийн хороотой (ҮСХ) сүүлийн хорин жилийн хугацаанд Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэлд үндэслэн ядуурлын шинжилгээ хийх чиглэлээр хамтран ажиллаж ирсэн. Бидний урт хугацааны хамтын ажиллагаа үргэлжлэн 2018 оны ядуурлын шинэчилсэн тайланг боловсруулсан бөгөөд цаашлан цар тахлын үед зохион байгуулан явуулсан “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа” мөн 2020 оны ядуурлын тооцоолол хийх, тайлангийн үр дүнг боловсруулах зэргээр өргөжин тэлсээр байна. Монгол Улсын ядуурал, тэгш бус байдлын шинжилгээ, тооцоолол хийх үйл ажиллагаанд тууштай дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаад Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваад бид гүнээ талархал илэрхийлж байна.

Тус тайлан 2010-аас 2014 оны эдийн засгийн эрчимтэй, хүртээмжтэй өсөлт нь Монгол Улсын хувьд ядуурлыг бууруулахад гайхалтай ахиц дэвшил гаргахад нөлөөлсөн болохыг харуулна. Харамсалтай нь 2016 оны эдийн засгийн уналтаас шалтгаалан ядуурал буурах хурд мэдэгдэхүйц удааширсан үед Ковид-19 цар тахал дэгдсэн нь нэмэлт дарамт үүсгэсэн хэдий ч ӨНЭЗС-ны 2020 оны үр дүнгээс харахад хүн амын хөдөлмөр эрхлэлт болон өрхийн орлогод үзүүлэх сөрөг нөлөө тахлын эхний жилд тийм ч их байгаагүйг илэрхийлжээ. Хүн амын хэрэглээний өсөлт 2018-аас 2020 оны хооронд бага байсан хэдий ч орлогын өсөлт ялангуяа ядуу, эмзэг бүлгийн орлогын өсөлт мэдэгдэхүйц өндөр байгаа нь орлого, хэрэглээний

чиг хандлагын зөрүүг бий болгосон. Эдийн засгийн тогтворгүй байдлын үед хүмүүс урьдчилан сэргийлэх зорилгоор хуримтлалаа нэмэгдүүлсэн нь энэ ялгааг бий болгосон нэг хүчин зүйл байж болох ч Монгол Улсын хүн амын хэрэглээ, орлогыг үнэн зөв хэмжихэд тулгарч буй бэрхшээлийг цаашид сайтар шинжлэн судлах шаардлага байна.

Монгол Улсад 2021 оны дунд үеэс дэгдсэн Ковид-19-ийн делта вирусийн давалгааны дараа эдийн засаг бага зэрэг сэргэж эхэлсэн ч сэргэлт нь удаан, тэгш бус байгаа шинж тэмдэг илэрч байна. Монгол Улсын импорт, экспортын хамгийн гол түнш болох БНХАУ-ын хилийн хориг, мөн сүүлийн үед тохиолдоод буй хүнсний болон хүнсний бус өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, түлш, эрчим хүчний үнийн өсөлт зэрэг нь нийт хэрэглээнийхээ 40 орчим хувийг хүнсний бүтээгдэхүүндээ зарцуулдаг хотын ядуу өрхүүдэд шинэ эрсдэлийг бий болгож байна. Түүгээр ч зогсохгүй хоёр жилийн хугацаанд төсвөөс хүн амд зарцуулсан амьжиргааг тэтгэх өргөтгөсөн дэмжлэг нь өрийн дарамтыг нэмэгдүүлж, цар тахлын дараа ч өрхүүдэд үргэлжлүүлэн үзүүлж буй төрийн дэмжлэг зорилгодоо чиглэж чадаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Төсвийн хязгаарлагдмал байдал, эдийн засагт тулгарч буй шинэ сорилтуудыг харгалзан Засгийн газрын бүх нийтэд чиглэсэн дэмжлэгийг ядуу, эмзэг бүлгийн өрхүүдэд чиглэсэн хөтөлбөрүүдэд шилжүүлэх нь ядуурлыг бууруулах ажлыг үр дүнтэй урагшлуулах нэн чухал асуудал юм. Ядуу, эмзэг бүлгийн өрхүүдийн орлогын алдагдлыг нөхөх, бэрхшээлийг даван туулах чадварыг нэмэгдүүлснээр улс орны хэмжээнд гэнэтийн сөрөг цочрол гарсан үед тэд эргэж сэргэхэд илүү дөхөм болно.

Дэлхийн банкны баг Монгол Улсад хүн амын амьжиргааг дэмжин ядууралтай тэмцэхэд нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг. Энэхүү тайлан нь ядуурлыг бууруулахад тулгарч буй сорилтуудыг хүлээн зөвшөөрч, бодлогын арга хэмжээг хаана хэрхэн хэрэгжүүлэх нь хамгийн чухал болохыг тодорхойлоход бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, эрдэмтэн, судлаачдад дэмжлэг болно гэдэгт найдаж байна.

ДЭЛХИЙН БАНКНЫ МОНГОЛ ДАХЬ СУУРИН
ТӨЛӨӨЛӨГЧ

АНДРЕЙ МИХНЕВ

ТАЛАРХАЛ

“Ядуурлын дүр төрх-2020” - Ядуурлыг бууруулахад ахиц дэвшил гаргасан болон зогсонги байдалд орсон арван жил” тайланг Икуко Уочи (Дэлхийн банкны эдийн засагч), Лидия Ким (Дэлхийн банкны урт хугацааны зөвлөх) нар ҮСХ-той хамтран боловсруулав. ҮСХ-ноос тайлан боловсруулалтад М.Оюунцэцэг (Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн дарга, Нийгмийн статистикийн газар), Н.Хэнбиш (Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн статистикч, Нийгмийн статистикийн газар), Ц.Мягмаржаргал (Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн статистикч, Нийгмийн статистикийн газар), О.Норовсамбуу (Өрхөд суурилсан судалгааны хэлтсийн статистикч, Нийгмийн статистикийн газар) ажиллалаа. Тайлангийн боловсруулалтыг Б.Батдаваа (ҮСХ-ны дарга), Мартин Райзер (ДБ-ны Монгол, Хятад, Солонгос улсыг хариуцсан захирал), Андрей Михнев (Монгол дахь ДБ-ны суурин төлөөлөгч), Хассан Заман (ДБ-ны Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгийн захирал), Ринку Мургай (ДБ-ны Зүүн Ази, Номхон Далайн ядуурал тэгш бус байдлын асуудал хариуцсан зохицуулагч) нарын удирдлага дор гүйцэтгэсэн болно. Тайлан боловсруулалтын баг Б.Батдаваа (ҮСХ-ны дарга), Э.Эрдэнэсан (Нийгмийн статистикийн газрын дарга), Руслан Г.Емцов (ДБ-ны хөтөлбөрийн удирдагч), Ён Сун Ким (ДБ-ны ахлах эдийн засагч), Жуди Янг (ДБ-ны ахлах эдийн засагч) нарын саналыг талархан хүлээн авсан болно. Мөн тайлан тархаахад дэмжлэг үзүүлсэн Б.Жавхлан (ДБ-ны Гадаад харилцааны ажилтан), хамтран ажиллах үйл ажиллагаанд онцгой дэмжлэг үзүүлсэн Т.Сүхчимэг (ДБ-ны багийн туслах ажилтан) нарт багийн хамт олон талархал илэрхийлж байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХМХ	Хүүхдийн мөнгө хөтөлбөр
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЗАНД	Зүүн Ази, Номхон Далай
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
КНТӨСС	Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа
ӨНЭЭС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
АХС	Ажиллах хүчний судалгаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАЧП	Худалдан авах чадварын паритет
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ДХҮ	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд
ХКИ	Хүний капиталын индекс
ОХЯХ	Олон хэмжээст ядуурлын хэмжүүр

АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	8
ХУРААНГУЙ.....	9
1. ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДАЛ	13
1.1. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ЯДУУРЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ.....	14
1.2. ЯДУУРАЛ 2020 ОНД.....	16
1.3. СҮҮЛИЙН АРВАН ЖИЛИЙН ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДЛЫН ЧИГ ХАНДЛАГА	18
1.4. ЯДУУРЛЫН ОРОН ЗАЙН ЯЛГАА	24
1.5. МОНГОЛ УЛС БОЛОН ОЛОН УЛСЫН ЯДУУРЛЫН ЧИГ ХАНДЛАГА	27
1.6. ЯДУУРЛЫН МӨНГӨН БУС ХЭМЖИГДЭХҮҮН.....	30
2. КОВИД-19 2020 ОНД: ЦАР ТАХЛЫН ЭХЭН ҮЕИЙН ӨРХИЙН АМЬЖИРГАА	37
2.1. МОНГОЛ УЛС ДАХЬ КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ 2020 ОНД.....	38
2.2. ЦАР ТАХЛЫН ХҮН АМЫН АМЬЖИРГААНД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ 2020 ОНД.....	39
2.3. ӨРХИЙН ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ АРГА ЗАМ БА БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ	46
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	52
ХАВСРАЛТ А. 2020 ОНЫ ЯДУУРЛЫН ТООЦООНЫ АРГА ЗҮЙ	53
2020 ОНЫ ЯДУУРЛЫГ ОРЛУУЛАХ АРГА ХЭРЭГЛЭН ТООЦОХ НЬ.....	53
ТООЦОО ХИЙХ ҮНДЭСЛЭЛ.....	53
ОРЛУУЛГЫН АРГА ЗҮЙ.....	54
1-р алхам: Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагчдыг тодорхойлох нь.....	56
2-р алхам: Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөг хувьсагчдыг тодорхойлох нь	56
3-р алхам: 2018 оны ӨНЭЗС –г ашиглан хувьсагчдыг сонгох, загвар боловсруулах нь.....	56
4-р алхам: 2020 оны өрхийн хэрэглээг орлуулан тооцох нь	58
5-р алхам: Үнэлэлт хийн баталгаажуулах нь	61
ТЭГШ БУС БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ НЬ	63
ХАВСРАЛТ Б.	64

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дундаж, хот, хөдөөгөөр, 2018-2020.....	16
Зураг 1.2	Ядуу хүн амын дүнд эзлэх хувь, 2020	16
Зураг 1.3	Цар тахал гараагүй гэж тооцоолон 2020 онд үндэсний ядуурлын түвшинг загварчилсан нь	17
Зураг 1.4	Цар тахал гараагүй гэж тооцоолон 2020 онд хот, хөдөөгийн ядуурлын түвшинг загварчилсан нь	17
Зураг 1.5	Нэг хүнд ногдох хэрэглээний тархалт, 2020.....	17
Зураг 1.6	Хэрэглээний өөрчлөлт дэх ядуурлын түвшний мэдрэмж	17
Зураг 1.7	Ядуурлын түвшин, хувиар, ядуу хүн амын тоо, мянган хүнээр, 2010-2020	18
Зураг 1.8	Ядуурлын гүнзгийрэлт ба мэдрэмж, хувиар, 2010-2020.....	18
Зураг 1.9	Ядуурлын түвшин, хувиар, ядуу хүн амын тоо, мянган хүнээр, 2010-2020	19
Зураг 1.10	Ядуу хүн амын дүнд эзлэх хувь, 2010-2020.....	19
Зураг 1.11	Хэрэглээний өсөлтийн хувь, хүн амын тэнцүү 5 бүлгээр, 2010-2014 ба 2016-2020.....	19
Зураг 1.12	Нийт хүн амын болон хамгийн ядуу 40 хувийн хэрэглээний жилийн дундаж өсөлтийн хурд, хэрэглээний өсөлтийн хүртээмж.....	20
Зураг 1.13	Өсөлтийн хүртээмжийн бүс нутгийн харьцуулалт	21
Зураг 1.14	Ядуурлын өөрчлөлтийг хэрэглээний өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь	21
Зураг 1.15	Ядуурлын өөрчлөлтийг орлогын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь	22
Зураг 1.16	Өсөлт ба ядуурлын жилийн дундаж бодит өөрчлөлт.....	23
Зураг 1.17	Ядуурлын мэдрэмжийн өсөлт.....	23
Зураг 1.18	Хөрш зэргэлдээ хөгжиж буй орнуудын Жини коэффициент	24
Зураг 1.19	Ядуурлын түвшин, хувиар	25
Зураг 1.20	Ядуу хүн амын дүнд эзлэх хувь.....	25
Зураг 1.21	Ядуурлын газар зүйн байршлын задлан шинжилгээ	25
Зураг 1.22	Ядуурлын түвшин, аймгаар, хувиар	26
Зураг 1.23	Монгол Улсын ядуурлын түвшин (ХАЧП-аар тооцсон 1.90 ам.доллар, 3.20 ба 5.50 ам.долларын ядуурлын шугам), 2010-2020.....	27
Зураг 1.24	Дунджаас доогуур болон дээгүүр орлоготой орнуудын ядуурлын түвшингийн бүс нутгийн чиг хандлага	28
Зураг 1.25	Бүс нутгийн улс орнуудын хүн амын бүлэгт эзлэх хувь, хандлага	29
Зураг 1.26	Боловсролын түвшин, нас, хүйсээр, хувиар.....	30
Зураг 1.27	Их, дээд сургуульд хамрагдалтын түвшин, хувиар	31
Зураг 1.28	25 ба түүнээс дээш насны хүмүүсийн дээд боловсролын түвшин, улсаар, хувиар.....	31
Зураг 1.29	Хүний Капиталын Индекс, 2020.....	31
Зураг 1.30	Удаан эдэлгээт бараа, эд хогшил болон интернэт	33
Зураг 1.31	Малын тоо, 2010, 2020.....	34
Зураг 1.32	Үйлдвэрлэсэн ноолуурын дундаж хэмжээ болон борлуулалтын орлого, 2010, 2020.....	34
Зураг 1.33	Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж	34
Зураг 2.1	Цар тахал 2020-оос 2021 онд.....	38
Зураг 2.2	Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин	39
Зураг 2.3	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан), хот, хөдөөгөөр.....	39

Зураг 2.4	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан), хэрэглээний тэнцүү 5 бүлгээр	40
Зураг 2.5	Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт	41
Зураг 2.6	Нэг ажиллагчид ногдох цалингийн орлогын хандлага	42
Зураг 2.7	Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулсан орлогын өөрчлөлт, малын тооны өөрчлөлтийн хувь (2018-2020)	43
Зураг 2.8	Өрхийн нэг хүнд ногдох сарын бодит цалин хөлсний болон нийт орлого	44
Зураг 2.9	Нэг хүнд ногдох хөдөлмөр эрхлэлтийн сарын дундаж орлого, улирлаар, 2020 он	44
Зураг 2.10	КОВИД-19 цар тахлын улмаас 2020 оны 2 дугаар сараас өрхийн хөдөлмөр эрхлэлтийн орлогоо алдсан гэж хариулсан өрхийн хувь, хэрэглээний тэнцүү таван бүлгээр 44	
Зураг 2.11	Цар тахлын улмаас бусдаас тусламж, дэмжлэг авахад хүндрэлтэй байсан гэж хариулсан өрхийн хувь, суурьшлаар, бусдаас тусламж, дэмжлэг авсан хэлбэрээр	46
Зураг 2.12	Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт	47
Зураг 2.13	КОВИД-19 цар тахлыг даван туулах ямар нэгэн арга хэрэглэсэн өрхийн хувь, аргын төрлөөр	48
Зураг 2.14	КОВИД-19 цар тахлын үед өрхөд үзүүлсэн тусламж, даван туулах арга зам ашиглалт, бүс нутгийн орнуудаар	48
Зураг 2.15	Хэрэглээний ахиу хандлага, хэрэглээний тэнцүү таван бүлгээр, 2014-2020 он	49
Зураг 2.16	Сүүлийн 12 сарын хуримтлал үүсгэсэн байдал, хэрэглээний тэнцүү таван бүлгээр, 2016-2020 он	49
Зураг 2.17	Санхүүгийн байгууллагууд дахь иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, 2016-2020	50
Зураг 2.18	Сүүлийн 12 сард зээл авсан өрхийн эзлэх хувь, улирлаар	50
Зураг 2.19	Өрхүүдийн сүүлийн сарын хүнсний хангамжийн санаа зовиол	51
Зураг А.1	Хот/Хөдөө аймгуудыг бүлэгт хуваасан байдал	54
Зураг А.2	2018 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, бүлгээр	57
Зураг А.3	2018 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар	58
Зураг А.4	2016 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, бүлгээр	61
Зураг А.5	Баталгаажуулалт: 2016 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар	62
Зураг А.6	Орлуулж тооцсон нэг хүнд ногдох лог-хэрэглээний тархалт	63

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	Тэгш бус байдлын чиг хандлага, 2010-2020	24
Шигтгээ Хүснэгт 1	SWIFT plus аргаар хийсэн ядуурлын тооцоо	55
Хүснэгт А.1	2018 оны бодит болон 2020 оны орлуулж тооцсон хэрэглээ, ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар	59
Шигтгээ Хүснэгт 2.	2018 оны бодит болон 2020 оны орлуулж тооцсон хэрэглээ ба ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, суурьшлаар	60
Хүснэгт А.2	Бодит болон орлуулж тооцсон Жини коэффициент	63
Хүснэгт Б.1	2018 оны нэг хүнд ногдох сарын бодит болон орлуулж тооцсон дундаж хэрэглээ ба ядуурлын түвшин, бүлгээр	64
Хүснэгт Б.2	2018 оны нэг хүнд ногдох бодит болон орлуулж тооцсон дундаж хэрэглээ ба ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар	64

ХУРААНГУЙ

Эдийн засгийн тогтворгүй байдлаас шалтгаалан 2010-аас 2020 он ядуурлыг бууруулахад ахиц дэвшил гарсан мөн зогсонги байдалд орсон он жилүүд байлаа.



Ядуурлыг бууруулах чиглэлээр 2010-аас 2014 онд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарч байсан бол 2016 оны эдийн засгийн хямралаас улбаалан ядуурал буурах хурд удааширсан байна. 2010 оны эхэн буюу эдийн засгийн эрчимтэй өсөлтийн үед өрхийн хэрэглээний тогтвортой, хүртээмжтэй өсөлтийн үр дүнд ядуурал 2010-аас 2014 онд 38.8-аас 21.6 хувь болон 17.2 нэгж хувиар буурч байжээ. Харин 2016 оны эдийн засгийн уналтын үе эхэлснээр хүн амын хэрэглээний өсөлт буурч, хүртээмж тэгш бус болж чинээлэг өрхүүдэд илүү таатай нөхцөл бүрдэж эхэлсэн байна. Эдийн засгийн өсөлт удааширсан энэ хугацаанд буюу 2016 онд 29.6 хувь болж өссөн ядуурлын түвшин 2020 онд 27.8 хувь болж буурсан ч манай улс Зүүн Ази, Номхон далайн бүс нутагтаа ядуурлыг хамгийн бага хэмжээгээр бууруулсан орны нэг болж байна.

Сүүлийн арван жилийн эхний хагаст ажиглагдсан хүртээмжтэй өсөлт нэмэгдэж тэгш бус байдал буурах хандлага сүүлийн хагас жилүүдэд өөрчлөгджээ. Нийгмийн хамгааллын тусламж, дэмжлэг 2010-аас 2014 онуудад харьцангуй жигд хуваарилагдаж байв. Харин 2016-аас 2020 онд ядуу өрхүүдэд хүрч буй нийгмийн хамгааллын тусламж, дэмжлэгийн хүртээмж буурч амьжиргаа муутай 40 хувийн хүн амын хэрэглээний өсөлтийн хурд нийт хүн амын хэрэглээний өсөлтийн хурдаас бага байсан. Энэ хугацаанд эдийн засгийн хувьд баталгаажсан дундаж давхаргын хүн амын өсөлт удаашрахад эдийн засгийн жигд бус өсөлт болон тэгш бус хуваарилалт нөлөө үзүүлсэн гэж харж болохоор байна.

Хотжилт ихсэж ядуурлын газар зүйн ялгаа багасаж байгаа нь ядуус хот, суурин газарт ялангуяа Улаанбаатар хотод улам бүр төвлөрч байгааг харуулж байна. Хот, суурин газрын ядуурал 2010 онд хөдөө орон нутгийнхаас (33.2 хувь ба 49.0 хувь) харьцангуй бага байсан бол 2010 оноос хойш хөдөө орон нутгийн ядуурлын бууралтын хурд хот суурин газрынхаас мэдэгдэхүйц нэмэгдэж, хот, хөдөөгийн ядуурлын зөрүү болох 16 нэгж хувийг 4 нэгж хувьд хүргэсэн байв. Үүнтэй ижил дүр зургийг бүс нутгийн үр дүнгээс харж болно. Тухайлбал, 2010 онд хамгийн ядуу (Баруун бүс) бүсийн ядуурлын түвшин хамгийн чинээлэг (Төвийн бүс) бүсээс 22 нэгж хувиар өндөр байв. Харин ядуу бүс нутгийн ядуурал хурдан буурснаар 2020 онд Баруун болон Төвийн бүсийн ядуурлын түвшингийн ялгаа 8 нэгж хувь болсон байдаг. Сүүлийн жилүүдэд ядуурлыг бууруулах хурд зогсонги байдалд орж эхэлснээс гадна хотжилтын түвшин 2010 оноос хойш нэмэгдсээр (жил бүр ойролцоогоор 2.6 хувиар нэмэгдсэн) нийт ядуу хүн амд Улаанбаатар хотод амьдардаг ядуу хүн амын эзлэх хувь 2010 онд 34 хувь байснаа 2020 онд 42 хувь болон тасралтгүйгээр өсөхөд нөлөө үзүүлжээ.

Сүүлийн арван жилд өрхийн аж байдлын мөнгөн бус хэмжигдэхүүнүүд сайжирсан ч хөдөөгийн болон гэр хорооллын оршин суугчдын дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмжид мэдэгдэхүйц ялгаа байсаар байна. Манай улс хүн амын боловсролын үзүүлэлтээрээ тэргүүлдэг ба залуучуудын (25-34 нас) тал хувь нь бакалаврын болон түүнээс дээш зэргийн боловсрол эзэмшжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд бараг бүх өрх цахилгаан эрчим хүч, нарны эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан байгаа нь айл өрхүүдийн гэр ахуйн цахилгаан хэрэгслийн өмчлөл, ашиглалт маш их нэмэгдэхэд хүргэсэн. Гэсэн хэдий ч хөдөө орон нутаг, гэр хорооллын оршин суугчдын дунд интернэт ашиглалт, сайжруулсан ус, ариун цэврийн байгууламжийн хангамж, найдвартай халаалтын эх үүсвэрийн хангамжийн асуудал зэрэг тулгарч буй бэрхшээлүүд байсаар байгаа бөгөөд цаг хугацаа өнгөрсөн ч энэ ялгаатай байдал арилахгүй байна. Тухайлбал, гэрт амьдарч буй арван хүн тутмын зургаа нь л ундны усны сайжруулсан эх үүсвэртэй, арван хүн тутмын найм нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай байна. Гэтэл Улаанбаатар хотод амьдарч буй өрхүүдэд эдгээр үйлчилгээ илүү хүртээмжтэй байна. Ядуурлыг бууруулах ажлыг урагшлуулахад өрхийн эдгээр мөнгөн бус амьжиргааны

үзүүлэлтүүдийг сайжруулах, байршлын ялгаатай амьдарч байгаагаас шалтгаалан гачигдалд өртөж буй байдлыг арилгахад цаашид улсын хэмжээнд анхаарал хандуулах шаардлагатай юм.

Сүүлийн арван жилийн сүүл хагаст өрхийн орлого, хэрэглээний чиг хандлага ялгаатай болж хэрэглээ зогсонги байдалд орж, орлого мэдэгдэхүйц өссөн байна. Өрхүүд тулгарах бэрхшээлээ бодитоор харж, үр ашиггүй зарцуулалтаа хянаж, урьдчилан сэргийлэх зорилгоор хуримтлал үүсгэж байгаа нь орлого, хэрэглээний ялгааг илт нэмэгдүүлж ядуурал буурахад удаашрал үүсгэсэн байх талтай.



2016-аас 2020 оны хооронд өрхийн бодит орлого хурдацтай өссөн боловч хэрэглээ зогсонги байдалд орсон. Нийгмийн халамжийн шилжүүлэг, цалин, мал аж ахуйгаас олох орлого нэмэгдсэнээр нэг хүнд ногдох бодит орлого 2016-аас 2020 оны хооронд дунджаар 23 хувиар өссөн бөгөөд хамгийн их өсөлт 2018-аас 2020 онд (19 хувь) гарсан байна. Өсөлтийн дийлэнх хувь нь энэ хугацаан дахь цалингийн тогтвортой өсөлтөөс шалтгаалсан ба 2018 онтой харьцуулахад нэг ажиллагчид ногдох бодит цалин 2020 онд 22.6 нэгж хувиар өссөн байна. Нэг өрхөд ногдох бодит орлогын өсөлт нь ядуу өрхүүдийн дунд илүү байсан бөгөөд хамгийн амьжиргаа багатай 40 хувийн өрхүүдийн бодит орлого дунджаар 52 хувиар, амьжиргаа сайтай 60 хувийн өрхүүдийнх 8 хувиар өссөн байв. Түүнчлэн нэг хүнд ногдох нийгмийн халамжийн шилжүүлэг дунджаар 35 хувиар бодитоор өссөн ба энэ өсөлт амьжиргаа багатай 40 хувийн өрхүүдэд арай ахиу байв. 2016-аас 2020 оны хооронд хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн шилжүүлгийн орлого мэдэгдэхүйц нэмэгдсэн хэдий ч хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн хүн амын хэрэглээний өсөлт болон ядуурлын бууралт бага хэвээрээ байжээ. Хэрэглээг орлогын бүрэлдэхүүн хэсгээр нь задалж шинжилсэн үр дүнгээс харахад хэрэв хэрэглээ орлоготой адил хурдацтай өссөн бол ядуурал 2016-аас 2020 оны хооронд 9 нэгж хувиар нэмж буурах байлаа.

Эдийн засгийн тогтворгүй, тодорхойгүй байдал нь ялангуяа Ковид-19 цар тахлын үед өрхүүдийн дунд эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хуримтлалыг нэмэгдүүлэхэд хүргэсэн байж магадгүй байна. ӨНЭЗС-ны 2020 оны тоо баримтаас хуримтлалын талаар өрхүүдийн өгсөн мэдээллээс харахад ялангуяа ядуу өрхүүдийн хуримтлал бий болгох идэвх эрс нэмэгдсэн байв. 2018-аас 2020 оны хооронд хуримтлал үүсгэсэн өрхүүд хамгийн ядуу 20 хувийн бүлэгт өмнөх жилүүдээс бараг гурав дахин нэмэгдэж, түүний дээд талын 20 хувийн бүлэгт хоёр дахин өссөн байна. Сүүлийн жилд хадгаламжиндаа хийсэн дундаж мөнгөн дүн ядуу өрхүүдийн хувьд илүү их нэмэгдсэн байна. Цаашилбал, захиргааны мэдээллээс харахад санхүүгийн байгууллагууд дахь иргэдийн хадгаламжийн нийт үлдэгдэл 2020 оны турш өссөн, хадгаламжийн хэмжээ улирал тутам өссөн ба 2020 оны 1 дүгээр улиралд 0.4 хувиар, 2020 оны 4 дүгээр улиралд 11 хувиар өссөн байжээ.

ӨНЭЗС-ны мэдээллийг ашиглан хэрэглээ, орлогыг хэмжихэд учирч болзошгүй бэрхшээлүүд нь ядуурал болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох дүр зургийг бүрхэг болгож байна. 2016, 2018 оны ӨНЭЗС-ны өрхүүдийн хэрэглээнд хийсэн шинжилгээнээс дүгнэхэд, хот, аймгийн төвийн өрхүүдийн хүнсний хэрэглээний мэдээллийг цуглуулахын тулд нэг сарын турш өдрийн тэмдэглэл хөтлүүлж байсан учраас хариулагчдын дургүйцэл нь мэдээллийг дутуу нөхөхөд хүргэдэг байсан байж болзошгүйг харуулсан. Лавлагаа хугацаа уртсах тусам хариулагч өрхүүд хүнсний хэрэглээгээ мэдээлэх нь буурч байсан ба ойролцоогоор 30 орчим хувь нь өдөр тутмын хүнсний хэрэглээгээ бүртгээгүй байв. Өрхүүд хэрэглээг дутуу мэдээлсэн байж болзошгүй байгаа нь ӨНЭЗС болон үндэсний дансны тооцооны өрхийн хэрэглээний хооронд гараад байгаа зөрүүнд нөлөөлсөн байж магадгүй байна. 2010 онд үндэсний дансны тооцоонд 80 орчим хувийг нь өрхийн хэрэглээ эзэлж байсан бол энэ онд дөнгөж 51 хувийг эзэлж байна. Баримт сөхвөл, 2016-аас 2020 оны хоорондох жилийн хэрэглээний өсөлт ӨНЭЗС-нд 1 хувь байсан бол үндэсний дансны тооцоонд 5.6 хувь байв. Үндэсний дансны тооцоо болон өрхийн судалгааны хэрэглээний зөрүү өсөж байгаа шалтгааныг өрхүүд ӨНЭЗС-нд хэрэглээнийхээ талаар дутуу тайлагнаж байж болохыг ойлгох нь цаашид чухал ач холбогдолтой байх болно.

2020 оны хэрэглээг бүрдүүлэх, хэмжихтэй холбоотой нэмэлт асуудал бол ӨНЭЗС-ны асуулгад өөрчлөлт орсны улмаас хэрэглээ, ядуурлыг тооцоолоход ашигласан “судалгааг-судалгаанд” орлуулах аргачлал юм. Загварын баталгаажуулсан тооцооллууд нь хэрэглээг урьдчилан таамаглаж, ядуурлыг тооцох арга нь сайн үр дүнтэй болохыг харуулж байгаа боловч загварчилсан тооцооллын арга нь тодорхой хэмжээний алдаатай байдаг. Иймээс энэ тооцооллын арга нь сүүлийн арван жилийн сүүл хагаст ажиглагдаад байгаа орлого, хэрэглээний ялгаатай хандлагад нөлөөлж байж магадгүй юм. Энэ нөлөөг 2022 оны ӨНЭЗС-ны мэдээллийг ашиглан хэрэглээний бүрдлийг байгуулан ядуурлын шугамыг шинэчилсэн тохиолдолд үнэлэх боломжтой болох юм.

Эцэст нь хэлэхэд, нийгмийн халамжид их хэмжээний мөнгө зарцуулсан ч энэ шилжүүлэг нь өрхүүдийн хэрэглээг өсгөх, ядуурлыг бууруулахад бага хэмжээний нөлөө үзүүлсэн байжээ. “Хүүхдийн мөнгө” зэрэг нийгмийн хамгааллын хөтөлбөрт амьжиргаа сайтай 60 хувьд багтсан өрхүүд хамрагдсан байхад ядуу 40 хувьд багтсан зарим өрх хамрагдаагүй байх тохиолдол байна. Тухайлбал, 2020 онд хамгийн ядуу 40 хувьд багтсан өрхийн 20 орчим хувь нь хүүхдийн мөнгө аваагүй байхад амьжиргаа сайтай 60 хувьд багтсан өрхүүдийн бараг тал хувь нь хүүхдийн мөнгө авч байв. Түүнчлэн 2020 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн тал орчим хувь нь эхний 60 хувьд буюу амьжиргаа сайтай бүлгүүдэд хуваарилагджээ. Бүтцийн шинжилгээнээс харахад 2010-аас 2020 оны хооронд бусад хүчин зүйлсийг тогтмол гэж үзвэл нийгмийн халамжийн шилжүүлэг ядуурлын түвшинг 10 орчим нэгж хувиар бууруулах боломжтой байсан. Гэвч сүүлийн арван жилийн сүүл хагаст өрхийн хэрэглээний ахиу хандлага буурсан нь энэ халамжийн шилжүүлгийн нөлөөллийг багасгасан байна. Урьдчилан сэргийлэх зорилгоор хуримтлал үүсгэх зан үйл хүн амын дунд өссөн нь сайн талтай хэдий ч нийгмийн халамжийн зорилтот байдал үр ашиггүй болж байгаа учраас орлогын дэмжлэг зайлшгүй шаардлагатай ядуу, эмзэг бүлгийн өрхүүдэд халамжийн бодлогыг илүү чиглүүлснээр ядуурлыг бууруулахад ахиц дэвшил гаргах боломжтой юм.

Цар тахлын эхний жил хүн амын амьжиргаанд төдийлөн нөлөөлөөгүй ч, цар тахалтай холбоотойгоор хөдөлгөөнийг хатуу хязгаарлаж эхэлсэн 2020 оны сүүлийн улиралд нөхцөл байдал хүндэрч, хүн амын эрүүл мэндийн хямрал эрчимжиж эхэлсэн нь 2021 онд байдал илүү хүндрэхийг илтгэж байв.



2018-аас 2020 оны хооронд ядуурал нэмэгдээгүй ч Ковид-19 цар тахал ядуурал буурах хурдыг удаашруулсан болохыг тоо баримт харуулж байна. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2020 оны судалгаагаар ядуурал 27.8 хувь буюу 2018 оныхоос 0.6 нэгж хувиар буурсан хэдий ч үр дүн нь статистикийн хувьд ач холбогдол багатай байна. Үнэн хэрэгтээ манай улсын хүн амын амьжиргааны эмзэг байдлын түвшин тогтмол өндөр байгаа учраас Ковид-19 шиг сөрөг цочрол олон өрхийг ядуурал руу түлхэх аюултай юм. Харин цар тахал гараагүй буюу цар тахлын нөлөө хүн амын амьжиргаанд нөлөөлөөгүй үед гэж үзсэн загварын тооцооллоор ядуурал 3.5 нэгж хувиар нэмж буурах боломжтой байсныг харуулж байна.

ӨНЭЗС-ны 2020 оны мэдээллээс харахад цар тахал хүн амын ажил эрхлэлтэд сүүлийн улирал хүртэл мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй байсан бөгөөд хот, суурин газарт болон үйлчилгээний салбарын ажиллагчид өртөх магадлал өндөр байв. Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2018-аас 2020 онд буурсан ялангуяа 2020 оны 4 дүгээр улиралд мэдэгдэхүйц буурсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн энэхүү бууралт нь хот, суурин газар, тэр дундаа Улаанбаатар хотод хамааралтай байна. 2018-аас 2020 онд хөдөө, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн түвшин 62.7-оос 61.6 хувь болж буурсан бол хот, суурин газарт 53.4-өөс 49.0 хувь болж буурчээ. Суурьшлын энэ ялгаатай нөлөөлөл нь цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн уналтын үед хамгийн их өртсөн үйлчилгээний салбарын үйл ажиллагаа хот, суурин газар илүү төвлөрдөгтэй холбоотой байж болох юм. Хот, суурин газарт чинээлэг ажиллагчдын эзлэх хувь өндөр ба тэд жижиглэнгийн худалдаа гэх мэт үйлчилгээний салбарт илүү оролцоотой байгаа нь 2020 онд түр болон байнгын ажлын байраа алдахад хүргэсэн байж болзошгүй байна.

2018-аас 2020 онд нэлээд өсөлттэй байсан хөдөлмөр эрхлэлтийн орлого 2020 оны эцсээр буурч эхэлсэн. Цалин, нийгмийн халамж, мал аж ахуйн орлогын тогтвортой өсөлтөөс шалтгаалан нэг хүнд ногдох өрхийн дундаж бодит орлого 2018-аас 2020 онд 19 хувиар өссөн байна. Энэ хугацаан дахь орлогын өсөлтийн талаас илүү хувь нь бодит цалингийн өсөлтөөс шалтгаалж байж болох бөгөөд бодит цалин Ажиллах хүчний судалгаагаар 2019 онд мэдэгдэхүйц нэмэгдэж, 2020 онд зогсонги байдалд орсон байжээ. Гэсэн хэдий ч ӨНЭЗС-аас тооцоолсон цалингийн өсөлт нь зөвхөн 2020 оны өсөлтийг илэрхийлэхгүй бөгөөд сарын дундаж цалинг тооцох жишиг хугацаа нь судалгаанаас өмнөх сүүлийн 12 сарын мэдээллийг цуглуулдаг болно. ӨНЭЗС нь өрхийн бүтэн жилийн мэдээллийг цуглуулдаг судалгаа учраас 2020 оны цалингийн орлогын лавлагаа хугацааны ихэнх хэсэгт 2019 оны орлогын мэдээлэл багтсан тул орлогын богино хугацааны өөрчлөлтийг илрүүлэх боломжгүй гэсэн үг юм. Үнэндээ, 2020 оны сүүлийн улиралд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн орлого буурч эхэлсэн нь цар тахлын улмаас амьжиргаа доройтож болзошгүй дохиог өгч байв.

Цаашид хийгдэх судалгаанууд цар тахлын урт хугацааны нөлөөллийн талаар илүү тодорхой дүр зургийг гаргах боловч 2020 оноос үүдэлтэй тэгш бус байдлын нөлөөлөл удаан хугацаанд үргэлжилж болох юм. 2021 он хүртэл хөдөлгөөний хатуу хязгаарлалттай, коронавирсийн өвчлөлийн тохиолдол, нас баралт ихтэй байсан хэдий ч ажиллах хүчний судалгааны үр дүнгээс харахад хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал тийм ч муу байсангүй. Харин 2021 оны эхний улиралд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин сүүлийн жилүүдэд байгаагүй хамгийн доод түвшинд хүрсэн ба хөдөлмөрийн дутуу ашиглалт нэмэгдэж, бодит цалин буурсан байв.

Нэмж дурдахад, ӨНЭЗС-ны 2020 оны тоо мэдээллээр ядуу өрхүүд ялангуяа хот, суурин газарт оршин суудаг өрхүүд хөдөлгөөний хатуу хязгаарлалттай үед хүнсний аюулгүй байдлын алдагдалд орох хандлага илүү байжээ. Хүнсний аюулгүй байдлын алдагдал удаан үргэлжлэх нь хүүхдэд учруулах хор хөнөөл их учраас 2021 он болон түүнээс хойшхи цар тахлын нөлөөллийн судалгаа нь тахлын оргил үед ядуу, эмзэг бүлгийнхэн хэрхэн өртсөн болон эдийн засгийн хямралаасаа гарч чадаж байгаа эсэхийг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Цар тахлын нөлөөллийг бууруулахад нийгмийн халамжийн үзүүлсэн нөлөө, өрхүүд энэ тусламжийг хэзээ, хэрхэн ашигласан зэргийг судлах нь цаашид ирээдүйн эдийн засгийн хямралыг даван туулахад хэрэгтэй мэдээлэл болох юм.

1

ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДАЛ

Энэ бүлэгт ядуурал, тэгш бус байдлын сүүлийн арван жилийн чиг хандлагыг харуулна. Мөн олон улсын ядуурлын үзүүлэлтийн улс хоорондын харьцуулалт болон өрхийн аж байдлыг илэрхийлэх мөнгөн бус хэмжигдэхүүний сүүлийн арван жилийн дүр зургийг онцлон харуулахыг зорилго.

1.1. ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ЯДУУРЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС) нь хүн амын амьжиргааг ядуурал, тэгш бус байдлаар тодорхойлох үндсэн зорилготой бөгөөд 2007 оноос тогтмол, 2012 оноос ядуурлын үзүүлэлтийг хоёр жил тутам тооцох боломжтой байдлаар явуулж буй үндэсний хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм. Үндэсний ядуурлын шугамыг¹ үндсэн хэрэгцээний зардлын аргачлалыг ашиглан 2010 оны ӨНЭЗС-наас тооцсон бөгөөд энэ нь өрхийн гишүүний “үндсэн хэрэгцээгээ” хангахад шаардагдах нэг хүнд ногдох хэрэглээний түвшинг хүнсний болон хүнсний бус хэрэглээний хувьд тооцдог арга юм. Ядуурлыг улс, хот, хөдөө, аймгийн түвшинд нэг хүнд ногдох сарын хэрэглээ нь үндэсний ядуурлын шугамаас доогуур байгаа хүн амын эзлэх хувь гэж тооцсон. Хот, хөдөөг цаашлаад дөрвөн суурьшилд хуваарилах боломжтой бөгөөд хотод Улаанбаатар, аймгийн төв, хөдөөд сумын төв, хөдөө нутаг багтана.

Олон улсын сайн туршлагад үндэслэн хэрэглээ, ядуурлын хэмжилтийг сайжруулах зорилгоор ҮСХ 2020 оны ӨНЭЗС-ны хэрэглээний асуулгад өөрчлөлт оруулсан. Тухайлбал, хотын өрхийн хүнсний хэрэглээг хэмжих өдрийн тэмдэглэлийн лавлах хугацааг нэг сар байсныг долоо хоног болгож, хүнсний бус хэрэглээний жагсаалтыг хураангуйлсан². ӨНЭЗС-ны 2016, 2018 оны үр дүнд хийсэн шинжилгээнээс харахад хотын өрхүүд хүнсний хэрэглээгээ мэдээлэхээс залхсан байж болзошгүй байсан. Тодруулбал, өрхүүд лавлагаа хугацаа уртсах тусам хүнсний хэрэглээгээ мэдээлэх нь багассан байв. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан бараг бүх өрхүүд хүнсний хэрэглээгээ дутуу тайлагнасан байх магадлалтай учраас ядуурлын тооцоонд нөлөөлөх үр дагавар нь асуудалгүй байж болох юм. Харин 2020 оны ӨНЭЗС-ны хотын өрхүүдийн хүнсний хэрэглээг бүртгэсэн богино хугацаа нь хэрэглэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ болон хэрэглэсэн калорийн аль алиных нь хувьд хэрэглээг дутуу тайлагнах асуудлыг мэдэгдэхүйц багасгасан байв.

Гэсэн хэдий ч 2020 оны сайжруулсан асуулгаар цуглуулсан ӨНЭЗС-ны бодит өгөгдлөөс тооцсон өрхийн нийт хэрэглээ, ядуурлын түвшингийн тооцоог өмнөх жилүүдийнхтэй шууд харьцуулах боломжгүй болсон учраас энэ удаад хэрэглээ, ядуурлыг хэмжих өөр аргыг ашиглах шаардлага бий болсон. Өрхийн хэрэглээ, ядуурлын түвшинг өмнөх судалгааны жилүүдийнхтэй харьцуулах боломжийг хангах үүднээс 2020 оны хэрэглээг судалгааг-судалгаанд орлуулан тооцох аргыг ашиглан загварчилсан (Шигтгээ 1.1-ийг үзнэ үү). Энэ тооцооны аргачлалын нэг сул тал нь хэрэглээний хуваарилалтыг төгс дуурайлган загварчлах боломжгүй байдал юм. Иймээс 2020 оны хэрэглээний тооцооны үр дүнд тодорхой нөлөө үзүүлсэн байж болзошгүй учраас энэхүү тайлангийн үр дүнг тайлбарлахдаа анхаарч үзэх шаардлагатай.

¹ 2010 оны ӨНЭЗС-нд үндэслэн тооцсон ядуурлын шугамыг суурь болгон судалгаа хоорондын үнийн өөрчлөлтийг тусгасан ХҮИ-ээр индексжүүлсэн. 2022 оны ӨНЭЗС-нд үндэслэн ядуурлын шугамыг шинэчлэхээр төлөвлөж байна.

² 2020 оны ӨНЭЗС-ны хэрэглээний асуулгад оруулсан өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт А-аас үзнэ үү.

Шигтгээ 1.1 Судалгааг-судалгаанд орлуулан тооцох аргачлалыг 2020 оны өрхийн хэрэглээ, ядуурлыг тооцоолоход ашиглах нь

ӨНЭЗС-ны асуулгад оруулсан өөрчлөлтөөс шалтгаалан 2020 оны хэрэглээ, ядуурлын түвшинг SWIFT Plus (Survey of Well-being via Instant and Frequent Tracking) аргачлалыг ашиглан судалгааг-судалгаанд орлуулах аргаар тооцоолсон (Yoshida et al., 2015; Yoshida et al., 2021). SWIFT Plus нь 2018 оны ӨНЭЗС-ны өрхийн хэрэглээний мэдээллийг ашиглан загвар боловсруулж 2020 оны ӨНЭЗС-ны мэдээлэлд үндэслэн 2020 оны өрхийн хэрэглээ болон ядуурлыг урьдчилан таамаглах арга юм. Аймгийн хэмжээнд тооцооллын нарийвчлалыг сайжруулахын тулд аймгуудыг нийгэм, эдийн засгийн төстэй шинж чанараар нь бүлэглэж загварыг боловсруулсан бөгөөд хотын 8 бүлэг, хөдөөгийн 6 бүлгийн нийт 14 загварыг боловсруулсан. Эдгээр бүлгүүдийг нэгтгэн ядуурлыг улс, хот, хөдөө, бүс, аймгийн түвшинд тооцсон боловч 4 суурьшлын түвшинд ядуурлыг тооцох боломжгүй байв.

Тооцоог баталгаажуулсан 2016, 2018 оны үр дүнгүүд нь энэ тооцооллын арга ядуурлын түвшин болон Жини коэффициентийг бодит байдалтай төстэй урьдчилан таамаглах боломжтой болохыг баталсан боловч (Хавсралт А-г үзнэ үү) хэрэглээний хуваарилалтыг төгс

загварчлах боломжгүй байгааг харуулсан. Судалгааг-судалгаанд орлуулан тооцох арга нь өрхийн хэрэглээний хувьсагчдын хоорондын хамаарал цаг хугацааны явцад өөрчлөгддөггүй гэсэн таамаглалд тулгуурладаг. Гэсэн хэдий ч коронавирус цар тахал зэрэг эдийн засгийн томоохон цочрол нь өрхийн хэрэглээний зан үйлийг өөрчилж, тооцооллын загвар нь хэрэглээг үнэн зөв таамаглах боломжгүй байж болзошгүй учраас 2020 оны хэрэглээний тооцооллын үр дүнг тайлбарлахдаа анхаарах шаардлагатай асуудал юм. ӨНЭЗС-ны 2022 оны мэдээллийг ашиглан ядуурлын шугамыг шинэчлэхээр төлөвлөж байгаа нь ядуурлын шинэ цувааны эхлэлийг тавих, улмаар 2020 оны бодит хэрэглээний багцыг бий болгоход ашиглагдах болно. Энэ нь эргээд хэрэглээний бодит мэдээллийг ашиглан 2020 оны хэрэглээ, хэрэглээний хуваарилалтыг нарийвчлан шинжлэх боломжийг олгох юм.


Хавсралт А-д 2020 онд хэрэглээ, ядуурлыг тооцоолоход ашигласан аргачлалын талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан болно.

1.2. ЯДУУРАЛ 2020 ОНД


Ядуурлын түвшин 2020 онд 27.8 хувь болж 2018 оноос 0.6 нэгж хувиар буурч, ойролцоогоор нийт хүн амын 903.4 мянга нь ядуу амьдарч байна. 2020 оны байдлаар нэг хүнд ногдох сарын хэрэглээ үндэсний ядуурлын шугам 184747 төгрөгөөс доош бол ядуу гэж тооцогдож байна. Өөрөөр хэлбэл үндэсний ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байгаа иргэд амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангах зайлшгүй шаардлагатай хүнс болон хүнсний бус хэрэглээний зүйлсээ худалдан авах чадваргүй байна гэсэн үг юм. Нийт хүн амын 27.8 хувь буюу 903.4 мянган хүн ядуу амьдарч байна (Зураг 1.1). 2018-аас 2020 оны хооронд ядуу хүн амын тоо бага зэрэг буурсан ч өөрчлөлт нь 5 хувийн ач холбогдлын түвшин дотор байгаа учраас статистикийн хувьд ач холбогдолтой өөрчлөлт биш юм. Ядуурлын гүнзгийрэлт ба мэдрэмж³ 2018 онтой харьцуулахад өөрчлөлт багатай байна.

Хот суурин газарт 2020 онд ядуурлын түвшин 26.5 хувь болж 2018 оноос 0.7 нэгж хувиар, хөдөө орон нутагт 30.5 хувь болж 0.3 нэгж хувиар буурсан байна. Нийт ядуу хүн амын ойролцоогоор 3 хүн тутмын 2 нь хот суурин газарт, 42 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна (Зураг 1.2).

Зураг 1.1 Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, улсын дундаж, хот, хөдөөгөөр, 2018-2020



Зураг 1.2 Ядуу хүн амын дүнд эзлэх хувь, 2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2020


Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

Тооцооны үр дүнгээс харахад 2020 онд ядуурал 2018 онтой харьцуулахад нэмэгдээгүй хэдий ч Ковид-19 цар тахал ядуурал буурах хурдыг сааруулсан байна. Цар тахал гараагүй байсан бол ядуурлын түвшин ямар байхыг бодитоор тооцоолох боломжгүй хэдий ч, хэрвээ цар тахал гараагүй бол гэж тооцоолсон загварт үндэслэсэн тооцоо нь бидэнд өрхүүдийн амьжиргаанд гарах байсан өөрчлөлтийг харуулж чадна гэж үзсэн⁴. Хэрэв Ковид-19 цар тахал гараагүй байсан бол улсын хэмжээнд ядуурлын түвшин 2020 онд 3.5 нэгж хувиар нэмж бууран 24.3 хувьд хүрч болох байсныг загварын тооцоолол харуулж байна (Зураг 1.3). Харин хотод 3.0 нэгж хувиар, хөдөөд 4.6 нэгж хувиар нэмж буурахаар байжээ (Зураг 1.4). Эдгээр загварчилсан тооцоолол нь цар тахал өрхийн хэрэглээ, хөдөлмөр эрхлэлтэд их сөрөг нөлөө үзүүлсэн бөгөөд хэрэв цар тахлын сөрөг нөлөө байгаагүй бол ядуурал мэдэгдэхүйц буурах байсныг харуулж байна.

³ **Ядуурлын гүнзгийрэлтийн индекс** нь ядуу бус хүн амыг ядуурлын шугамаас 0 хувийн зөрүүтэй гэж үзвэл хүн тус бүрийн хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамаас хэдэн хувиар доогуур байгааг илэрхийлнэ. **Ядуурлын мэдрэмжийн индекс** нь ядуу хүн амын дундах хэрэглээний тархалтыг харуулна. Тухайн өрхийн хэрэглээ нэмэгдсэн ч хэмжээ нь ядуурлын шугамаас доогуур байвал ядуурлын хамрах хүрээ, гүнзгийрэлт өөрчлөгдөхгүй, харин ядуурлын мэдрэмж нь нэмэгдэнэ.


⁴ Ядуурлыг цар тахал гараагүй үеийн симуляцийн загвараар ("КОВИД-ын өмнөх загвар") тооцохыг Ёшида (2021) хөгжүүлсэн. Энэхүү симуляцийн загвар нь 2020 оны албан ёсны ядуурлыг тооцсон ("КОВИД-ын дараах загвар") загвартай ижил боловч гол ялгаа нь дан цаг хугацаанд өөрчлөгддөггүй хувьсагчдаас (жишээлбэл: өрхийн хүн ам зүйн үзүүлэлтүүд, орон сууцны нөхцөл, хөрөнгийн өмчлөл) бүрдсэн. Харин ковидийн дараах загвар нь цаг хугацааны хувьд өөрчлөгддөг болон цаг хугацааны өөрчлөгддөггүй хувьсагчдыг хоёуланг нь багтаасан. Иймд ковидын өмнөх загвараар хэрэв цар тахал гараагүй бол гэж тооцоо хийх боломжтой гэж үзсэн. Дэлгэрэнгүйг Хавсралт А-аас үзнэ үү.

Зураг 1.3 Цар тахал гараагүй гэж тооцоолон 2020 онд үндэсний ядуурлын түвшинг загварчилсан нь



Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2020


Зураг 1.4 Цар тахал гараагүй гэж тооцоолон 2020 онд хот, хөдөөгийн ядуурлын түвшинг загварчилсан нь



Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2020


Хүн амын нэлээдгүй хувь нь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр хэрэглээтэй амьдарч байгаа нь тэднийг Ковид-19 цар тахал шиг аливаа нэгэн цочрол ядуурал руу түлхэж болзошгүй эмзэг болгож байна. Ядуурлын шугамыг 25 хувиар өсгөхөд нийт хүн амын 14.4 хувь буюу 467 мянган хүн ядуурлын шугам болон ядуурлын шугамыг 25 хувиар өсгөсөн үзүүлэлтийн хооронд орж 2020 оны нийт хүн амын 27.8 хувь буюу 903 мянган ядуу хүн дээр нэмэгдэхээр байна (Зураг 1.5). Эдгээр “бараг л ядуу” хүмүүс үнийн өсөлт, ажилгүйдэл, өвчин, байгалийн гамшигт нэрвэгдэх зэрэг цочролд өртөхөд л ядууралд орох эмзэг байдалтай байна. Өөрөөр хэлбэл, өрхийн нэг хүнд ногдох хэрэглээний өчүүхэн төдий өөрчлөлт нь эдгээр эмзэг бүлгийн хүн амыг ядуурал руу амархан түлхэж болзошгүй юм. Тухайлбал, хэрэглээний өөрчлөлтийн мэдрэмж нь өрхийн нэг хүнд ногдох хэрэглээний түвшинг 5 хувиар бууруулахад улсын ядуурлын түвшинг (27.8 хувь) 3 нэгж хувиар нэмэгдүүлж 30.8 хувьд хүргэх боломжтойг харуулна (Зураг 1.6). Түүнчлэн, хэрэглээний өөрчлөлтийн мэдрэмж нь өрхийн нэг хүнд ногдох хэрэглээний түвшинг 10 ба 20 хувиар бууруулахад ядуурлын түвшинг 6.5 ба 14.3 нэгж хувиар тус тус мэдэгдэхүйц өсгөхөөр байна. Хөдөө орон нутагт өрхийн нэг хүнд ногдох хэрэглээ 20 хувиар буурвал ядуурлын түвшин 16.9 нэгж хувиар нэмэгдэж 47.4 хувьд хүрэхээр байна. Эдгээр үр дүн нь өрхийн хэрэглээнд бага зэргийн цохилт өгөхөд ядуу хүн амын тоо мэдэгдэхүйц нэмэгдэхэд хүргэж болзошгүйг харуулсаар байна.

Зураг 1.5 Нэг хүнд ногдох хэрэглээний тархалт, 2020



Тайлбар: Зураг 1.5-д 20 удаа тооцоолсон утгын 20 өөр таамаглалын тархалтыг харуулав.

Зураг 1.6 Хэрэглээний өөрчлөлт дэх ядуурлын түвшний мэдрэмж




Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

1.3. СҮҮЛИЙН АРВАН ЖИЛИЙН ЯДУУРАЛ БА ТЭГШ БУС БАЙДЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Ядуурлыг бууруулах чиглэлээр 2010-аас 2014 онд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарч байсан бол 2016 оны эдийн засгийн хямралаас улбаалан ядуурал буурах хурд удааширсан байна. Ядуурлын түвшин 2010-аас 2014 оны эдийн засгийн өсөлтийн үед 38.8 хувиас 21.6 хувь болж ихээхэн буурчээ. Энэхүү гайхалтай ахиц дэвшлийн дараа эдийн засгийн уналтын улмаас 2014-өөс 2016 оны хооронд 21.6 хувиас 29.6 хувь болж ядуурал мэдэгдэхүйц нэмэгдсэн байна (Зураг 1.7). 2016-аас 2018 онд нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн өсөлт 4.3 хувьд хүрч, макро эдийн засаг сэргэсэн ч өрхийн хэрэглээний өсөлт буурч, хэрэглээний хуваарилалтын тэгш бус байдлаас шалтгаалан ялангуяа хот суурин газарт ядуурал буурах хурд удааширсан. Түүнчлэн коронавирусийн цар тахал нь ядуурлыг бууруулах боломжийг гацааж байна (Зураг 1.3). Үр дүнд нь ядуурлын түвшин 2016-аас 2020 онд 29.6 хувиас 27.8 хувь болж бага зэрэг буурчээ.


Ядуурлын гүнзгийрэлт нь ядуурлын түвшин буурах хурдтай уялдан өөрчлөгдөж байна. Ядуурлын гүнзгийрэлтийн индекс 2010 онд 11.5 хувь байсан бол 2014 онд 5.2 хувь болж ядуурлын түвшинтэй уялдан буурсан нь 2010-аас 2014 оны хооронд ядуу хүн амын дундаж хэрэглээний дутагдлыг хоёр дахин бууруулсан гэсэн үг юм (Зураг 1.8). Ядуурлын гүнзгийрэлт ийнхүү буурч байгаа нь ядуу хүн амын дундаж хэрэглээ үндэсний ядуурлын шугамд дөхсөнийг харуулж байгаа бөгөөд 2010-2014 онуудад ядуурлыг бууруулахдаа зөвхөн ядуу хүмүүсийг ядуурлын шугамаас дээш гаргаад зогсоогүй ядуурлын гүнзгийрэлтийг мөн бууруулж чаджээ. Эсрэгээрээ, 2016 онд ядуурлын хамралтын түвшин нэмэгдэхэд ядуурлын гүнзгийрэлт болон ядуурлын мэдрэмжийн индекс нэмэгдэж, түүнээс хойш бараг өөрчлөгдөлгүй зогсонги байдалд орсон байна.

Зураг 1.7 Ядуурлын түвшин, хувиар, ядуу хүн амын тоо, мянган хүнээр, 2010-2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020


Зураг 1.8 Ядуурлын гүнзгийрэлт ба мэдрэмж, хувиар, 2010-2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020


2010 онд байсан хот, хөдөөгийн ядуурлын түвшний ялгаа мэдэгдэхүйц багасч, хот суурин газарт ядуурал илүү төвлөрөх хандлагатай болжээ. 2010-аас 2020 оны хооронд ядуурлын түвшин хот, хөдөөд аль алинд нь буурсан ч хот суурин газарт буурах хурд нь мэдэгдэхүйц удааширсан байна. 2010 онд хөдөөгийн хүн амын бараг тал хувь нь ядуу амьдарч байсан бол 2020 онд арван хүн тутмын гурав болж буурчээ. Хөдөө орон нутгийн өрхүүдийн 60 гаруй хувь нь мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг учраас ялангуяа малчин өрхүүдийн дунд ядуурал буурах хандлага ажиглагдаж байна. Харин 2010-аас 2020 онд хотын ядуурал 33.2-оос 26.5 хувь болж 6.7 нэгж хувиар буурчээ. 2010-аас 2020 онд хөдөө орон нутагт ядуу хүн амын тоо 140 мянган хүнээр буурсан бол хот суурин газрын харьцангуй бага хэмжээтэй буурсан байв. Ядуурлын бууралтын хурд саарч байгаагаас гадна хот суурин газрын ядуу хүн амын тоо бага хэмжээтэй буурч байгаа нь хотжилт, ялангуяа хот суурин газрын хүн амын эзлэх хувь нэмэгдэж байгаатай холбоотой гэж үзэж болно. Тодруулбал, Улаанбаатар хотын хүн амын өсөлт 2010 оноос хойш жил бүр дунджаар 2.6 хувиар өссөн байна. Үр дүнд нь хот суурин газарт амьдарч буй ядуу хүн амын эзлэх хувь 2010 онд 55 хувь байсан бол 2020 онд 64 хувь болж тасралтгүй өссөн байна (Зураг 1.10).

Зураг 1.9 Ядуурлын түвшин, хувиар, ядуу хүн амын тоо, мянган хүнээр, 2010-2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020


Зураг 1.10 Ядуу хүн амын дүнд эзлэх хувь, 2010-2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

Сүүлийн арван жилийн эхэн хагаст хүн амын хэрэглээний өсөлт өндөр ялангуяа ядуу хүн амд илүү таатайгаар хуваарилагдсан бол сүүлийн хагаст хэрэглээний өсөлт буурч, хуваарилалт тэгш бус болсон байна. 2010-аас 2014 онд хүн амын хэрэглээний жилийн дундаж өсөлт хүн амын хэрэглээний бүлэг бүрт жигд өндөр, улсын дундаж өсөлт 6.3 хувьтай байв (Зураг 1.11). Цаашилбал, өсөлт хамгийн ядуу өрхүүдэд харьцангуй таатай байсан. Хүн амын хамгийн ядуу 20 хувийн нэг хүнд ногдох хэрэглээний жилийн дундаж өсөлт 7.3 хувь, хамгийн чинээлэг 20 хувийн хэрэглээ 5.9 хувиар өсөж байжээ. Ерөнхийдөө, хөдөө орон нутагт хэрэглээний өсөлт ядуу хүн амд илүү таатай байсан бөгөөд хамгийн ядуу 20 хувийн хэрэглээний жилийн дундаж өсөлт хамгийн чинээлэг 20 хувийнхаас бараг 5 нэгж хувиар илүү байв. Харин 2016-аас 2020 онд хүн амын хэрэглээний жилийн дундаж өсөлт буурч, илүү жигд болж эхэлсэн. Тоо баримтаас харахад, хамгийн ядуу 20 хувьд хэрэглээний өсөлт хамгийн бага (0.3 хувь) байсан бол сүүлийн 80 хувьд багтах өрхүүдийн хэрэглээ 0.8-1.7 хувийн өсөлттэй байжээ.

Зураг 1.11 Хэрэглээний өсөлтийн хувь, хүн амын тэнцүү 5 бүлгээр, 2010-2014 ба 2016-2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

Хэрэглээний өсөлт нийт хүн амтай харьцуулахад ядуу хүн амд хэр өгөөжөө өгснийг хэмждэг үзүүлэлт болох өсөлтийн хүртээмж сүүлийн арван жилийн сүүл хагаст сөрөг утгатай болсон байна. Өсөлтийн хүртээмж нийт хүн ам болон хамгийн ядуу 40 хувийн хүн амын жилийн дундаж хэрэглээний өсөлтийн зөрүүгээр тодорхойлогддог (Дэлхийн банк, 2018а) хэмжигдэхүүн бөгөөд хэрэглээний өсөлт хэр шударга байгааг хянахад өргөн ашиглагддаг. Өсөлтийн хүртээмж 2010-аас 2014 оны хооронд эерэг байгаа нь хүн амын хамгийн ядуу 40 хувийн хэрэглээний жилийн дундаж өсөлт нийт хүн амынхаас илүү хурдацтай өссөнийг илэрхийлж байна (Зураг 1.12). Цаашилбал, хэрэглээний өсөлтийн хувийг харуулсан шинжилгээтэй (Зураг 1.11) уялдуулан үзэхэд 2016-аас 2020 онд хэрэглээний жилийн дундаж өсөлт мэдэгдэхүйц буурч, хүртээмж тэгш бус болсон нь өсөлтийн хүртээмжийг сөрөг гарахад хүргэсэн байв (-0.4 нэгж хувь).

Зураг 1.12 Нийт хүн амын болон хамгийн ядуу 40 хувийн хэрэглээний жилийн дундаж өсөлтийн хурд, хэрэглээний өсөлтийн хүртээмж




Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

Тайлбар: Өсөлтийн хүртээмж = Shared Prosperity Premium

Зүүн Ази, Номхон Далайн (ЗАНД) хөгжиж буй бүс нутагт 2010 оны үед өсөлтийн хүртээмж эерэг үр дүнтэй байв. Зураг 1.13-т ЗАНД-н бүс нутгийн зарим улс орнуудын сүүлийн арван жилийн эхний ба сүүлийн хагасын өсөлтийн хүртээмжийг харьцуулан харуулав. Өрхийн судалгааг тогтмол явуулдаг ЗАНД-н бүс нутгийн зургаан орны сүүлийн арван жилийн хэрэглээний/орлогын дундаж өсөлтийн хүртээмж эерэг үр дүнтэй байжээ⁵. Тодруулбал, сүүлийн арван жилийн эхний хагаст өсөлтийн хүртээмж 0.3-аас (Индонез) 4.8 (Хятад) нэгж хувийн хооронд эерэг байсан нь энэ зургаан улсын ядуу хүн амд өсөлтийн хүртээмж таатай нөлөө үзүүлснийг харуулж байв. Цаашилбал, арван жилийн сүүлийн хагаст ихэнх улс оронд ядуусынхаа амьжиргааг дэмжсэн өсөлт үргэлжилсэн байхад зөвхөн Монгол, Вьетнам хоёрт өсөлтийн хүртээмж сөрөг болсон байна. Түүнчлэн ЗАНД-н бүс нутгийн бусад орнуудын хамгийн ядуу 40 хувийн хэрэглээний/орлогын дундаж өсөлт энэ хугацаанд 4.7 хувь байсан бол Монголд 0.6 хувь байгаа нь сүүлийн жилүүдэд ядуурлын бууралт зогсонги байдалд орсныг харуулж байна.

⁵ Өсөлтийн хүртээмж гэдэг нь хүн амын хамгийн ядуу 40 хувийн хэрэглээний/орлогын өсөлтийн хувиар тодорхойлогдоно.

Зураг 1.13 Өсөлтийн хүртээмжийн бүс нутгийн харьцуулалт




Эх үүсвэр: ӨНЭЭС 2010-2020, ЗАНД бүс нутгийн өрхийн судалгаануудыг уялдуулсан өгөгдлөөс гаргасан зохиогчийн тооцоо

Ядуурлын өөрчлөлтийг хэрэглээний өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваан үзэхэд ядуурлын бууралтад хэрэглээний тэгш хуваарилалтаас илүү өсөлт гол нөлөө үзүүлсэн байв.

Өсөлт-тэгш бус байдлын бүтцийн шинжилгээгээр (Датт, Раваллион нар 1992) ядууралд гарсан өөрчлөлт нэг хүнд ногдох дундаж хэрэглээний өсөлт, хэрэглээний хуваарилалтын алинаас илүү хамааралтай болохыг шинжилдэг. Зураг 1.14-т хэрвээ 2010-аас 2014 онд хэрэглээний өсөлтийг хэрэглээний бүлэг бүрт тэгш хуваарилсан бол ядуурал 15-аас дээш нэгж хувиар буурах боломжтой байсныг харуулсан. Энэ хугацаанд хэрэглээний өсөлт ядуурлыг бууруулах гол хөдөлгөгч хүч байсан хэдий ч түүний хуваарилалт нь ядуурлын түвшинг улсын хэмжээнд 1.9 нэгж хувиар, хөдөөд 4.8 нэгж хувиар нэмж бууруулсан бөгөөд ялангуяа хөдөөгийн ядуу өрхүүдэд илүү чиглэсэн хандлагатай байжээ. Нөгөө талдаа, 2016-аас 2020 онд чинээлэг өрхүүдийн хэрэглээний өсөлт нэмэгдсэн ч нийт өрхүүдийн хэрэглээний өсөлт буурсан нь ядуурлыг дорвитой буулгасангүй. Онцолбол, энэ хугацаанд улсын дундаж хэрэглээний өсөлт хот, суурин газрын хэрэглээний өсөлтөөс шууд хамааралтай байв. Хэрэв хэрэглээний өсөлт хүн амын бүлэг бүрт тэгш хуваарилагдсан бол 2016-аас 2020 онд ядуурал улсын хэмжээнд 2.5 нэгж хувиар буурах байсан ч хотын өрхүүдийг дэмжсэн тэгш бус хуваарилалт нь ядуурлыг 0.7 нэгж хувиар өсөхөд хүргэсэн байна.

Зураг 1.14 Ядуурлын өөрчлөлтийг хэрэглээний өсөлтийн болон тэгш бус байдлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь




Эх үүсвэр: ӨНЭЭС 2010-2020


Ядуурлын өөрчлөлтийн өөр нэг бүтцийн шинжилгээ болох орлогын бүрэлдэхүүн⁶ хэсгээр задлах аргаар сүүлийн арван жилийн сүүл хагаст хүн амын орлогын өсөлт хэрэглээний өсөлтөд үзүүлэх нөлөө бага байснаас шалтгаалан ядуурал буурах хурд саарсан байна. 2010-аас 2014 оны хооронд цалингийн болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын өсөлт, мөн нийгмийн шилжүүлгийн нэмэгдлүүд нь ядуурлыг бууруулахад хамгийн их хувь нэмэр оруулсан. Орлогын эх үүсвэрийн эдгээр гурван бүрэлдэхүүн хэсэг нийлээд энэ хугацаанд ядуурлын түвшинг 17 нэгж хувиар бууруулсан (Зураг 1.15). 2016-аас 2020 оны хооронд одоо хэрэгжиж буй нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн (хүүхдийн мөнгө, хүнсний талон) тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн нь ядуурлын бууралтад 5-аас дээш нэгж хувиар нөлөөлсөн. Гэтэл эсрэгээрээ, энэ хугацаанд цалингийн болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын өсөлт ядуурлыг бууруулахад чухал түлхэц болох байсан хэдий ч тэдний оруулсан хувь нэмэр үнэмлэхүй хэмжээгээр багасч, орлогын өсөлт хэрэглээний өсөлт рүү шилжих нь бага байжээ. Хэрэв хэрэглээ орлоготой ижил хурдтай өссөн бол 2016-аас 2020 оны хооронд ядуурал 9 орчим нэгж хувиар буурах байсныг бүтцийн шинжилгээ харуулж байна.

Зураг 1.15 Ядуурлын өөрчлөлтийг орлогын бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах нь

(а) 2010-2020



(б) 2010-2014, 2016-2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

Тайлбар: Хэрэглээний ахиу хандлага нь хэрэглээ болон орлогын хоорондын хамаарлын нөлөөллийг илэрхийлдэг. Өрхийн хэмжээ нь нэг өрхөд ногдох хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин болон ажил эрхэлж буй насанд хүрэгчдийн эзлэх хувийн жингийн ядууралд үзүүлэх цэвэр нөлөөг харуулна.


Нийгмийн шилжүүлэг нь 2010-аас 2020 оны хооронд ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн хэдий ч зорилтот хөтөлбөрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх нь ядуурлыг бууруулахад оруулах хувь нэмрийг илүү нэмэгдүүлэх боломжтой байсан. Сүүлийн жилүүдэд ядуу, эмзэг бүлгийнхэнд хүрэх нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн цар хүрээг өргөжүүлэх чиглэлээр томоохон ахиц гарсан. 2010-аас 2018 оны хооронд нэг хүнд ногдох тэтгэмжийн хэмжээ хүн амын хамгийн доод 40 хувьд 33 хувиар, дээд 60 хувьд 16 хувиар өссөн байна. Гэвч өнөөгийн байдлаар хэрэгжсэн зарим хөтөлбөрүүд дан зорилтот бүлгийг эсвэл бүх нийтийг хамруулсан шинжтэй, үр ашиггүй байгаа нь онцолж авч үзэх асуудал мөн юм.

⁶ Энэхүү тайланд ядуурлын өөрчлөлтийн бүтцийн шинжилгээг Баррос (2006) болон Азеведо (2013) нарын боловсруулсан аргачлалын дагуу хийсэн болно. Энэ арга нь тархалтыг бүхэлд нь эсрэгцүүлдэг бөгөөд хүн ам зүйн үзүүлэлтүүд болон хүн амын хөдөлмөр эрхлэлтийн орлого (цалин хөлсний, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого), хөдөлмөр эрхлэлтийн бус орлого (нийгмийн шилжүүлэг, мөнгөн гуйвуулга, хөрөнгийн орлого гэх мэт) бүрийг тогтмол гэж үзэн нэг нэгээр нь өөрчлөх замаар ядуурлыг бууруулахад оруулсан хувь нэмрийг тоон байдлаар тодорхойлох боломж олгодог. Энэ арга нь өмнөх жилүүдийн нөлөөнөөс зайлсхийхийн тулд бүрэлдэхүүн хэсэг бүрийн ядуурлын өөрчлөлтөд оруулсан хувь нэмрийг олохдоо Шапли-Шаррокийн тооцооллыг хийдэг. Задлан шинжлэх аргачлалын дэлгэрэнгүй мэдээллийг Азеведо (2013) болон Иншаусте (2014) нараас харна уу.

Тухайлбал, 2020 онд хүн амын хамгийн амьжиргаа багатай 40 хувийн өрхийн 20 орчим хувь нь хүүхэдтэй өрхүүдэд сар бүр олгодог хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдаж чадаагүй байна. Мөн 2020 онд нийт хүүхдийн мөнгөн тэтгэмжийн тал орчим хувь нь амьжиргаа сайтай эхний 60 хувьд багтсан өрхүүдэд олгогдсон байна. Нийгмийн шилжүүлэг хамгийн их хэрэгцээтэй ядуу, эмзэг бүлгийнхэнд чиглэснээр ядуурал буурах болон нийгмийн шилжүүлгийн үр нөлөө нэмэгдэх ач холбогдолтой юм.


Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт буурсан нь сүүлийн арван жилийн сүүл хагаст ядуурлын буурах хурдыг удаашруулсан. Ядуурлын мэдрэмжийн өсөлт нь нэг хүнд ногдох хэрэглээний өсөлт болон ДНБ-ий өсөлт ядуурлын бууралтад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарладаг үзүүлэлт юм. 2010-аас 2014 оны хооронд нэг хүнд ногдох бодит ДНБ болон хувийн хэрэглээ жилд 10 хувиар өсч, ядуурлын түвшний жилийн дундаж өөрчлөлт хасах 13.7 хувь байв (Зураг 1.16). Өөрөөр хэлбэл, нэг хүнд ногдох бодит ДНБ болон хувийн хэрэглээ нэг хувиар өссөн нь ядуурлын түвшинг тус тус 1.4 ба 1.3 хувиар бууруулсан байна. Харин эсрэгээрээ 2016-2020 оны хооронд ДНБ-ий өсөлт огцом буурсан (жилд ойролцоогоор 1 хувь орчим) хэдий ч хувийн хэрэглээний өсөлт 5.6 хувьтай байжээ. Энэ хугацаанд ядуурлын түвшин дунджаар 1.6 хувиар буурсан нь ядуурлын мэдрэмжийн өсөлт буурахад хүргэсэн. Ядуурлын мэдрэмжийн өсөлт нь нэг хүнд ногдох ДНБ-ий хувьд -1.5 хувь, нэг хүнд ногдох хувийн хэрэглээний хувьд -0.3 хувь байв. Эдгээр үр дүн нь 2016-2020 оны эдийн засгийн бага өсөлт ядуурлыг зогсонги байдалд оруулсныг харуулж байна. 2016-2020 онд ДНБ-тэй харьцуулахад хувийн хэрэглээний өсөлт хурдацтай байсан нь тэдний дунд ядуурлын өсөлтийн мэдрэмжийн ялгаа бий болоход нөлөөлсөн ба Бүлэг 1.1-д дурдсанчлан ӨНЭЗС-г ашигласан хэрэглээ дутуу мэдээлэгдсэн мөн 2020 оны хэрэглээг орлуулан тооцсон зэрэг нь нөлөөлсөн байх магадлалтай⁷.

Зураг 1.16 Өсөлт ба ядуурлын жилийн дундаж бодит өөрчлөлт



Эх үүсвэр: YCX, ӨНЭЗС 2010-2020

Зураг 1.17 Ядуурлын мэдрэмжийн өсөлт өөрчлөлт



Эх үүсвэр: YCX, ӨНЭЗС 2010-2020

Тэгш бус байдал 2010-2020 оны хооронд харьцангуй тогтвортой байв. Хүснэгт 1.1-д харуулснаар, хотын Жини коэффициент 2010 онд 32.9-өөс 2020 онд 33.4 болж бага зэрэг өссөн бол хөдөөд 2010 онд 31.7 байсан нь 2020 онд 28.6 болж буурсанд амьжиргаа багатай бүлгийн хэрэглээний эрчимтэй өсөлт хөшүүрэг болсон байна. Энэ нь улсын түвшинд Жини коэффициентийг сүүлийн арван жилийн хугацаанд 32-33 нэгжийн хооронд тогтвортой байлгажээ. Ерөнхийдөө манай улсын тэгш бус байдлын индекс хөрш зэргэлдээ орнуудаасаа харьцангуй бага байна (Зураг 1.18).


⁷ Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС) болон үндэсний тооцоо хооронд өрхийн хэрэглээний зөрүү ихсэж байна. 2010 онд үндэсний тооцооны хувийн хэрэглээний 80 хувийг өрхийн хэрэглээ эзэлж байсан бол 2020 онд 51 хувь болж буурчээ. ӨНЭЗС болон үндэсний тооцоо хооронд ижил төстэй хандлага ажиглагдсан ч өрхийн хэрэглээний түвшин, өсөлтийн хурд өөр байна. Тухайлбал, 2016-аас 2020 оны хооронд жилийн хэрэглээний өсөлт ӨНЭЗС-нд ердөө 1.0 хувь байсан бол үндэсний тооцоонд 5.6 хувь байсан.

Хүснэгт 1.1 Тэгш бус байдлын чиг хандлага, 2010-2020

	2010	2012	2014	2016	2018	2020
Жини коэффициент						
Улсын дундаж	33.0	33.8	32.0	32.3	32.7	32.3
Хот	32.9	34.2	32.9	33.1	34.0	33.4
Хөдөө	31.7	30.6	28.3	29.6	29.2	28.6
Тейлийн индекс						
Улсын дундаж	19.3	20.0	18.6	19.0	19.2	17.4
Хот	19.3	20.6	19.5	20.0	20.6	18.6
Хөдөө	17.5	16.2	14.6	15.4	15.1	13.6

Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

Зураг 1.18 Хөрш зэргэлдээ хөгжиж буй орнуудын Жини коэффициент



Эх үүсвэр: ӨНЭЗС 2020, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд


Тайлбар: Малайз, Филиппин улс Жини коэффициентийг хэмжихдээ өрхийн нэг хүнд ногдох орлогыг ашигласан

1.4. ЯДУУРЛЫН ОРОН ЗАЙН ЯЛГАА

Ядуурал өндөртэй бүс нутгуудад ядуурал буурч, ядуурал багатай бүс нутгуудад зогсонги байдалд байснаар ядуурлын түвшний ялгаа бүс нутагт цаг хугацааны явцад багасчээ. Таван бүсийн хувьд (Баруун, Хангай, Төв, Зүүн болон Улаанбаатар) ядуурлын түвшин 2010 оноос хойш буурсан боловч ядуурлын бууралтын хурд бүс нутгуудад ихээхэн ялгаатай байна (Зураг 1.19). Хүн амын талаас илүү хувь нь ядуу амьдарч байсан Баруун болон Хангайн бүс нутаг 2010 онд хамгийн ядуу байв. Гэсэн хэдий ч дээрх хоёр бүс нутаг ядуурлыг бууруулах чиглэлээр гайхалтай ахиц гаргаж, 2014 он гэхэд ядуурлын түвшин нь 25-26 хувь хүртэл буурчээ. Зүүн бүс нь 2010 онд гурав дахь ядуу бүс байсан ба 2016 оны эдийн засгийн хямралын үеэр хамгийн хүнд уналтад орж, хамгийн ядуу бүс болсон. Харин 2016 оноос хойш Зүүн бүсийн ядуурал бусад бүсүүдтэй харьцуулахад хурдацтай буурч, ядуурлын түвшин нь 2016 онд 44 хувь байсан бол 2020 онд 33 хувь болжээ. Эсрэгээрээ, ядуурлын түвшин багатай бүс нутаг буюу Улаанбаатар болон Төвийн бүсийн ядуурлын бууралтын түвшин 2016 оноос хойш зогсонги байдалд орсон. Үр дүнд нь сүүлийн арван жилд орон зайн ядуурлын ялгаа нийт бүсийн хэмжээнд мэдэгдэхүйц багассан байна.


Улаанбаатар хотод ядуу хүн ам улам ихээр төвлөрч байна (Зураг 1.20). Зүүн бүс нутагт ядуурал хамгийн өндөр байгаа боловч улсын хэмжээнд нийт хүн амын хамгийн бага хувийг (7 хувь) эзэлдэг тул нийт ядуу хүн амын дөнгөж 8 хувийг эзэлж байна. Харин Баруун болон Хангайн бүсүүдийн хувьд ядуурлын түвшин төдийгүй ядуу хүн амынхаа эзлэх хувийг тодорхой хэмжээнд бууруулж чадсан. Баруун болон Хангайн бүсийн ядуу хүн амын эзлэх хувь 2010 онд 18 ба 27 хувь байсан бол 2020 онд 14 ба 21 хувь болж буурчээ. Улаанбаатар хотын хувьд, хотжилтын түвшин өндөр байгаа нь ядуурлын түвшинг бууруулахад хүндрэл болж байгаа нь нийт ядуу хүн амд эзлэх Улаанбаатар хотын ядуу хүн амын тоо 2010 онд 35 хувь байснаа өсөж 2020 онд 43 хувь болж нэмэгдсэнтэй холбогдож байна.

Зураг 1.19 Ядуурлын түвшин, хувиар



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

Зураг 1.20 Ядуу хүн амын дүнд эзлэх хувь




Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020


Сүүлийн арван жилийн эхний хагаст бүх суурьшил, бүсийн хэмжээнд ядуурал буурч, ахиц гарсан бол сүүлийн жилүүдэд нийслэл хотын ядуурлын бууралт зогсонги байдалд орсон байна. Газар зүйн байршлаар задлан шинжлэх арга нь (Раваллион болон Хуппи, 1991) ядуурлын бууралтад бүс хоорондын хүн амын шилжилт хөдөлгөөн хэр нөлөө үзүүлсэнийг тодорхойлдог. Зураг 1.21-т газар зүйн байршлаар задлан шинжилсэн үр дүнг хот, хөдөө (а) болон бүсээр (б) харуулав. 2010-аас 2014 оны хооронд улсын хэмжээнд ядуурлын түвшин буурахад газар зүйн бүх байршил, бүс нутаг нөлөөлсөн ба Улаанбаатар хот (6.4 нэгж хувь) болон Хангайн бүс (5.2 нэгж хувь) хамгийн их нөлөө үзүүлжээ. 2016-2020 онд ядуурлын түвшин буурахад бүх суурьшил, бүс нутгийн нөлөө бага, харин хамгийн ядуу бүсийн (Зүүн бүс) нөлөө их байж, 2016-аас 2020 оны хооронд нийт ядуурлын бууралтын 40 гаруй хувийг бүрдүүлсэн байна. Энэ хугацаанд ядуурлыг бууруулахад нөлөө үзүүлээгүй цорын ганц бүс нь Улаанбаатар хот байв.

Зураг 1.21 Ядуурлын газар зүйн байршлын задлан шинжилгээ

(а) Хот, хөдөөгөөр



(б) Бүсээр




Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020


Ядуурлын түвшин аймаг хооронд харьцангуй ялгаатай байна. Зураг 1.22-т ядуурлын түвшинг аймгаар харуулав. Ядуурлын түвшин Говь-Алтай, Говьсүмбэр аймагт 2020 онд хамгийн өндөр, аймгийн нийт хүн амынх нь 42.4 ба 39.8 хувь ядуу байгаа бол уул уурхайн баялаг ихтэй Өмнөговь аймагт ядуурлын түвшин хамгийн бага буюу хүн амынх нь 16.4 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна. Зүүн болон Баруун бүсийн аймгуудад ядуурлын түвшин өндөр байгаа бол Улаанбаатар, Төвийн бүсийн зарим аймгуудад (Өмнөговь, Дундговь, Дорноговь) харьцангуй бага байна. Ядуурлын түвшин хамгийн өндөр (Говь-Алтай, Говьсүмбэр) болон хамгийн бага (Өмнөговь) аймгуудын хоорондох ядуурлын түвшний ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолтой байна. Харин бусад олон аймгуудын хоорондох ядуурлын түвшний ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолгүй байгаа нь аймгийн хэмжээнд судалгааны түүврийн хэмжээ бага мөн аймаг хоорондын онцлог ялгаатай байдлаас үүдэлтэй байна. Ядуурлын газар зүйн тархалтад зөвхөн ядуу хүн амын тооноос гадна нийт хүн амын тоо нөлөөлсөн. Тухайлбал, Говь-Алтай, Говьсүмбэр аймагт ядуурлын түвшин хамгийн өндөр байгаа ч, хүн ам цөөтэй учраас нийт ядуу хүн амын 2.6 ба 0.8 хувь нь тус тус ногдож байна.

Зураг 1.22 Ядуурлын түвшин, аймгаар, хувиар


(а) Ядуурлын түвшин, аймгаар, 2020



(б) Ядуурлын түвшин, аймгаар, 2018-2020



(в) Ядуу хүн амын дүнд эзлэх хувь, 2020




Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2020

1.5. МОНГОЛ УЛС БОЛОН ОЛОН УЛСЫН ЯДУУРЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын ядуурлын түвшинг олон улсын ядуурлын шугам ашиглан олон улстай буюу тухайлбал, Ази Номхон Далайн бүс нутгийн улсуудтай харьцуулах боломжтой. Сүүлийн арван жилийн сүүл хагаст хөрш зэргэлдээ зарим улсууд ядуурлынхаа түвшинг тогтвортой бууруулан ахиц гаргаж байсан бол манай улсын ядуурлын түвшингийн бууралт удааширсан. Ядуурлын түвшинг олон улс хооронд харьцуулах боломжтой болгохын тулд Дэлхийн банкнаас олон улсын хэмжээнд харьцуулж болох гурван өөр ядуурлын шугамыг нэвтрүүлсэн (Шигтгээ 1.2-ийг үзнэ үү). Зураг 1.23-т харуулснаар, Монгол Улс нэн ядуурлыг бараг устгасан (2011 оны худалдан авах чадварын паритетаар тооцсон 1.9 ам.доллар) ба дунджаас доогуур орлоготой орнуудын ядуурлын түвшин харьцангуй бага (2011 оны ХАЧП-аар тооцсон 3.2 ам.доллар) байна. Монгол Улс одоогоор нэг хүнд ногдох ҮНО-оор хэмжигдсэн дунджаас доогуур орлого, эдийн засагтай орнуудын дээгүүр хэсэгт байна. Мөн дунджаас дээгүүр орлоготой улс болох эрмэлзлэлтэй байгаа бөгөөд дунджаас дээгүүр орлоготой орнуудын ядуурлын түвшинд (2011 оны ХАЧП-аар тооцсон 5.50 ам.доллар) Монгол Улсын ядуурлын түвшин (2011 оны ХАЧП-аар тооцсон 5.59 ам.доллар) хүрэхэд ойрхон байгаа нь дунджаас дээгүүр орлоготой улсад хамаарах боломжтойг харуулж байна⁸. Гэсэн хэдий ч, 2020 онд нийт хүн амын 26.9 хувь нь 5.50 ам.долларын ядуурлын шугамаас доогуур буюу ядуу хэвээр байна. Эдгээр ядуурлын тооцоог хийхдээ Монгол Улсын нэг хүнд ногдох ДНБ-ээр хэмжигддэг орлогын түвшинг авч үзэн олон улсын ядуурлын шугам ашигласан ба ингэснээр бүс нутгийн хөрш орнуудтай харьцуулахад тохиромжтой болсон (Зураг 1.24). Бүс нутгийн хэмжээнд өрхийн судалгааг тогтмол хийдэг улс орнууд сүүлийн арван жилийн эхний хагаст дунджаас доогуур ба дээгүүр орлоготой орнуудын ядуурлын түвшингээ эрс бууруулж чадсан. Гэвч, 2016 оны эдийн засгийн уналт нь Монгол Улсын ядуурлын түвшин буурахад саад болсон бол Тайландаас бусад улс орнууд Ковид-19 цар тахал гарах хүртэл ядуурлаа бууруулахад тогтвортой ахиц гаргасан.

Зураг 1.23 Монгол Улсын ядуурлын түвшин (ХАЧП-аар тооцсон 1.90 ам.доллар, 3.20 ба 5.50 ам.долларын ядуурлын шугам), 2010-2020



Эх үүсвэр: ӨНЭЭС 2010-2020, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд

Тайлбар: ХАЧП-худалдан авах чадварын паритет

⁸ Монгол Улсын үндэсний ядуурлын шугамыг нэг хүнд ногдох ҮНО эсвэл нэг хүнд ногдох ДНБ-ийг ХАЧП-ийн ам.доллараар илэрхийлвэл бүс нутаг дахь зарим улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тухайлбал, Индонезийн үндэсний ядуурлын шугам (2021 онд) 2011 оны ХАЧП 4.1 доллар, Вьетнам улсын ядуурлын шугам (2018 онд) 2011 оны ХАЧП 3.2 доллар байсан бол Монголын үндэсний ядуурлын шугам (2020 онд) 2011 оны ХАЧП 5.59 доллар байна.

Шигтгээ 1.2 Олон улсын ядуурлын хэмжүүр


Дэлхийн банк, НҮБ болон бусад хөгжлийн байгууллагууд дэлхий нийтийн ядуурлын түвшинг хянаж үзэхийн тулд олон улсын ядуурлын шугамыг тогтоож өгдөг. Дэлхийн хэмжээнд ядуурлыг хэмжихийн тулд нийтлэг ойлголт тодорхойлолт хэрэгтэй тул худалдан авах чадварын паритет (ХАЧП) болон олон улсын ядуурлын шугамыг ашиглаж хэрэглээг олон улсад харьцуулах боломжтой болгодог. Олон улсын туйлын ядуурлын шугамыг өдрийн 1.90 ам.доллар (ХАЧП, 2011) байхаар тогтоохдоо 1990-ээд оны 15 ядуу орны үндэсний ядуурлын шугамын дундажаар авсан. Түүнчлэн орлогоор нь ангилсан буюу дунджаас доогуур болон дээгүүр орлоготой орнуудын ядуурлын шугамыг нэг хүнд ногдох ҮНО-д үндэслэхээр тогтоосон ба жишиг утгууд нь дунджаас доогуур орлоготой орнуудын хувьд 3.20 ам.доллар (ХАЧП, 2011) бол дунджаас дээгүүр орлоготой орнуудын хувьд 5.50 ам.доллар (ХАЧП, 2011) бөгөөд эдгээр ядуурлын шугам нь эдийн засаг,

хөгжлийн түвшний хувьд Зүүн Ази Номхон далайн бүс нутгийн олон оронд хамаатай. Мөн, дэлхийн хэмжээнд үнийн түвшний зөрүү өөрчлөгдөхийн хэрээр үнийн өөрчлөлтийг тусгахын тулд олон улсын ядуурлын шугамыг үе үе шинэчилэх хэрэгтэй болдог. Дэлхийн банк 2022 оны тавдугаар сард бүх орлогын ангилалд хамаарах олон улсын ядуурлын шугамаа 2017 оны үнийг (ХАЧП, 2017) ашиглан 2022 оны намар шинэчлэнэ хэмээн зарласан.


Олон улсын ядуурлын шугам нь улс хоорондын харьцуулалт хийх, дэлхийн нийтийн болон бүс нутгийн ядуурлыг хянаж үзэхэд хэрэгтэй. Монгол улсын үндэсний ядуурлын шугам нь өөрийн үндсэн хэрэгцээнд тулгуурласан бөгөөд улсын түвшинд бодлого тогтоох эсвэл ядуу хүн амдаа анхаарлаа илүү чиглүүлэхэд нь тохирсон.

Зураг 1.24 Дунджаас доогуур болон дээгүүр орлоготой орнуудын ядуурлын түвшингийн бүс нутгийн чиг хандлага

(а) Дунджаас доогуур орлоготой орнуудын ядуурлын түвшин (2011 оны ХАЧП-аар тооцсон 3.20 доллар)



(б) Дунджаас дээгүүр орлоготой орнуудын ядуурлын түвшин (2011 оны ХАЧП-аар тооцсон 5.50 доллар)




Эх үүсвэр: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд

Сүүлийн арван жилийн хугацаанд бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад Монгол Улс эдийн засгийн баталгаат байдлаа болон дундаж давхаргын хүн амаа нэмэгдүүлэхийн төлөө хичээсээр ирсэн. Дэлхийн банкнаас гаргасан (20186) тодорхойлолтын дагуу өрхүүдийг туйлын ядуу, ядуу, эмзэг, эдийн засгийн хувьд баталгаажсан болон дундаж орлоготой гэсэн таван бүлгээр ангилж болно⁹. 2010 оны байдлаар бүс нутгийн улс орнууд дундаа Монгол Улс хамгийн их буюу хүн амынх нь бараг 3 хүн тутмын 2 нь эдийн засгийн хувьд баталгаатай болон дундаж орлоготой ангилалд багтаж байна.

Гэсэн хэдий ч, сүүлийн арван жилийн хугацаанд бүс нутгийн олон улс орон ядуу, эмзэг бүлгээ бууруулах тал дээр мэдэгдэхүйц ахиц гаргаж, эдийн засгийн хувьд баталгаатай болон дундаж орлоготой хүн амаа нэмэгдүүлжээ. Тухайлбал, 2012 онд Хятадын хүн амын эдийн засгийн хувьд баталгаатай болон дундаж орлоготой хүн амын эзлэх хувь нь 56 байсан нь Монголынхоос (2010) 7 хувиар бага байсан ч, 2019 онд 84 хувьд хүргэжээ. Түүнчлэн, 2010 онд Монгол Улсын эдийн засгийн хувьд баталгаатай болон дундаж орлоготой хүн ам Вьетнам улсаас 10 нэгж хувиар өндөр байв. Харин сүүлийн арван жилийн сүүл гэхэд Вьетнам улс ядуу болон эмзэг бүлгийнхээ эзлэх хувийг амжилттайгаар хоёр дахин бууруулж, эдийн засгийн хувьд баталгаатай болон дундаж орлоготой бүлэгт хамаарах хүн ам нь ойролцоогоор 59 ба 19 хувь болсон байна.

Зураг 1.25 Бүс нутгийн улс орнуудын хүн амын бүлэгт эзлэх хувь, хандлага



Эх үүсвэр: ЗАНД бүс нутгийн өрхийн судалгаануудыг уялдуулсан өгөгдлөөс гаргасан зохиогчийн тооцоо


⁹ Эдийн засгийн ангиллыг (нэг хүнд ногдох өдөр тутмын хэрэглээний зардлаар, 2011 оны худалдан авах чадварын паритет ханшаар) дараах байдлаар тодорхойлсон: туйлын ядуу – 1.90 ам.доллараас бага; ядуу – 1.90-3.20 ам.долларын хооронд; эмзэг – 3.20-5.20 ам.долларын хооронд; эдийн засгийн хувьд баталгаажсан – 5.50-15.00 ам.долларын хооронд; дундаж орлоготой – 15.00 ам.доллараас дээш. Эдгээр босго хэмжээг бүс нутгийн хэд хэдэн улс орны панел өгөгдлийг ашиглан тооцсон бөгөөд ядуурлын дунд шугамыг илэрхийлэх (2011 оны худалдан авах чадварын паритет 3.20 ам.доллар) буюу тухайн өрхийн доод ангилалд орох магадлал 10 хувиас бага байх түвшин юм. Эмзэг бүлгийнхэн ядуурлын дунд шугамаас (3.20 ам.доллар) дээгүүр байгаа ч ядуу ангилал руу унах магадлал 10 хувиас дээш байна. Эдийн засгийн хувьд баталгаатай бүлгийнхэн ядуу ангилал руу унах аюулгүй боловч эмзэг бүлэг рүү орохгүй байх баталгаагүй байгаа бол дундаж орлоготой бүлэг нь эдийн засгийн хувьд илүү баталгаатай бөгөөд эмзэг бүлэг рүү орох магадлал багатай байна.

1.6. ЯДУУРЛЫН МӨНГӨН БУС ХЭМЖИГДЭХҮҮН

Ядууралд мөнгөн хэлбэрийн хэмжүүрээс гадна өөр олон хэмжүүр байдаг. Ядуурлыг тооцдог уламжлалт арга нь өрхийн хэрэглээ эсвэл орлогод суурилж тооцдог буюу амьжиргааг мөнгөн хэлбэрээр илэрхийлдэг. Гэхдээ ганц мөнгөн хэлбэрээр тооцох нь ядуурлын зураглалыг бүрэн илэрхийлж чаддаггүй. Иймд мөнгөн бус үзүүлэлт буюу хүний хөгжил, өрхийн суурь үйлчилгээний хүртээмж зэрэг нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг авч үзэх нь өрхийн амьжиргааны гачигдлыг олон талаас нь үнэлэх чухал ач холбогдолтой.


Манай улс хүний хөгжлийн хувьд гайхалтай ахицтай байна. Тухайлбал, залуучуудын бараг 60 хувь нь дундаас дээш боловсрол эзэмшсэн ба бага насны хүүхдүүдийн хүн капиталын чадавхи өндөр байна. Бид бүс нутгийн бусад улс орнуудтай харьцуулахад боловсрол эзэмшилтээрээ тэргүүлж байна. 55 ба түүнээс дээш насны таван хүн тутмын нэг нь их дээд сургууль эсвэл түүнтэй адилтгах түвшний боловсролтой бол 17 хувь нь боловсролгүй болон бага боловсролтой байна (Зураг 1.26). Харин 25-35 насны залуучууд илүү дээд боловсрол эзэмшсэн байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн 40 орчим хувь, эмэгтэйчүүдийн 60 орчим хувь нь их, дээд сургууль төгссөн эсвэл түүнтэй адилтгах түвшний боловсролтой байна. Түүнчлэн, 2020 онд их, дээд сургуульд хамрагдалтын нийт түвшин 59 хувьд хүрсэн (Зураг 1.27) бөгөөд манай улсын 25 ба түүнээс дээш насныхны дээд боловсролын түвшин (34 хувь) бүсийнхээ бусад улс орнуудаас хамгийн өндөр нь байна (Зураг 1.28). Дэлхийн банкны Хүний Капиталын Индекс (ХКИ) болон нэг хүнд ногдох ДНБ-ий хамаарлыг бүс нутгаар харьцуулж (Зураг 1.29) харуулав. ХКИ нь тухайн улс орны эрүүл мэнд, боловсролын өнөөгийн чиг хандлага нь өнөөдөр төрсөн хүүхдийн ирээдүйд хэвээр хадгалагдана гэж үзэн хүний капиталын түвшинг тодорхойлдог (Дэлхийн банк, 2019 он). Монгол Улсын хувьд ХКИ нь 0.61 байна. Энэ нь өнөөдөр төрсөн хүүхдүүдийн ирээдүйн чадавхийг харуулж байгаа ба тэдний 61 хувь нь ирээдүйд эрүүл саруул байна, мөн өндөр боловсрол эзэмшинэ гэдгийг илэрхийлж байна. Өнөөгийн эдийн засгийн хөгжлийн түвшингээс харахад Монгол Улс ХКИ-ээр дундаас доогуур орлоготой бусад орнуудаасаа дээгүүр буюу 118 орноос дөрөвдүгээрт жагсаж, араас нь Вьетнам, Украин, Узбекистан улсууд оржээ (Зураг 1.29). Дундаас дээш орлоготой орнуудтай харьцуулахад ч гэсэн Монгол Улсын ХКИ тэдний дундаж онооноос дээгүүр байна (0.56). Монгол Улс цаашдын нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглахад боловсролын чанар, тэгш байдлыг хангах, дундаас дээш боловсролын хүртээмжийг сайжруулах, тэр дундаа хөдөө орон нутгийн болон ядуу өрхийн хүүхдүүдэд мэргэжлийн боловсрол олгох зэрэг асуудлууд тулгамдаж байна.

Зураг 1.26 Боловсролын түвшин, нас, хүйсээр, хувиар




Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

Зураг 1.27 Их, дээд сургуульд хамрагдалтын түвшин, хувиар




Эх үүсвэр: ӨНЭЭС 2020

Зураг 1.28 25 ба түүнээс дээш насны хүмүүсийн дээд боловсролын түвшин, улсаар, хувиар



Эх үүсвэр: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд

Зураг 1.29 Хүний Капиталын Индекс, 2020



Эх үүсвэр: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд

Шигтгээ 1.3 Хөдөлмөрийн зах зээл дэх хүйсийн ялгаатай байдал

Манай улсад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ илүү боловсролтой боловч ажиллах хүчний оролцооны түвшин дэх хүйсийн ялгаатай байдал их байна. 2020 оны байдлаар 25-29 насны гурван эмэгтэй тутмын хоёр нь мэргэжлийн сургууль эсвэл их, дээд сургууль төгссөн байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд энэ нь 52 хувьтай байна. Энэ нь эрэгтэй хүүхдүүд хөдөлмөрийн зах зээлд эрт орж байгаатай зарим талаараа холбоотой бөгөөд тэр тусмаа хөдөө орон нутагт


дундаас дээш боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал байна. Мөн малчин өрхүүд хүүхдүүдээ багаас нь мал аж ахуйн ажилд татан оролцуулж байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд өндөр боловсролтой байх нь хөдөлмөрийн зах зээл дээр өндөр цалинтай ажилд орох боломж ихтэй гэсэн үг биш байна. Ажиллах хүчний судалгаагаар манай улсын эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь сүүлийн 10 жилийн хугацаанд 53-56 орчим хувьтай бараг хэвээрээ

байгаа бол эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 2018 онд 69.5 хувь болж дээд цэгтээ хүрсэн байна (Шигтгээ Зураг 1.1). 2020 онд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 51.8 хувь, эрэгтэйчүүдийнх 66.8 хувь байна.

Бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бага байгаа нь нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс гадна хүйсийн хэвшмэл байдал байгааг харуулж байна.

Эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс бага зэрэг өндөр байгаа ч хөдөлмөр эрхлэлтийн түвшинд хүйсийн ялгаа их байна. Ялангуяа энэ нь залуу үеийнхний дунд илүү их байна. Ажиллах хүчний оролцоо 25-29 насны эрэгтэйчүүдэд 86 хувь байгаа бол эмэгтэйчүүдийнх ердөө 69 хувь байна. Энэ нь нэг талаараа эмэгтэйчүүд цалин хөлстэй ажлын оронд гэрээхуйнажилхийж байгаатай холбоотой. Эмэгтэйчүүд хүүхдээ асран хүмүүжүүлэхээс гадна ахуйн бусад ажлыг хариуцдаг гол хүн нь байна. Ахуйн ажилтай холбоотой хүйсийн хэвшмэл ойлголт нь ихэвчлэн хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоог багасгаж, тэдний хөдөлмөр эрхлэх аливаа боломжид нь нөлөө үзүүлж байна (Дэлхийн банк, 2018). Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинд тэдний гэрлэлтийн байдал, хүүхэдтэй эсэх, амьдардаг байршил, боловсролын түвшин, орлого, нас болон нийгэм, эдийн засгийн орчин зэрэг өөр бусад хүчин зүйлс нөлөөлсөн байж болно (Angrist and Evans, 1998).

Шигтгээ Зураг 1.1. Ажиллах хүчний оролцоо, хүйсээр




Эх үүсвэр: АХС 2010-2020

Эмэгтэйчүүд ажил олж чадсан ч цөөн цагаар ажиллаж, бага цалин авдаг. Мөн гэр ахуйн ажилдаа их цаг зарцуулах шаардлагатай байдаг.

Хот болон хөдөөгийн эмэгтэй ажиллагчид сүүлийн 7 хоногт дунджаар 46 ба 56 цагийг цалинтай ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан бол эрэгтэйчүүд 50-иас дээш цаг ажилласан (Шигтгээ Зураг 1.2) байгаа нь цалин хөлсний хүйсийн зөрүүтэй байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Түүнчлэн эмэгтэйчүүд цалин багатай үйлчилгээний салбарт буюу ихэвчлэн улсын болон худалдааны салбарт ажиллах хандлагатай байдаг ба 2019 онд эмэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин (1,021 мянган төгрөг) эрэгтэй ажиллагчдын авч буй цалингаас (1,223 мянган төгрөг) 16 хувиар бага байжээ. Мөн ихэвчлэн хөдөө орон нутаг дахь эмэгтэйчүүд цалин хөлсгүй гэр ахуйн ажилд цаг их зарцуулах хандлагатай байна. Хөдөөгийн эмэгтэй ажиллагчид сүүлийн 7 хоногт дунджаар 33 цагийг цалин хөлсгүй гэр ахуйн ажилд зарцуулсан байгаа бол хөдөөгийн эрэгтэй ажиллагчид ердөө 18 цагийг гэр ахуйн ажилд зарцуулсан байна. Ерөнхийдөө эмэгтэйчүүд ихэнх цагаа хоол хийх, цэвэрлэгээ хийх, хүүхдээ асрахад зарцуулж байна.

Шигтгээ Зураг 1.2. Хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн цалинтай болон цалингүй ажилд зарцуулж буй дундаж хугацаа, хот, хөдөөгөөр




Эх үүсвэр: АХС 2019

Сүүлийн арван жилийн хугацаанд өрхүүд удаан эдэлгээтэй хөрөнгөтэй болох нь нэмэгдсэн байна. Мөн хөдөөд интернэт ашиглах боломж бусад суурьшилтай харьцуулахад хоцрогдсон хэвээр байна.

Сүүлийн арван жилийн хугацаанд нарны эрчим хүч ашиглан мөн төвийн шугам сүлжээгээр дамжуулан цахилгаан эрчим хүчинд холбогдох нь нэлээд сайжирсан тул өрхүүд гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй болох нь нэмэгджээ. Ялангуяа ядуу өрхүүдийн дунд энэхүү өсөлт илүү ажиглагдаж байна. 2018-аас 2020 оны хооронд хэрэглээний бүлгийн хамгийн ядуу 20 хувьд хамаарах өрхүүдийн хөргөгч, угаалгын машины эзэмшил 30 гаруй хувиар өссөн байна (Зураг 1.30). 2010 онд хамгийн ядуу бүлгийн өрхүүдийн гар утас ашиглах боломж нь бусад бүлгүүдээсээ бага байсан бол 2018 онд бараг ядуу өрх бүр дор хаяж нэг гар утастай байна. Гэвч интернэт ашиглах боломж орон зайн хувьд тэгш бус хэвээр байна. Улаанбаатар хотын өрхүүдийн 80 орчим хувь нь интернэт ашиглах боломжтой байхад хөдөөд ердөө 30 хувь нь интернэт ашиглах боломжтой байна. Энэ дижитал үйлчилгээнд тулгарч буй бэрхшээл нь хөдөө орон нутгийн хүүхдүүдийн суралцах, сайн ажилд орох, бүтээмжээ нэмэгдүүлэх боломжинд нь саад учруулж байж магадгүй юм.


Зураг 1.30 Удаан эдэлгээт бараа, эд хогшил болон интернэт

(а) 2010-2020 он




Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

(б) Хамгийн ядуу 20%-ийн удаан эдэлгээт бараа, эд хогшил эзэмшил, 2010, 2018



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010, 2018

(в) Интернэт ашиглах боломж, суурьшлаар, 2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2020


Малчид малынхаа тоо толгойг өсгөж, ямааны ноолуураа зарж түлхүү орлого олж байна. Мал аж ахуй нь хөдөөгийн малчдын амьжиргаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, мал аж ахуй нь тэдний хөдөлмөр эрхлэлт, орлого, хэрэглээний гол эх үүсвэр болохоос гадна өрхөд гэнэтийн бэрхшээл тулгарах үед даатгалын хэлбэрээр ашиглагдах боломжтой. 2020 онд улсын хэмжээнд малтай өрхийн хувь бага зэрэг буурч, 2010 онд 30 хувь байсан нь 27 хувь болсон хэдий ч алслагдсан хөдөөгийн өрхийн 90 хувь нь мал аж ахуй эрхэлсээр¹⁰ байна. Малын тоо толгойг хэрэглээний тэнцүү 5 бүлгээр харахад доод 20 хувьд хамаарах малчин өрхүүд сүүлийн арван жилийн хугацаанд мал сүргээ амжилттай өсгөсөн байна. 2010 онд доод 20 хувьд хамаарах малчин өрх дунджаар 142 толгой малтай байсан бол 2020 он гэхэд малын тоо толгой нь 227 болж өссөн байна. Энэхүү өсөлтийн үр дүнд ядуу малчин өрхүүд зах зээлд борлуулалт хийх боломжтой болох ба цаг агаарын гэнэтийн аюул, гамшигийг даван туулах чадвартай болдог¹¹. Мөн сүүлийн үед малын үнэ өссөн нь малчдын орлого нэмэгдэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн. Үүнтэй адил сүүлийн арван жилд ноолуурын үйлдвэрлэл болон ноолуурын үнэ тасралтгүй өсч байна. Малчид дунджаар 2010 онд 25 кг ноолуур үйлдвэрлэдэг байсан бол 2020 онд 46 кг болтол нэмэгдүүлжээ. Хэдийгээр ноолуурын үнэ хэлбэлзэж байсан ч малчид 2010-аас 2020 оны хооронд ноолуурын үйлдвэрлэлээс олох дундаж орлогоо 70 хувиар нэмэгдүүлж чадсан байна. Зах зээлд илүү сайн холбогдон төрөөс татаас, шилжүүлэг нэмэгдсэнээр малчдын амьжиргаа нэлээд сайжирч, тэдний ядуурлын хамралт 2010 онд 49 хувь байсан бол 2020 онд 29 хувь болж эрс буурчээ¹².

¹⁰ Судалгаа авах үед дор хаяж нэг малтай байсан өрхүүд.


¹¹ Монгол улсад өмнө нь хийгдсэн мал аж ахуйн судалгаагаар (Дэлхийн банк, 2009) 500 ба түүнээс дээш малтай малчид зах зээлд илүү нэвтэрсэн бөгөөд үйлдвэрлэлийн хүчин чадлаа зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн харьцангуй хурдан зохицуулж чаддаг. Харин 200-аас цөөн малтай малчид зах зээлд малаа борлуулах боломж нь хязгаарлагдмал бөгөөд хахир өвөлд (зуд) маш эмзэг байдаг.

¹² Орлого болон хэрэглээндээ малаа ашиглаж байсан малчин өрхүүдийн ядуурлын түвшин.

Зураг 1.31 Малын тоо, 2010, 2020



Зураг 1.32 Үйлдвэрлэсэн ноолуурын дундаж хэмжээ болон борлуулалтын орлого, 2010, 2020



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010, 2020


Эх үүсвэр: ӨНЭЗС 2010, 2020

Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр өрхийн амьжиргааны чанар сайжирсан ч, энэ нь гэр хороололд амьдардаг өрхүүдийн тулгамдсан асуудал хэвээр байна. Найдвартай эрчим хүч, байнгын халаалтын эх үүсвэр, сайжруулсан ундны ус, ариун цэврийн байгууламжийн эх үүсвэрийг ашиглах боломж нь манай улсын өрхийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлт болдог ба мөн хүүхдийн эрүүл мэнд, өрхийн амьжиргаа, эдийн засгийн бүтээмжийг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Манай улс сүүлийн арван жилийн хугацаанд аймаг болон сумын (хөдөө) төвүүдийн цахилгаан эрчим хүчний сүлжээг өргөтгөж, 2020 оны байдлаар эдгээр бүсүүд бараг нийтээрээ цахилгааны сүлжээнд холбогдож, цахилгаан ашиглах боломжтой болсон байна (Зураг 1.33.а). Харин алслагдсан хөдөө нутагт нарны эрчим хүчний системийг өргөжүүлснээр, 2020 оны байдлаар хөдөөгийн бараг бүх өрх (98 хувь) цахилгаантай болсон байна. Мөн бусад суурь үйлчилгээний хүртээмж (сайжруулсан ундны ус, ариун цэврийн байгууламж, байнгын халаалт) аажмаар сайжирч байна. Түүхий нүүрс хэрэглэхийг 2019 онд хориглосноор¹³ өрхүүдийг уламжлалт халаалтын эх үүсвэрээс татгалзахад түлхэц өгч, 2018-2020 оны хооронд халаалтын эх үүсвэр сайжрахад нөлөөлсөн байж магадгүй байна (Зураг 1.33.б). Гэсэн хэдий ч, гэр хороололд амьдардаг болон хөдөө гэрт амьдардаг өрхүүдэд эдгээр үйлчилгээний хүртээмжийн гачигдал байсаар байна (Зураг 1.33.в). Цаг хугацааны явцад нийслэл болон хөдөөгийн хоорондын ялгаатай байдлын зөрүү багасах байдал ажиглагдаж байна.

Зураг 1.33 Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж

(а) Цахилгаан, эрчим хүчний хүртээмж, 2010, 2020

(б) Сайжруулсан ундны ус, ариун цэврийн байгууламж, байнгын халаалтын хүртээмж 2010-2020



¹³ Монгол Улсын Засгийн газраас 2019 онд Улаанбаатар хотын төвийн зургаан дүүргийн хувь хүн, аж ахуйн нэгжид түүхий нүүрс хэрэглэхийг хориглож, түүхий нүүрсний үнэтэй ойролцоо үнээр сайжруулсан шахмал түлшийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх болсон.

(в) Сайжруулсан ундны ус (2020), ариун цэврийн байгууламж (2018), байнгын халаалтын хүртээмж (2020), суурьшил, сууцны нөхцөл, хэрэглээний тэнцүү 5 бүлгээр¹⁴



Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020

Шигтгээ 1.4 Олон хэмжээст ядуурлын хэмжүүр

Дэлхийн банкаас боловсруулсан Олон Хэмжээст Ядуурлын Хэмжүүр (ОХЯХ) нь ядуурлыг ганц мөнгөн хэлбэрээс гадна өрхийн амьжиргаанд нөлөөтэй мөнгөн бус талыг ойлгоход хэрэг болдог. Ядуурлыг хэмжих олон хэмжээст арга нь хүмүүсийн амьжиргаа нэг эсвэл олон үзүүлэлтээр гачигдалтай байна уу, эсвэл ямар нэгэн гачигдалгүй байна уу гэдгийг үнэлэхэд өргөнөөр хэрэглэгддэг арга юм. Түүнчлэн Тогтвортой Хөгжлийн Зорилгууд (ТХЗ) нь “бүх төрлийн ядуурлыг” (ТХЗ.1) арилгахыг онцолж байгаа бол бусад ТХЗ-ууд бас олон хэмжээстийн мөнгөн бус үзүүлэлтүүд дэх гачигдалд анхаарч байна. Улс орнууд ядуурлыг олон талаас нь судлахын тулд Дэлхийн банкны ОХЯХ-ийн гурван хэмжээс, зургаан үзүүлэлтийг ойлгох¹⁵ хэрэгтэй.

Гурван хэмжээс үзүүлэлтэд: (1) Ядуурлын шугамыг 1.90 ам.доллар (ХАЧП)-оор тооцсон ядуурлын хамралт, (2) Боловсролын хүртээмж, (3) Дэд бүтцийн суурь үйлчилгээний хүртээмж багтана. Зургаан үзүүлэлтэд: өрхийн нэг хүнд ногдох хэрэглээ эсвэл орлого, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, ундны ус, ариун цэврийн байгууламж, цахилгаан, эрчим хүчний¹⁶ үзүүлэлтүүд тус тус багтаж байна.

ОХЯХ-ийн тооцоонд хэмжээс болгоны болон дэд үзүүлэлт бүрийн жин нь тэнцүү жинтэй байх ба нийт нийлбэр нь 1 байхаар хуваарилагдсан байна¹⁷. Хэрэв гуравны нэгээс илүү жигнэгдсэн үзүүлэлтээр гачигдсан (33 хувь) байвал олон хэмжээсээр ядуу гэж тооцогдоно.

¹⁴ Сайжруулсан ундны ус гэдэгт ус дамжуулах шугам хоолойнд холбогдсон, төвлөрсөн ус хангамжийн систем ашигладаг, хамгаалалттай худаг, хамгаалалттай булаг шанд, зөөврийн усны үйлчилгээ, хурын ус болон савласан ус ашигладаг өрхүүдийг хамруулсан. Сайжруулсан ариун цэврийн байгууламж гэдэгт төвлөрсөн шугамд холбогдсон бие засах байгууламж (ариутгах татуургатай), битүү тунгаагуур, сайжруулсан нүхэн жорлон, био жорлон ашигладаг өрхүүдийг хамруулсан. Байнгын халаалтын эх үүсвэрт төвлөрсөн халаалтад холбогдсон, хувийн бага оврын уурын зуух эсвэл цахилгаан халаалтын систем ашигладаг өрхүүдийг хамруулсан.

¹⁵ Олон улсын болон үндэсний ядуурлыг бууруулах арга хэмжээний үзэл баримтлалтай адил Дэлхийн банкны ОХЯХ нь улс орнуудыг хооронд нь харьцуулах боломжтой үзүүлэлтээр хангахад чиглэсэн ба энэ нь Монгол Улсын тусгай хэрэгцээ шаардлагыг бүрэн хамруулах шаардлагагүй. Нөгөөтэйгүүр, тухайн улс өөрийн орны онцлог, хэрэгцээ, бодлогын асуудлуудаа тусгасан хэмжээс, үзүүлэлтүүдээ сонгож өөрсдийн олон хэмжээст хэмжүүрийг боловсруулж болно.

¹⁶ Бүх үзүүлэлтүүд хоёрчилсон (0/1) нөхцлөөр илэрхийлэгдсэн. Зургаан үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлов: (1) мөнгөний ядуурал: Нэг хүнд ногдох нэг өдрийн хэрэглээ 1.90 ам.доллар (ХАЧП)-оос бага бол, (2) сургуульд хамрагдалт: Дор хаяж сургуулийн насны (6-14 нас) нэг хүүхэд сургуульд хамрагдаагүй бол, (3) боловсролын түвшин: Насанд хүрсэн өрхийн гишүүдийн хэн нь ч бага түвшний боловсрол эзэмшээгүй бол, (4) ундны ус: Өрх ундны усны эх үүсвэрээр хангагдаагүй бол, (5) ариун цэврийн байгууламж: Өрх ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй бол, (6) цахилгаан: Өрх ямар ч цахилгаангүй бол тухайн үзүүлэлтээр гачигдалтай гэж үзсэн.

¹⁷ ОХЯХ-ийн нийт жингийн нийлбэр нь 1-тэй тэнцүү байх ёстой ба ОХЯХ-ийн хэмжээс бүр ижил жинтэй байна. Мөн хэмжээс доторх шалгуур үзүүлэлтүүдээ тэнцүү жинг хуваарилна. Шалгуур үзүүлэлтүүдийн жинг тооцохдоо тухайн хэмжээсийн жинг үзүүлэлтүүдийн тоонд хувааж олно. Дэлгэрэнгүйг Дэлхийн Банк, 2022-оос харна уу.

2

КОВИД-19 2020 ОНД: ЦАР ТАХЛЫН ЭХЭН ҮЕИЙН ӨРХИЙН АМЬЖИРГАА


Энэ бүлэгт 2020 оны ӨНЭЗС-нд хамрагдсан өрхийн мэдээллийг ашиглан Ковид-19 цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлсэн нөлөөллийг судлахыг зорьсон. Тодруулбал, цар тахал амьжиргааны ялгаатай бүлгийн өрхүүдийн хөдөлмөр эрхлэлт болон орлогод хэрхэн нөлөө үзүүлснийг тодорхойлохдоо цаг хугацааны хандлагыг харлаа. Мөн цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн нийгмийн халамж, дэмжлэг, тусламжийн үр ашгийг харахыг хичээсэн болно.

2.1. МОНГОЛ УЛС ДАХЬ КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ 2020 ОНД


Ковид-19 цар тахлын дэгдэлт манай улсын эдийн засгийг уналтад хүргэсэн ч 2021 он хүртэл тийм ч их хохирол учруулаагүй байв (Зураг 2.1(a)). Манай улсын Засгийн газар 2020 оны эхээр эхэлсэн цар тахлын эсрэг урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг шуурхай авсан байдаг. Олон улсын болон дотоодын хөдөлгөөнийг хязгаарласан эдгээр арга хэмжээ нь хүн амын хөдөлгөөнийг огцом буурахад хүргэсэн (Зураг 2.1(б)). Гэвч Ковид-19-ийн тохиолдол цөөн, ихэвчлэн гаднаас зөөвөрлөгдсөн байсан нь хүн амын хөдөлгөөнийг хязгаарлалт богино хугацаанд үргэлжлэх нөхцөл болж байв. Гэхдээ бодит байдалд 2020 оны 11 сар хүртэл манай улсад Ковид-19-ийн тохиолдол бараг бүртгэгдээгүй байв (Зураг 2.1(a)). 2020 оны 11 сарын дунд үеэс эхлэн Ковид-19-ийн дотоодын тохиолдлын тоо эрчимтэй нэмэгдэж ирсэн нь 2021 оны эхний улирал дуустал хүн амын хөдөлгөөнийг хатуу хориход хүргэсэн (Зураг 2.1(б)). Ковид-19-ийн тохиолдлын тоо болон түүнээс шалтгаалсан нас баралт 2021 онд эрчимтэй нэмэгдэж, нас баралтын тоо хүн амынхаа тоотой харьцуулахад өндөр хэмжээнд хүрсэн хэдий ч 2021 оны 4 сараас эхлэн хөдөлгөөнийг хязгаарлалтын хатуу хоригийг шат дараатай бууруулан цар тахалтай дасан зохицож амьдрах замыг сонгосон байна.

Зураг 2.1 Цар тахал 2020-оос 2021 онд

(a) Ковид-19-ийн өвчлөл ба нас баралт



(б) Хүн амын хөдөлгөөн ба хязгаарлалт




Тайлбар: 14 хоногийн дундаж үзүүлэлт нь Ковид-19-ийн тохиолдол болон нас баралтыг харуулсан. 30 хоногийн дундаж үзүүлэлт нь хязгаарлалтын арга хэмжээ болон хүн амын хөдөлгөөнийг өөрчлөлтийг харуулна. Хөдөлгөөний индекс нь ажлын байр, худалдааны газар, нийтийн тээврийн зогсоол, автомашины зогсоол зэрэгт зарцуулсан дундаж цагийг цар тахлын өмнөх үетэй харьцуулан харуулдаг бөгөөд урвуу утгаар илэрхийлэгддэг (өөрөөр хэлбэл, өндөр утга нь хөдөлгөөн бага байсныг илтгэнэ). Хязгаарлалтын индекс гэдэг нь Ковид-19-ийн эсрэг ЗГ-ын авч хэрэгжүүлсэн хязгаарлалтын арга хэмжээний үр нөлөөг харуулдаг.

Эх үүсвэр: "Our World in Data", "Google Mobility Reports", Оксфордын Их сургууль

Ажиллах хүчний судалгааны үр дүнгээс харахад цар тахал өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд 2020 оны сүүлийн улирал хүртэл бага нөлөөлж байсан хэдий ч 2021 оны эхээр хамгийн ихээр нөлөөлсөн байв. 2020 оны эхний улиралд ажиллах хүчний оролцооны түвшин 60 хувиас бууж 2020 оны эцэс буюу хөдөлгөөний хатуу хязгаарлалт тогтоосон үед 57 хувь болов (Зураг 2.2(a)). Хөдөлгөөний хатуу хязгаарлалт үргэлжлэхийн хэрээр ажиллах хүчний оролцооны түвшин буурч 2021 оны эхний хагаст 54.9 хувь болсон. Ажиллах хүчний оролцооны түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь) хоёулаа 2021 оны эхний улиралд манай улсад сүүлийн жилүүдэд байгаагүй хамгийн доод түвшинд хүрсэн байна. Ялангуяа үйлчилгээний салбарт ажиллагчид болон 20-29 насныхны хөдөлмөр эрхлэлт 2021 оны эхээр огцом буурсан байв. Улаанбаатар хотын хүн амын хөдөлмөр эрхлэлт 2020 оны 4-р улирлаас 2021 оны 1-р улиралд 5.7 нэгж хувиар буурсан ба Ковид-19-ийн дэгдэлт эрт эхэлсэн ОХУ-ын хилтэй залгаа аймгууд болох Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгуудад хөдөлмөр эрхлэлтийн бууралт харьцангуй их байв. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин 2019 онд мэдэгдэхүйц буурч ирсэн боловч 2020 оны сүүлийн улиралд нэмэгдэж, 2021 оны эхээр Улаанбаатар хотын 30-аас доош насныхны хөдөлмөрийн дутуу ашиглалт эргэж өссөн байна (Зураг 2.2(б)).

Зураг 2.2 Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин

(а) Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин (б) Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин




Тайлбар: Хөдөлмөрийн дутуу ашиглалт нь хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг тоон үзүүлэлтээр илэрхийлдэг бөгөөд ажилгүй хүмүүс, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч, боломжит ажиллах хүчний нийлбэр юм.
Эх үүсвэр: АХС, ҮСХ

2.2. ЦАР ТАХЛЫН ХҮН АМЫН АМЬЖИРГААНД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ 2020 ОНД


ӨНЭЗС-ны 2020 оны үр дүнгээс харахад хөдөлмөр эрхлэлт буурах үзэгдэл хот, суурин газарт хамгийн өндөр байв. ӨНЭЗС-ны үр дүн 2018-аас 2020 онд хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь) буурч 2020 оны сүүлийн улиралд улам дордсон гэж АХС-ны үр дүнг баталж байна. Хөдөлмөр эрхлэлтийн бууралт хөдөлгөөний хязгаарлалт хатуу байсан хот суурин газарт ялангуяа Улаанбаатар хотод хамгийн их хамааралтай байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин¹⁸ 2018-аас 2020 онд хөдөөд 62.7-оос 61.6 хувь, хотод 53.4-өөс 49.0 хувь болж буурсан (Зураг 2.3(а)). Түүнчлэн хот, суурин газрын хөдөлмөр эрхлэлт 2020 оны 4 дүгээр улиралд 2018 оны мөн улиралтай харьцуулахад 9.4 нэгж хувиар, хөдөөгийнх 3.6 нэгж хувиар буурсан байжээ (Зураг 2.3(б)). Суурьшил хоорондын энэ ялгаатай байдлыг 2020 онд цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн уналтад хамгийн их өртсөн үйлчилгээний салбарын хөдөлмөр эрхлэлтийн оролцоо хот суурин газарт өндөр байдагтай холбон тайлбарлаж болох юм.

Зураг 2.3 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан), хот, хөдөөгөөр

(а) 2014-2020



(б) 2020-2018 оны хөдөлмөр эрхлэлтийн түвшингийн зөрүү, улирлаар




Тайлбар: Судалгаа авснаас өмнөх 7 хоногийн хөдөлмөр эрхлэлт. Цаг хугацааны хувьд харьцуулагдах боломжтой байлгах үүднээс зөвхөн өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлт гэж тодорхойлсон.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2014-2020

¹⁸ Цаг хугацааны хувьд харьцуулагдах боломжтой байлгах үүднээс зөвхөн өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлт гэж авч үзсэн.


Чинээлэг бүлгийн ажиллагчид хот, суурин газар илүү төвлөрөн оршин сууж, үйлчилгээний салбарт түлхүү хөдөлмөр эрхэлж байгаа нь 2020 онд тэд ажлын байраа түр болон бүрмөсөн алдахад хүрсэн байх магадлал өндөр байна. Чинээлэг бүлгийн ажиллагчид хот, суурин газар оршин суух нь түгээмэл байна. Тухайлбал, 2020 онд чинээлэг 20 хувийн бүлгийн ажиллагчид хамгийн ядуу 20 хувийн ажиллагчидтай харьцуулахад хотод амьдрах нь 30 хувиар илүү байна. Цар тахлын үед үйлчилгээний салбарт ажиллагч хамгийн чинээлэг 20 хувийн хүн ам 16 нэгж хувиар, хамгийн ядуу 20 хувийн хүн ам 36 нэгж хувиар хөдөлмөр эрхлэх боломжоо алдсан байна. Судалгааны үр дүнгээс харахад 2018-аас 2020 онд чинээлэг ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт илүү бууралттай байгаа нь өмнөх жилүүдэд байсан хөдөлмөр эрхлэлтийн ялгааг багасгасан байна (Зураг 2.4(а)). Хэдийгээр хамгийн ядуу бүлгийн ажиллагчид хамгийн чинээлэг бүлгийн ажиллагчдаас хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур хэвээрээ байгаа ч 2018-аас 2020 онд хамгийн ядуу бүлгийн хөдөлмөр эрхлэлт статистикийн хувьд ач холбогдолтой байхаар мэдэгдэхүйц буураагүй байна. 2018-аас 2020 оны улирлын чиг хандлагыг харвал чинээлэг бүлгийн ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт илүү буурсан нь (ялангуяа хамгийн чинээлэг 20 хувь) 2020 оны сүүлийн улирлын огцом бууралттай холбоотой бөгөөд энэ хугацаанд хөдөлгөөний хязгаарлалт хамгийн чанга байсан (Зураг 2.4(б)). Ерөнхийдөө 2020 оны бүх улирлын туршид хамгийн чинээлэг бүлгийн 20 хувийн ажиллагчдын хөдөлмөр эрхлэлт 2018 онтой харьцуулахад бага байгаа нь чинээлэг бүлгийн ажиллагчдын ажил эрхлэх боломж удаан хугацаанд хязгаарлагдсан байж болзошгүйг харуулж байна. Энэ хандлага 2016 оны эдийн засгийн хямралын үеэс эрс ялгаатай харагдаж байгаа бөгөөд тухайн үеийн хямрал хэрэглээний бүх бүлгийн ажиллагчдад ижил нөлөө үзүүлж байв.

Зураг 2.4 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан), хэрэглээний тэнцүү 5 бүлгээр

(а) 2014-2020



(б) 2020-2018 оны хөдөлмөр эрхлэлтийн түвшингийн зөрүү, улирлаар



Тайлбар: Судалгаа авсанаас өмнөх 7 хоногийн хөдөлмөр эрхлэлт. Цаг хугацааны хувьд харьцуулагдах боломжтой байлгах үүднээс зөвхөн өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлт гэж тодорхойлсон. Эх үүсвэр: ӨНЭЗС 2014-2020

Хөдөлмөр эрхлэлт нь хүйс, насны бүлэг зэрэг өргөн хүрээнд нөлөөлжээ. ӨНЭЗС-ны үр дүнгээс харахад хөдөлмөр эрхлэлтийн оролцоо эрэгтэй, эмэгтэй бүх ажиллагчдад буурсан хэдий ч АХС-ны үр дүнгээр 2021 онд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн оролцоо эргэн сэргэхгүй удаашралтай байсан байна. Хүн амын хөдөлмөр эрхлэлтэд гарсан нөлөөг залуучууд болон бусад хөдөлмөрийн насны бүлгүүдтэй харьцуулан харж болох юм.


2020 онд ажиллагчдын ажилласан цагийн хандлагаас харахад хөдөлмөр эрхлэлтийн нөлөөлөл нь энгийн бус бөгөөд хэрэглээний бүлэг бүрт ижил байна. Дэлхийн Банкны аж ахуйн нэгжийн судалгааны үр дүнгээс харахад 2020 оны эдийн засгийн уналтыг Монголын аж ахуйн нэгжүүд, ажил олгогчид ажилтнуудаа цомхотгохоос илүү ажлын цагийг нь багасгах, цалин хөлсийг нь бууруулах замаар зохицуулалт хийн шийдвэрлэхийг илүү хичээсэн байна (Дэлхийн банкны тайлан). ӨНЭЗС-ны тоо мэдээллээс бодитоор харвал 2020 оны 4 дүгээр улиралд ажиллагчид өмнөх 3 улиралтайгаа харьцуулахад 2.4 цагаар бага ажилласан байгаа нь 2020 оны 11 дүгээр сарын хөдөлгөөний хатуу хязгаарлалтын нөлөөллөөс шалтгаалсан эдийн засгийн идэвхжил буурсан үед ажил олгогчдын ажиллах хүчээ авч үлдэх гэсэн зохицуулалтыг илэрхийлж байгаа юм. Тодруулбал, үйлчилгээний салбарт ажиллагчид 4 дүгээр улиралд өмнөх улирлаасаа 2.7 цагаар

бага ажилласан байв (Зураг 2.5(а)). АХС болон ӨНЭЗС-ны 2020 оны тоо баримтаас харахад үйлчилгээний салбарын буюу жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газар, тээврийн ажил эрхэлдэг ажиллагчдаас илүү мэдээлэл, харилцаа холбоо, санхүү болон захиргааны ажлуудыг гэрээсээ хийхэд боломжтой байсан бөгөөд ийм төрлийн ажил хийдэг ажиллагчдын тоо бага буурчээ. Нэмж дурдахад, ядуу болон ядуу бус ажиллагчид, эрэгтэй болон эмэгтэй ажиллагчдын дунд ажлын цаг багассан хандлага ижил байсан бол цалинтай ажил хийдэг хүмүүс хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс, 25-60 насны ажиллагчид ахмад настнууд болон залуучуудтай харьцуулахад ажиллах цагаа багасгасан байв.


Цар тахал 2020 онд ажиллагчдын цалин хөлсөд төдийлөн нөлөө үзүүлсэнгүй. Судалгаа авсанаас өмнөх 7 хоногийн цалингийн өөрчлөлтийг хянах боломжгүй байсан ч 2020 оны ӨНЭЗС-наас ажиллагчдын сүүлийн сарын дундаж цалингийн өөрчлөлтийг улирлаар харахад хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарт хамгийн бага байна (Зураг 2.5(б)). Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын сарын дундаж цалин 2020 оны 4 дүгээр улиралд өмнөх улиралтайгаа харьцуулахад буурсан ч 1, 2 дугаар улиралтайгаа харьцуулахад өндөр хэвээр байв. 4 дүгээр улирлын цалингийн бууралт нь дээр дурдсанчлан ажлын цагийг багасгасантай холбоотой байж болно. 2020 оны 4 дүгээр улирлын цагийн цалин хөлсний бууралтыг дээр дурдсанчлан ажилласан цагийн тоо багассан тохиолдолд дутуу тооцсон байх магадлал бий. Үнэн хэрэгтээ АХС-ны тоо мэдээллээр 2020 оны 4 дүгээр улиралд цалин хөлс 5 хувиар нэмэгдсэн нь үйлчилгээний салбарын цалингийн өсөлтөөс шалтгаалсныг харуулж байна.

Зураг 2.5 Хөдөлмөр эрхлэлтийн зохицуулалт

(а) Сүүлийн 7 хоногт ажилласан дундаж цаг



(б) Сүүлийн сард авсан дундаж цалин, 2020 оны үнээр




Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

ӨНЭЗС-ны үр дүнгээс харахад 2018-аас 2020 оны хооронд ялангуяа хүн амын хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн бүлэгт жилийн цалингийн өсөлт өндөр байсан бол эсрэгээрээ тэдний хэрэглээний өсөлт бага байгаа нь тодорхой хариултгүй хэвээр байна. Нэг ажиллагчид ногдох дундаж цалин (бодитоор) 2018-аас 2020 оны хооронд 22.6 хувиар өссөн нь 2010 оноос хойш 2 жилийн хоорондох хамгийн өндөр өсөлт байв (Зураг 2.6(а)). АХС-ны мэдээлэл энэ хандлагыг бататгаж¹⁹ байгаа бөгөөд бодит цалингийн өсөлтийн дийлэнх нь 2019 онд гарсан, харин 2020 онд өсөлт нь зогсонги байдалд орсон байна (Зураг 2.6(б)). 2018-аас 2020 онд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын ажиллагчид ялангуяа уул уурхай, жижиглэн худалдааны салбарын ажиллагчдын бодит цалин хамгийн өндөр өсөлттэй байжээ (Зураг 2.6(а)). Түүгээр ч зогсохгүй ядуу ажиллагчдын ялангуяа доод 40 хувийн бүлгийн ажиллагчдын цалин харьцангуй их хэмжээгээр нэмэгдсэн байна (Зураг 2.6(в)). Энэ үр дүн 2018-аас 2020 онд хамгийн ядуу 40 хувийн бүлгийн хэрэглээний өсөлт яагаад бага байсан юм бол гэсэн тааврыг гаргаж ирсэн.


¹⁹ АХС-ны үр дүн 2018-аас 2020 оны хооронд дундаж бодит цалин 17.3 хувиар өссөнийг харуулж байна. Гэсэн хэдий ч 2019 онд аргачлал, асуулгад оруулсан өөрчлөлт нь 2019 оны өмнөх болон дараах үеийн цагийн цалин хөлсний үзүүлэлтийг харьцуулж үзэхэд нөлөөлж байж болзошгүй (Зураг 2.6-ын тайлбарыг үзнэ үү).

Зураг 2.6 Нэг ажиллагчид ногдох цалингийн орлогын хандлага


(а) Нэг ажиллагчид ногдох дундаж бодит цалин, салбараар (2020 оны үнээр)



(б) Нэг ажиллагчид ногдох үндсэн ажлынх нь цагийн бодит дундаж цалин, АХС (2020 оны үнээр)



(в) Хэрэглээний бүлгүүдийн нэг ажиллагчид ногдох бодит цалингийн өөрчлөлт (2018-2020)




Тайлбар: Зураг (б)-д бодит цалинг тооцохдоо жилийн ХҮИ-ийг ашигласан. АХС-ны 2014-2018 оны мэдээллээс нэг цагийн цалин хөлсийг өнгөрсөн 7 хоногт олсон цалин хөлс болон ажилласан дундаж цагийг ашиглан тооцсон. 2019-2020 оны АХС-ны мэдээллээс нэг цагийн цалин хөлсийг хариулагчийн хамгийн сүүлд авсан цалин болон тухайн цалинг авахад ажилласан дундаж цагийг ашиглан тооцсон. Зураг (в) саарал хэсэг нь 95 хувийн итгэмжлэх интервалыг илэрхийлнэ.
Эх үүсвэр: ӨНЭЭС 2010-2018; АХС 2014-2020; ҮСХ

2018-аас 2020 оны хоорондох орлого, хэрэглээний чиг хандлагыг тайлбарлан дүн шинжилгээ хийхэд хэд хэдэн асуудлыг анхаарах шаардлагатай. 1-рт, жилийн цалинг тооцох жишиг хугацаа нь судалгаанаас өмнөх сүүлийн 12 сарын мэдээллийг цуглуулдаг тул тооцоолсон цалин нь зөвхөн 2020 оны өсөлтийг илэрхийлэхгүй. Өөрөөр хэлбэл 2020 оны ӨНЭЭС нь бүтэн жил тойрсон судалгаа учраас сүүлийн 12 сарын лавлагаа хугацааны цалинд 2019 оны цалингийн орлого мөн тусгагдсан. Энэ тохиолдолд АХС-ны үр дүнгээр бодит цалингийн өсөлтийн дийлэнх нь 2019 онд байсан гэсэн дүгнэлтийг анхаарч үзэх хэрэгтэй юм. Гэхдээ, КНТӨСС-ны мэдээлэл нь 2020 онд богино хугацаанд нөлөөлөл илүү хүчтэй байсан байх магадлалтайг харуулж байсан (Шигтгээ 2.1-ийг үзнэ үү). 2-рт. Бүлэг 1.1-т дурдсанчлан 2020 оны хэрэглээг тооцоолсон нь хүн амын хэрэглээний ялгаатай бүлгүүдийн хувьд загвар нь алдаатай ажилласан байж болох учраас 2018-аас 2020 оны хоорондох орлого, хэрэглээний ялгаатай хандлагыг бий болоход зарим талаар нөлөөлсөн байж болзошгүй. Гэсэн хэдий ч энэ алдааны хэмжээг 2022 оны ӨНЭЭС-ны мэдээллийг ашиглан хэрэглээг бүрдүүлэн, ядуурлын шугамыг шинэчилсэн үед үнэлэх боломжтой юм. Эцэст нь, Бүлэг 1.1-т дурдсанчлан өрхүүд хэрэглээнийхээ талаар дутуу тайлагнасан байж болзошгүй байгаа нь орлого, хэрэглээний энэ ажиглагдсан чиг хандлагын зөрүүг улам бүр нэмэгдүүлсэн байж болох юм.

2018-аас 2020 онд ноолуурын үнэ огцом унасан хэдий ч мал аж ахуйн орлого өссөн байна. Тухайлбал мал, махны үнийн өсөлтөөс шалтгаалан ядуу өрхүүдийн орлого нэмэгдсэн байв. Цар тахлын үед ноолуурын эрэлт буурснаас шалтгаалан килограмм ноолуурын үнэ 2020 онд 2018 оноос ойролцоогоор 35 орчим хувиар буурсан. Цаашилбал, 2018-аас 2020 онд малчдын чинээлэг бүлгийн ноолуурын борлуулалт илүүтэй буурсан байв (Зураг 2.7). Дээрх хугацаанд ямаа, хонь, үхэр зэрэг малын үнэ 26-37 орчим хувиар өсөж малчин өрхүүдийн мал борлуулсан орлого нэмэгдсэн байжээ. Мал борлуулснаас олсон орлогын өсөлт хамгийн бага хэрэглээтэй 40 хувьд багтсан малчдын хувьд мэдэгдэхүйц их тодруулбал, хамгийн бага хэрэглээтэй 20 хувийн борлуулалт 2.3 дахин, түүний дээд талын 20 хувьд 87 хувиар өссөн байна (Зураг 2.7). Хамгийн их хэрэглээтэй 60 хувьд багтсан малчдын мал борлуулсан орлого өссөн хэдий ч мэдэгдэхүйц өндөр байсангүй. Хэрвээ малчдын малаа зарж борлуулсан байдлыг цар тахлыг туулах арга байсан гэж үзэх юм бол малын борлуулалт их байгаа нь малчин өрхүүд санхүүгийн хүндрэлтэй тулгарсан болохыг илтгэнэ. Гэхдээ хамгийн бага хэрэглээтэй 40 хувьд багтсан малчин өрхийн малын тоо 15-24 хувиар өссөн нь цар тахалд малчид бага нэрвэгдсэн байх магадлалтайг илэрхийлж байна.

Зураг 2.7 Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүн борлуулсан орлогын өөрчлөлт, малын тооны өөрчлөлтийн хувь (2018-2020)




Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2020


Цалинтай ажиллагчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого нэмэгдсэн нь ялангуяа ядуу өрхүүдийн хөдөлмөр эрхлэлтийн орлого 2018-аас 2020 онд нэмэгдэхэд их нөлөө үзүүлжээ. Хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн халамжийн шилжүүлгийн орлогын өсөлтөөс шалтгаалан 2018-аас 2020 онд нэг хүнд бодит ногдох орлого дунджаар 19.0 хувиар өссөн байна (Зураг 2.8(a)). Хөдөлмөр эрхлэлтийн орлого ядуу болон ядуу бус өрхүүдийн аль алинд тодорхой хэмжээгээр өссөн боловч 2010 оноос хойш сүүлийн 10 жилийн хугацаанд ядуу өрхүүдийн орлого харьцангуй болон үнэмлэхүй ихээр нэмэгджээ. Нэг хүнд ногдох хөдөлмөр эрхлэлтийн орлого ядуу өрхүүдэд 2018-аас 2020 онд 66.4 хувиар нэмэгдсэн бол ядуу бус өрхүүдэд 8.8 хувь байна. Хөдөлмөр эрхлэлтийн орлогын огцом өсөлт нь өрхийн нийт орлогын өсөлтөд нөлөөлсөн бөгөөд энэ өсөлт ядуу өрхүүдийн хувьд мэдэгдэхүйц байна. Хамгийн ядуу 20 хувийн нийт орлого 71.5 хувь, түүний дээд талын 20 хувийн нийт орлого 39.1 хувиар өссөн байв (Зураг 2.8(б)). Нөгөө талдаа хамгийн чинээлэг өрхүүдийн нийт орлогын өсөлт зогсонги байдалтай байна. 2018-аас 2020 онд хүн амын хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн өрхийн нийт орлогын өсөлтийн 70 орчим хувийг хөдөлмөр эрхлэлтийн орлого бүрдүүлж байна. Хамгийн бага хэрэглээтэй 40 хувийн өрхийн хувиараа хөдөлмөр эрхлэгчид буюу хөдөө аж ахуй болон хөдөө аж ахуйн бус бизнес эрхлэгчдийн орлого тодорхой хэмжээнд өссөн хэдий ч тэдний цалин хөлсний орлого нийт орлогынх нь өсөлтөд гол нөлөөг үзүүлжээ.

Зураг 2.8 Өрхийн нэг хүнд ногдох сарын бодит цалин хөлсний болон нийт орлого

(а) Өрхийн нэг хүнд ногдох хөдөлмөр эрхлэлтийн бодит орлого (2010-2020, 2020 оны үнээр)



(б) Өрхийн нэг хүнд ногдох бодит нийт орлогын өөрчлөлтийн бүтэц (2018-2020)




Тайлбар: Зураг (б)-д өндөр насны тэтгэвэрт зөвхөн нийгмийн даатгалаас авдаг өндөр насны тэтгэврийг тооцсон. Тэтгэвэр, тэтгэмжид нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн (сургалт, жижиг зээл гэх мэт) бусад тэтгэвэр, тэтгэмжийг оруулсан. Бусад орлогод ангилаагүй бусад эх үүсвэрийг оруулсан.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2010-2020


2018-2020 оны хооронд хөдөлмөр эрхлэлтийн орлого ялангуяа хамгийн ядуу 40 хувийн өрхүүдэд огцом өсөлттэй байсан боловч энэ хугацаанд ядуурал бага хэмжээгээр буурсан нь таавар хэвээр байна. Гэхдээ 2020 оны улирлын чиг хандлагаас харахад өрхүүд цар тахлын нөлөөгөөр богино хугацаанд хөдөлмөр эрхлэлтээс олох орлогодоо мэдэгдэхүйц алдагдал хүлээсэн байж магадгүй юм. Хэдийгээр 2020 оны ӨНЭЗС нь 2018 оноос 2020 онд нийт өрхийн хөдөлмөр эрхлэлтийн орлого өссөнийг харуулж байгаа ч цар тахлын цалин болон орлогод үзүүлсэн богино хугацааны нөлөөг дутуу тооцох магадлалтай, учир нь уг судалгаа нь мэдээлэл цуглуулсан үеэс өмнөх бүтэн жилд олсон орлогод үндэслэдэг (Шигтгээ 2.1-ийг харна уу). Тодруулбал 2020 оны эхний хоёр улиралд судалгаанд хамрагдсан өрхүүдийн орлогын тооцоонд 2019 онд олсон орлогын дор хаяж тал хувь нь багтсан ба 2019 онд Монгол Улсын эдийн засаг өсөлттэй жил байсан болно. 2020 оны 4 дүгээр улиралд судалгаанд хамрагдсан өрхүүд 1-3 дугаар улиралд судалгаанд хамрагдсан өрхүүдээс хөдөлмөр эрхлэлтийн орлого дунджаар 9 хувиар бага байгааг 2020 оны улирлын чиг хандлага харуулж байна (Зураг 2.9).

Зураг 2.9 Нэг хүнд ногдох хөдөлмөр эрхлэлтийн сарын дундаж орлого, улирлаар, 2020 он



Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

Зураг 2.10 КОВИД-19 цар тахлын улмаас 2020 оны 2 дугаар сараас өрхийн хөдөлмөр эрхлэлтийн орлогоо алдсан гэж хариулсан өрхийн хувь, хэрэглээний тэнцүү таван бүлгээр



Тайлбар: КОВИД-19 модуль судалгаанд ӨНЭЗС-нд 2-4 дүгээр улиралд хамрагдсан өрхүүдийг хамруулсан.
Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

Зарим өрхүүд цар тахлын улмаас 2020 онд хөдөлмөр эрхлэлтийн орлогоо алдаж байсан ч амьжиргаанд нь үзүүлэх нөлөө тийм ч их биш байсныг өрхүүдийн өөрсдийн өгсөн мэдээлэл нотолж байна. Коронавирусийн талаарх мэдлэг, цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлж буй нөлөө, түүнийг даван туулж байгаа арга зам зэрэг КОВИД-19 цар тахалтай холбоотой асуулга бүхий модуль судалгааг 2020 оны ӨНЭЗС-нд нэмсэн ба 2020 оны 2 дугаар улирлаас эхлэн өрхөөс цуглуулж эхэлсэн учраас нийт өрхийн 75 хувь нь хамрагдсан. Тус модуль судалгаанд хамрагдсан өрхүүдийн 30 орчим хувь нь цар тахлын улмаас өрхийн хөдөлмөр эрхлэлтийн орлогоо алдсан гэж хариулсан байв. Түүнчлэн хамгийн чинээлэг бүлгийн өрхүүд хөдөлмөр эрхлэлтийн орлого буурсан гэж хариулсан хувь бага байсан боловч бүлгүүдийн хувьд ерөнхийдөө ойролцоо байна (Зураг 2.10).

Шигтгээ 2.1. Коронавирусийн өрхөд үзүүлж буй нөлөөг “цаг тухайд нь” хянах зорилготой “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”

КНТӨСС нь цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлж буй богино хугацааны нөлөөллийг илүү сайн ойлгох боломжийг олгосон.


ӨНЭЗС-гаар цар тахлын улмаас өрхийн амьжиргаанд гарсан нөлөөллийн цогц шинжилгээг хийж байгаа хэдий ч хөдөлгөөний хатуу хязгаарлалтын үе дэх богино хугацааны нөлөөллийг нарийвчлан судлах боломжгүй юм. Харин “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”-гаар цар тахлын үед өрхийн хөдөлмөр эрхлэлт, орлогод гарч буй өөрчлөлт, үйлчилгээний хүртээмж, тахлын үеийг даван туулж буй арга замыг болон бусад сэдвүүдийн талаар тухай бүрт богино хугацаанд мэдээллүүдийг гарган авч чадаж байв. “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”-г 2020-2021 оны хооронд нийт 5 удаа зохион байгуулсан бөгөөд мэдээлэл цуглуулалт тухай бүрт 1-2 долоо хоног үргэлжилсэн: 1-р шат 2020 оны 5 дугаар сар, 2-р шат 2020 оны 9 дүгээр сар, 3-р шат 2020 оны 12 дугаар сар, 4-р шат 2021 оны 4 дүгээр сар, 5-р шат 2021 оны 6 дугаар сард зохион байгуулагдсан. Энэхүү судалгаа нь богино хугацаанд утсаар мэдээлэл цуглуулдаг тойм судалгаа хэдий ч цар тахал өрхүүдэд хэрхэн нөлөөлснийг харуулах нотлох баримт болсон.

КНТӨСС нь 2020 оны хөдөлгөөний хязгаарлалттай үед цар тахлын өрхөд үзүүлэх нөлөө их байсан байж болзошгүйг харуулж байгаа бол ӨНЭЗС-ны ерөнхий чиг хандлага энэ нөлөө богино хугацаанд байсныг харуулж байна. КНТӨСС-ны мэдээллийг 2020 онд хөдөлгөөний хязгаарлалттай үед цуглуулсан бөгөөд эхний судалгааг 2020 оны 5 дугаар сард анхны хөл хорио тогтоосон үед мэдээлэл цуглуулсан бол хөдөлмөр эрхлэлт, орлогын мэдээлэл бүхий дараагийн шатыг 2020 оны 12 дугаар сард буюу илүү хатуу хөл хорионы дундуур мэдээлэл цуглуулсан. Иймээс тус судалгааны мэдээлэл нь КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хөдөлгөөний хатуу хязгаарлалтын үед нөлөөллийн зэрэг хэр зэрэг байсныг тодорхойлох боломжийг олгосон. КНТӨСС нь ӨНЭЗС-ны үр дүнтэй төстэй ерөнхий хандлага байгаа хэдий ч хөл хорионы үед нөлөөлөл илүү хүчтэй байсныг харуулж байв. Судалгааны мэдээлэл цуглуулах үед цар тахлын өмнөх үеэс ажил хийхээ зогсоосон иргэдийн хувь эхний хөл хорионоос дараагийн хөл хорионы хооронд (2020 оны 5 дугаар сараас 2020 оны 12 дугаар сар) 19 хувиас 52 хувь болж өссөн байв. Үзүүлэлтүүдийг шууд харьцуулах боломжгүй боловч ӨНЭЗС-ны хөдөлмөр эрхлэлтийн чиг хандлагаас харахад хөл хорионы үеийн ажил зогсолт түр зуурынх байсныг илэрхийлж байв¹.

¹ Нэмж дурдахад “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”-ны тойм байдал нь хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, өрхийн хөдөлмөр эрхлэлтийн орлогын өөрчлөлтийг нарийн тодорхойлохгүй, чиг хандлагыг илэрхийлэхгүй боловч нөлөөллийн ялгааг илрүүлэхэд чухал мэдээлэл болсон.

Өрхийн бусдаас авсан хандив, тусламжийн орлогын хэмжээнд цар тахал ерөнхийдөө нөлөө үзүүлээгүй боловч зарим өрхүүдэд бусдаас хандив, тусламж авахад саад учирч байсан болохыг өөрсдийнх нь өгсөн мэдээлэл нотолж байна. 2020 онд бусдаас тусламж, дэмжлэг авсан өрхүүдийн 12.5 хувь (нийт өрхийн 9.1 хувь) нь цар тахлын улмаас тусламж авахад хүндрэлтэй байсан гэж хариулсан байна. Ялангуяа Улаанбаатар хотын өрхийн хувьд бусдаас тусламж, дэмжлэг авахад хүндрэлтэй байжээ. Тодруулбал Улаанбаатар хотын бусдаас тусламж, дэмжлэг авсан өрхийн тавны нэг нь тусламж, дэмжлэг авахад хүндрэлтэй байсан гэж хариулсан байна (Зураг 2.11(а)). Түүнчлэн Улаанбаатар хотын бусдаас тусламж, дэмжлэг авахад хүндрэлтэй байгаа гэж хариулсан ядуу өрх, ядуу бус өрхөөс 6.8 нэгж хувиар илүү байжээ. Манай улсын хувьд өрхийн бусдаас авсан бэлэг, тусламж, хандивын орлогын дийлэнх хувийг дотоодын гуйвуулга эзэлдэг бөгөөд цар тахлын өмнө бусдаас авсан бэлэг, тусламж, хандивыг гол төлөв бэлэн мөнгөөр эсвэл ямар нэгэн мөнгөн бус хэлбэрээр авч байв (Зураг 2.11(б)). Цар тахлын үеийн нийгмээс тусгаарлах арга хэмжээ, хөдөлгөөний хязгаарлалт зэрэг нь бусдад бэлнээр хандив, тусламж өгөхөд хүндрэл учруулсан байж болзошгүй бөгөөд үүний үр дүнд 2018-аас 2020 онд дансаар бусдад хандив, тусламж шилжүүлсэн өрхийн нийт хандив тусламж өгсөн өрхөд эзлэх хувь хоёр дахин буюу 22 хувиас 42 хувь болж өссөн байна (Зураг 2.11(б)). Энэ өсөлт нь ядуу өрхүүдэд илүү нөлөөлсөн ба бусдаас хандив, тусламж хүлээн авсан ядуу өрхүүд дансаар хандив, тусламжаа авсан хувь нь 3 дахин (14.6 хувиас 43.0 хувь), ядуу бус өрхүүд 1.8 дахин (23.5 хувиас 41.9 хувь) өссөн байна.

Зураг 2.11 Цар тахлын улмаас бусдаас тусламж, дэмжлэг авахад хүндрэлтэй байсан гэж хариулсан өрхийн хувь, суурьшлар, бусдаас тусламж, дэмжлэг авсан хэлбэрээр



Тайлбар: Зураг (б)-д тусламж, дэмжлэгийг аль нэг хэлбэрээр нь дор хаяж нэг удаа авсан өрхийн нийт өрхөд эзлэх хувийг харуулав. Түүврийг ӨНЭЗС-ны КОВИД-19 модулийн 2020 оны 2-4 дүгээр улиралд судалгаанд хамрагдсан өрхөөр авсан.


Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

2.3. ӨРХИЙН ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛЖ БУЙ АРГА ЗАМ БА БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ


Цар тахлын эсрэг 2020 онд хэрэгжүүлсэн тусламж, дэмжлэг огцом өссөн нь хүүхдийн мөнгөн тэтгэмж нэмэгдсэнтэй холбоотой. Тэтгэвэр, тэтгэмж хэлбэрээр авсан нэг хүнд ногдох дундаж орлогын хэмжээ 2020 онд 2018 онтой харьцуулахад 40 хувиар өссөн байна (Зураг 2.12(а)). Энэхүү өсөлтөд цар тахлын үед хүүхдийн мөнгөн тэтгэмжийг тав дахин нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн өсөлтийг тэтгэмжийн бүтцийн зургаас харж болно (Зураг 2.12(б)). Ерөнхийдөө олон хүүхэдтэй ядуу өрхүүдийн хувьд тэтгэвэр, тэтгэмжийн орлогын өсөлт өндөр байна. Хамгийн бага хэрэглээтэй 20 хувийн нэг хүнд ногдох хүүхдийн мөнгөн тэтгэмжээс орсон дундаж бодит орлого 2020 онд 2018 оноос хоёр дахин (сард дунджаар 10100 төгрөгөөс 20600 төгрөг болсон) нэмэгдэж, нийт тэтгэвэр, тэтгэмжийн орлогын талаас илүү хувийг нь, нийт орлогын 9 хувийг нь бүрдүүлсэн байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжээс гадна нийт өрхийн 6-7 хувь буюу хүнсний талон авдаг өрхүүдийн хүнсний талоны мөнгөн дүнгийн хэмжээ мөн 69 хувиар (сард дунджаар бодит орлого 8090 төгрөгөөс 13600 төгрөг болсон) нэмэгдсэн байна.

Зураг 2.12 Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт

(а) Тэтгэвэр, тэтгэмжийн нэг хүнд ногдох сарын дундаж бодит орлого (2020 оны үнээр)



(б) Тэтгэвэр, тэтгэмжийн нэг хүнд ногдох сарын дундаж бодит орлогын өөрчлөлт, бүтцээр, 2018-2020



Тайлбар: Зураг (б)-д Бусад тэтгэвэр, тэтгэмжид хүүхдийн мөнгө, хүнсний талоноос бусад нийгмийн халамжийн сангийн бүх тэтгэвэр, тэтгэмжүүд орсон. Нийгмийн даатгал/хөдөлмөр эрхлэлтэд нийгмийн даатгалын сангийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүх тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг, туслалцааг оруулав.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2014-2020

Төрөөс үзүүлсэн тусламж, дэмжлэгийн хэмжээ бүс нутгийн бусад улсуудтай харьцуулахад их хэмжээгээр нэмэгдсэн хэдий ч дийлэнх өрхүүд хэрэглээгээ жигдрүүлэн, цар тахлыг даван туулахын тулд мөнгөн шилжүүлгээ бүгдийг ашиглаагүй байж болохыг нотлох баримт харуулж байна. Төрөөс 2020


онд үзүүлсэн тусламж дэмжлэгийн хэмжээг бусад улс орнуудтай харьцуулж харвал манай улсын хувьд ДНБ-ий 6 хувьтай нь тэнцэж байна (Зураг 2.14(а)). Энэ нь бүсийн нутгийн ихэнх улс орнуудаас хамгийн өндөр буюу 3 дахин их байна. Гэсэн хэдий ч 2020 онд нийт өрхийн 2 хүрэхгүй хувь нь цар тахлын нөлөөг даван туулахад засгийн газар, төрийн бус байгууллага, бусад эх сурвалжийн тусламжид найдаж байгаагаа илэрхийлсэн. Ядуу өрхүүд тусламжид найдах хандлага бага байгаа боловч ядуу бус өрхийн хувьд мөн адил бага байжээ (Зураг 2.13). Түүнчлэн "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа"-ны үр дүнгээс харахад хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хэрэглэхээс илүүтэй хуримтлуулах хандлага өндөр байжээ. 2020 онд хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан нийт өрхийн гуравны нэгээс илүү хувь нь хүүхдийн мөнгөө ирээдүйд ашиглах зорилгоор хадгаламжид хийсэн гэж хариулсан байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь хүүхдийн боловсрол, эрүүл мэндийг сайжруулах зорилготой байдгийг харгалзан өрхүүд хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулалт хийх илүү магадлалтай юм.

Монгол Улсын хувьд бүс нутгийн бусад улс орнуудтай харьцуулахад цар тахлыг даван туулах ямар нэг арга ашигласан байдал бага байна. 2020 онд арван өрх тутмын нэг нь цар тахлын нөлөөллийг даван

туулахын тулд ямар нэг арга ашигласан гэж хариулсан бол ядуу өрхүүд цар тахлыг даван туулахад илүү тусламжид найдах хандлагатай байна. Ядуу болон ядуу бус өрхүүдийн даван туулах арга ашиглалт ерөнхийдөө бага байна (Зураг 2.13). Энэ үр дүн нь 2020 он болон 2020 оны 4 дүгээр улирлын хөл хорионы үед ч ялгаагүй өрхүүд даван туулах ямар нэгэн арга ашиглаагүй байх магадлалтайг харуулж байна. Лавлагаа хугацаа болон судалгааны цаг хугацааны зөрүүгээс шалтгаалан 2020 оны ӨНЭЗС-ны үр дүнтэй шууд харьцуулах боломжгүй байгаа ч "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа"-ны үр дүнгээр манай улсын хүн амын хувьд цар тахлыг даван туулахдаа засгийн газрын дэмжлэг тусламжид найдсан хувь бүс нутгийн бусад улсуудаас хамгийн бага байна²⁰ (Зураг 2.14(б)). Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох ижил төстэй судалгааг 2020 онд зохион байгуулсан бүсийн бусад улс орнуудын хувьд цар тахлыг даван туулах ямар нэгэн арга хэрэглэхээс гадна Засгийн Газрын тусламжаас ихээхэн хамааралтай байв. Энэ үр дүнгээс харахад манай улсын хувьд хүн амын хэрэглээний өсөлт бага байгаа нь 2018-аас 2020 оны хооронд өрхийн хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр тэтгэмжийн орлогын мэдэгдэхүйц өндөр өсөлттэй байгаатай харьцуулахад сонирхол татахуйц харагдаж байна.

²⁰ 2020 оны ӨНЭЗС-ны асуулга болон судалгааны мэдээлэл цуглуулах хугацаа ялгаатай зэргээс шалтгаалан хариулагчид "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа"-нд даван туулах арга замын талаар илүү мэдээлсэн байх боломжтой юм.

Зураг 2.13 КОВИД-19 цар тахлыг даван туулах ямар нэгэн арга хэрэглэсэн өрхийн хувь, аргын төрлөөр




Тайлбар: Түүвэр нь ӨНЭЗС-ны КОВИД-19 модулийн 2020 оны 2-4 дүгээр улиралд хамрагдсан өрх


Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

Зураг 2.14 КОВИД-19 цар тахлын үед өрхөд үзүүлсэн тусламж, даван туулах арга зам ашиглалт, бүс нутгийн орнуудаар

(а) КОВИД-19 цар тахлын үед өрхөд үзүүлсэн тусламж, дэмжлэг, ДНБ-д эзлэх хувиар, бүс нутгийн орнуудаар



(б) Даван туулах арга зам ашигласан өрхүүдийн хувь, КНТӨСС, бүс нутгийн орнуудаар




Тайлбар: Зураг Б-д 2020 оны ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулах хугацааны ялгаатай байдлаас шалтгаалан хариулагчид "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа"-нд даван туулах арга замын талаар илүү мэдээлсэн байх боломжтой юм. 2020 онд "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа"-г нэгээс олон давтамжтайгаар явуулсан улс орны хувьд дундаж утга нь үе шат болгоны дундаж юм.

Эх үүсвэр: Зураг А - ДБ-ны мэргэжилтнүүдийн тооцоолол, Зураг Б - "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа" - 1-ээс 3-р үе шат, 2020 онд ДБ-наас зохион байгуулж явуулсан "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа"-нд үндэслэсэн зохиогчийн тооцоолол

2018-аас 2020 оны хоорондох өрхүүдийн орлого, хэрэглээний зөрүүтэй чиг хандлагаас харахад өрхүүд ялангуяа хамгийн ядуу 40 хувийн өрхүүд цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хуримтлалаа нэмэгдүүлсэн байх магадлалтайг харуулж байна. Өмнө дурдсанчлан өрхийн нэг хүнд ногдох сарын дундаж бодит орлого 2018-аас 2020 оны хооронд мэдэгдэхүйц нэмэгдэж, ядуу өрхүүдийн хувьд өсөлтийн хурд өндөр байв (Зураг 2.8(б)).

Өрхийн орлого мэдэгдэхүйц өссөн хэдий ч 2018-2020 оны хооронд хэрэглээний өөрчлөлт бага байсан. Үүний үр дүнд 2020 онд өрхүүдийн хэрэглээний ахиу хандлага ерөнхийдөө буурч, хамгийн бага хэрэглээтэй 20 хувьд багтаж буй өрхүүдийн хэрэглээнд хамгийн их бууралт ажиглагдсан байна (Зураг 2.15). Бүлэг 1.1-т дурдсанчлан "судалгааг-судалгаанд" орлуулах аргачлал нь хэрэглээг тооцохдоо алдаа гаргаж хэрэглээний ахиу хандлагын бууралтын хэмжээг нэмэгдүүлсэн байж болох ч хандлагаас харахад ядуу өрхүүд энэ хугацаанд цар тахлаас шалтгаалан хуримтлал үүсгэх хандлагатай байсан байж магадлалтай байна.

Зураг 2.15 Хэрэглээний ахиу хандлага, хэрэглээний тэнцүү таван бүлгээр, 2014-2020 он



Тайлбар: 2020 оны хэрэглээг орлуулснаас шалтгаалан түрээсийн орлуулсан утгыг тооцолгүйгээр ахиу хэрэглэх хандлагыг тооцох боломжгүй юм. Зурагт үзүүлсэн ахиу хэрэглэх хандлага нь өндөр үнэтэй байшинд амьдардаг чинээлэг өрхүүдийн хувьд илүү өндөр байна.



Эх үүсвэр: ӨНЭЭС 2014-2020

ӨНЭЭС-ны мэдээллээс харахад өрхийн хуримтлал бий болгох идэвх 2018-аас 2020 оны хооронд нэмэгдсэн ба ялангуяа ядуу өрхүүдийн хувьд цар тахлаас шалтгаалан илүү өссөн байна. 2018 оноос 2020 онд нийт өрхөд хуримтлал үүсгэсэн өрхийн эзлэх хувь 18 хувиас 27 хувь болж өссөн байна. Ялангуяа бага хэрэглээтэй 40 хувьд багтаж байгаа өрхүүдийн хуримтлал үүсгэх магадлал өндөр өссөн ба хуримтлал үүсгэсэн өрхийн эзлэх хувь хамгийн бага хэрэглээтэй 20 хувьд бараг 3 дахин, 2 дахь бага хэрэглээтэй 20 хувьд 2 дахин өссөн байна (Зураг 2.16(а)). Мөн 2018-аас 2020 онд хадгаламжийн дундаж хэмжээ (бодитоор) 17 хувиар нэмэгдэж, 2016-аас 2018 онтой харьцуулахад бага хэрэглээтэй 40 хувьд багтаж буй өрхүүдийн хувьд илүү өссөн байна (Зураг 2.16(б)). Цаашилбал иргэдийн хадгаламжийн нийт үлдэгдэл 2020 оны туршид, ялангуяа сүүлийн хагаст өссөн үзүүлэлттэй байна (Зураг 2.17). Хэдий тийм ч удаан үргэлжилсэн цар тахлын нөлөө болон инфляцийн өсөлтөөс шалтгаалан иргэдийн хадгаламжийн үлдэгдлийн бодит өсөлт 2021 онд огцом буурсан.

Зураг 2.16 Сүүлийн 12 сарын хуримтлал үүсгэсэн байдал, хэрэглээний тэнцүү таван бүлгээр, 2016-2020 он


(а) Сүүлийн 12 сард хуримтлал үүсгэсэн өрхийн нийт өрхөд эзлэх хувь

(б) Өрхийн сарын нийт хадгаламжийн хэмжээ, 2020 оны үнээр



Эх үүсвэр: ӨНЭЭС 2016-2020

Зураг 2.17 Санхүүгийн байгууллагууд дахь иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, 2016-2020




Эх үүсвэр: Монголбанк, ҮСХ

Тайлбар: Хадгаламжийн үлдэгдлийг инфляциар засварласан (2020=100)

2018-аас 2020 оны хооронд нийт өрхийн зээл авах хандлага буурсан хэдий ч 2020 онд ядуу өрхүүд цар тахлыг даван туулахын тулд зээлд найдах магадлал өндөр байсныг нотлох баримт харуулж байна.

Нийт өрхөд сүүлийн 12 сард зээл авсан өрхийн эзлэх хувь 2020 онд 2018 оноос бага, улирал бүр буурсан байна (Зураг 2.18). Гэсэн хэдий ч өмнөх жилүүдээс ялгаатай нь 2020 онд зээл авсан ядуу өрхийн хувь, ядуу бус өрхөөс илүү байсан (Зураг 2.18). Мөн КОВИД-19 модуль судалгааны үр дүнгээс харахад ядуу өрхүүд цар тахлын сөрөг нөлөөг даван туулахын тулд албан болон албан бус зээл авах хандлагатай байсныг харуулж байна (Зураг 2.13). Бусад зээлийн хувьд лизингийн зээл, бизнесийн зээл өссөн ч малчны зээл нэмэгдсэн нь ядуу өрхүүдийн зээл авалт идэвхжихэд гол нөлөө үзүүлсэн ба нийт өрхөд малчны зээл авсан өрхийн эзлэх хувь 2018-аас 2020 оны хооронд 8-аас 11 хувь болж өссөн байжээ. Өрхүүдийн зээл авсан үндсэн зорилго нь өрхийн хэрэглээ, хувийн бизнесээ санхүүжүүлэхэд чиглэсэн байв.


Зураг 2.18 Сүүлийн 12 сард зээл авсан өрхийн эзлэх хувь, улирлаар



Эх үүсвэр: ӨНЭЗС 2018-2020

Цар тахлын урт хугацааны нөлөөллийн тодорхой дүр зургийг 2022 оны ӨНЭЗС-гаар гаргах боловч 2020 оны ӨНЭЗС-ны мэдээлэл болон 2021 оны тоо баримтууд нь цар тахал ядуу өрхөд ялангуяа хот суурин газар оршин суудаг ядуу өрхүүдэд урт хугацааны туршид нөлөө үзүүлж болзошгүйг илэрхийлж байна. Ерөнхийдөө цар тахал 2020 онд өрхийн орлогын өсөлтийг бууруулаагүй хэдий ч өрхүүд урьдчилан сэргийлэх зорилгоор хуримтлалаа нэмэгдүүлсэн нь өрхийн хэрэглээний өсөлтийг удаашруулсан байна. Мөн тоо баримтаас харахад ерөнхийдөө цар тахлын өрхийн орлогод үзүүлсэн нөлөө 2020 онд 2021 он шиг хүчтэй байгаагүйг харуулсан. Гэсэн хэдий ч ядуу өрхүүд цар тахлын нөлөөнд илүү удаан хугацаанд өртөж болзошгүйг тэдний өгсөн мэдээллээс харж болохоор байна. Тодруулбал өрхүүд цар тахлыг даван туулах ямар нэг арга ашиглах нь бага байсан боловч ядуу өрхүүд цар тахлын хариу арга хэмжээнд зээл авах эсвэл хооллолтын хэлбэрээ өөрчлөх хандлагатай байжээ (Зураг 2.13). Нэмж дурдахад “Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”-ны үр дүнгээс харахад цар тахлын үе буюу 2020 онд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нийт өрхийн талаас илүү хувьд нөлөөлсөн нь өрхөд хамгийн түгээмэл тохиолдсон хүндрэл бэрхшээлийн нэг байсан. Хүнсний аюулгүй байдлын алдагдал ерөнхийдөө бага байсан хэдий ч 2020 оны хөдөлгөөний хатуу хязгаарлалтын үед илүү байх магадлалтай байв. Ядуу өрхүүдэд хүнсний аюулгүй байдал алдагдах магадлал өндөр байв. Тухайлбал, 2020 оны ӨНЭЗС-нд мэдээлснээр сүүлийн 30 хоногт хоол хүнсээ авч чадаагүй ядуу өрх ядуу бус өрхүүдээс 3.2 нэгж хувиар илүү, харин хангалттай хоол хүнс авах эсэхдээ санаа зовж байна гэж хариулсан нь 4.7 нэгж хувиар илүү байжээ (Зураг 2.19). Хотын өрхүүд, ялангуяа Улаанбаатар хот болон ОХУ-тай хил залгаа бүсийн өрхүүд хөдөө орон нутгийн өрхүүдээс илүү хоол хүнс худалдаж авахад хүндрэлтэй тулгарсан ба хотын өрхүүд хөдөө орон нутгийн өрхүүдээс дөрөв дахин илүү хоол хүнс худалдаж авах боломжгүй байсан гэж мэдээлсэн байна. Хүнсний аюулгүй байдал удаан үргэлжилбэл өрхүүдэд хор хөнөөлтэй, ялангуяа бага насны хүүхэдтэй өрхүүд, тэдгээрийн эрүүл мэндэд мэдэгдэхүйц хохирол учруулж болзошгүй юм.

Зураг 2.19 Өрхүүдийн сүүлийн сарын хүнсний хангамжийн санаа зовиол



Тайлбар: Түүвэр нь ӨНЭЗС-ны КОВИД-19 модулийн 2020 оны 2-4 дүгээр улиралд хамрагдсан өрх

Эх үүсвэр: ӨНЭЗС 2020

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Adams, Richard Jr. 2004. "Economic Growth, Inequality and Poverty: Estimating the Growth Elasticity of Poverty." *World Development*, Elsevier, vol. 32(12), 1989-2014.
- Azevedo, Joao Pedro; Inchauste, Gabriela; Olivieri, Sergio; Saavedra, Jaime; Winkler, Hernan. 2013. "Is labor income responsible for poverty reduction? a decomposition approach". Policy Research working paper; no. WPS 6414. Washington, DC: World Bank.
- Angrist, J. and W. Evans. 1998. "Children and their Parents' Labor Supply: Evidence from Exogenous Variation in Family Size," *American Economic Review* 88(3), 450-477.
- Barros, Ricardo Paes, Mirela de Carvalho, Samuel Franco, and Rosane Mendonça. 2006. "Uma Análise das Principais Causas da Queda Recente na Desigualdade de Renda Brasileira." In: *Revista Econômica* 8 (1): 117-147. Rio de Janeiro: Universidade Federal Fluminense.
- Beegle, K., Joachim De Weerd, J. Friedman, J. Gibson. 2010. "Methods of household consumption measurement through surveys: experimental results from Tanzania." Policy Research Working Paper. No. 5501. Washington, DC: World Bank.
- Datt, Gaurav, and Martin Ravallion. 1992. "Growth and Redistribution Components of Changes in Poverty Measures: A Decomposition with Applications to Brazil and India in the 1980s." *Journal of Development Economics*, 38: 275-296.
- Jolliffe, Dean. "Measuring Absolute and Relative Poverty: The Sensitivity of Estimated Household Consumption to Survey Design." *Journal of Economic and Social Measurement* Volume 27, no. Numbers 1-2 (2001): 1-23.
- Foster, Greer and Thorbecke. 1984. "A Class of Decomposable Poverty Measures." *Econometrica* 52 (3): 761-65.
- Inchauste Comboni, Maria Gabriela; João Pedro Azevedo, B. Essama-Nssah, Sergio Olivieri, Trang Van Nguyen, Jaime Saavedra-Chanduvi and Hernan Winkler. 2014. "Understanding changes in poverty". Washington, DC: World Bank Group.
- Kolenikov, Stanislav, and Anthony Shorrocks. 2005. "A Decomposition Analysis of Regional Poverty in Russia." *Review of Development Economics* 9 (1):25-46.
- Үндэсний статистикийн хороо 2017. "Ядуурлын дүр төрх-2016".
- Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк 2018. "Ядуурлын дүр төрх-2018".
- Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк 2020. "Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа (1-ээс 5-р үе шат). <https://www.worldbank.org/en/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia>
- Ravallion, Martin, and Monika Huppi. 1991. "Measuring Changes in Poverty: A Methodological Case Study of Indonesia during an Adjustment Period." *The World Bank Economic Review* 5 (5): 57-82.
- Rubin, D. B. 1987. *Multiple Imputation for Nonresponse in Surveys*. Wiley. New York.
- Schafer, J. 1999. "Multiple Imputation: a Primer." *Statistical Methods in Medical Research* 8: 3-15.
- Yoshida, N., R. Munoz, A. Skinner, C. Kyung-eun Lee, M. Brataj, and D. Sharma. 2015. "SWIFT Data Collection Guidelines version 2." The World Bank.
- Yoshida, N., X. Chen, S. Takamatsu, K. Yoshimura, S. Malgioglio, S. Shivakumaran, K. Zhang, and D. Aron. 2021. "The Concept and Empirical Evidence of SWIFT Methodology." The World Bank.
- World Bank. 2009. "Mongolia: Livestock sector study VOLUME I – SYNTHESIS REPORT", Washington, DC: World Bank.
- World Bank. 2016. "Mongolia: Progress in Reducing Poverty and Boosting shared prosperity, 2010-2014?", Washington, DC: World Bank.
- World Bank. 2018a. *Poverty and Shared Prosperity 2018: Piecing Together the Poverty Puzzle*. Washington, DC: World Bank.
- World Bank. 2018b. *Riding the Wave: An East Asian Miracle for the 21st Century*. World Bank East Asia and Pacific Regional Report;. Washington, DC: World Bank.
- World Bank. 2019. *Mongolia Systematic Country Diagnostic*. Washington, DC: World Bank.
- World Bank. 2020. *Poverty and Shared Prosperity 2020: Reversals of Fortune*. Washington, DC: World Bank.
- World Bank. 2021. *Mongolia Economic Update, February 2021: From Relief to Recovery*. World Bank.
- World Bank. 2022. *Mongolia Economic Update, April 2022: Navigating Stronger Headwinds*. World Bank.

ХАВСРАЛТ А. 2020 ОНЫ ЯДУУРЛЫН ТООЦООНЫ АРГА ЗҮЙ

2020 ОНЫ ЯДУУРЛЫГ ОРЛУУЛАХ АРГА ХЭРЭГЛЭН ТООЦОХ НЬ

“Судалгааг-судалгаанд” (survey to survey) орлуулах арга ашиглан 2020 оны ядуурлын түвшинг тодорхойлоходоо өмнөх судалгааны үр дүнгүүдтэй харьцуулагдах боломжтой байхаар тооцсон. Энэ аргачлалын техникийн хавсралтад 2020 оны ядуурлын тооцоонд ашигласан загварын арга зүйн үе шатуудын дэлгэрэнгүй тайлбарыг оруулсан болно. Энэхүү тооцооны зорилго нь 2020 онд улс, хот, хөдөө, аймгийн түвшинд өмнөх жилүүдтэй харьцуулагдахуйц ядуурлын тооцоог хийх байв.

ТООЦОО ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Хэрэглээний судалгааны асуулгыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсруулах, хүн амын хэрэглээний хэв шинжийн өөрчлөлтийг бүрэн тусгах зорилгоор 2020 оны судалгааны асуулгад хэд хэдэн өөрчлөлт, сайжруулалт хийсэн байв. Тухайлбал судалгааны хүнсний хэрэглээний мэдээлэл цуглуулах хугацаа өөрчлөгдсөн, хэрэглээний бүтцэд хэд хэдэн нэр төрөл нэмэгдсэн зэрэг нь 2020 оны хүн амын хэрэглээг 2010-2018 оны хэрэглээтэй харьцуулах боломжгүй болгосон байх магадлалтай байна. Судалгааны хамрах хугацаа, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өөрчлөлт нь өрхийн хэрэглээг тооцоход багагүй нөлөө үзүүлсэн байх боломжтой²¹. Иймд уг аргачлал нь 2020 оны хүн амын хэрэглээг өмнөх жилүүдийн ӨНЭЗС-тай харьцуулах боломж олгож буй юм. ӨНЭЗС-ны 2020 оны загварт оруулсан өөрчлөлтийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

Хүнсний хэрэглээ - Өрхийн хүнсний хэрэглээг хот, суурин газрын өрхийн хувьд 1 сарын турш өдрийн тэмдэглэл хөтлүүлэн тооцдог байсан бол 2020 оны ӨНЭЗС-гаар өдрийн тэмдэглэл хөтлөлтийг 7 хоног болгосон (хөдөө, орон нутгийн өрхүүдийн хувьд 7 хоногоор сануулан тэмдэглэл хөтлүүлдэг байсан нь өөрчлөгдөөгүй).

Өрхийн орлого, зарлагын судалгааны асуулгад олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор энэхүү өөрчлөлтийг хийсэн юм. Хэд хэдэн судалгаанаас харахад, хүнсний хэрэглээний тэмдэглэл хөтлөх хугацаа урт байх тусам хэрэглэгч залхах²² тохиолдол хамгийн түгээмэл ажиглагдсан учраас тооцооллын алдаа гарахаас сэргийлэх зорилгоор уг хугацааг долоо хоног болгон багасгасан²³.

Хүнсний бус хэрэглээ – 2020 оны ӨНЭЗС-нд багтсан хүнсний бус бүтээгдэхүүний тоог 362-оос 270 хүртэл цөөлсөн ба ихэвчлэн нарийвчилсан эд зүйлсийг бүлэглэн ерөнхийлөн ангилсан (жишээ нь: тус тусдаа байсан эрэгтэй, эмэгтэй болон хүүхдийн хувцсыг нэгтгэн бэлэн хувцас болгосон). Өрхийн хэрэглэсэн өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нарийвчилсан хэмжээ нийт хэрэглээний тооцооллд нөлөөлөх магадлал өндөр байдаг. Тухайлбал, хэд хэдэн судалгаагаар бүтээгдэхүүний нарийвчилсан жагсаалтаар цуглуулсан мэдээлэл нь хэрэглээ өндөр гарах шалтгаан болохоос гадна ядуурлын түвшинд нөлөөлж байна гэж үздэг (Beegle, 2010; Jolliffe, 2001).

Гэрээс гадуур хооллох – Өрхийн гишүүдийн гэрээс гадуур хооллолт ихэсч байгаагаас шалтгаалан (ялангуяа хотын өрхүүд) гэрээс гадуур хооллолтод өрхөөс гарч буй зардал, хэрэглээг тодорхойлох зорилгоор хүнсний хэрэглээний модулийг өргөжүүлсэн. Тодруулбал, тухайн өрхийн гишүүдийн гадуур хооллосон талаарх илүү нарийвчилсан асуулт оруулав.

2020 онд ядуурлын түвшинг орлуулан тооцох болсон шалтгааны нэг нь 2020 оны ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулалтын ихэнх хэсгийг Ковид-19 цар тахлын үеэр хийсэнтэй холбоотой юм. Хөл хорионы үеэр хийгдсэн тул 2020 оны ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулалтыг хэдэн сарын турш утсаар холбогдон хийсэн. 2020 оны эхэн үе болон зуны улирлын хугацаанд CAPI (Computer assistance personal interviewing)-г ашиглан мэдээллийг биечлэн цуглуулсан бол Улаанбаатар, Орхон зэрэг хот суурин газруудад мэдээллийг 2-12-р сар хүртэл утсаар холбогдон цуглуулсан.

²¹ Beegle, ... нарыг (2010) үзнэ үү.

²² Залхах, санахгүй байх болон бусад хүчин зүйлс нь хэрэглээний тоон мэдээ цуглуулахад гардаг нийтлэг алдаа юм. Хэрэглээний тоон мэдээ цуглуулахад тулгардаг бэрхшээл болон ашигладаг арга хэрэгслийн тухай үзэх бол Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага болон Дэлхийн банк (2018) “Өрхийн хүнсний хэрэглээ болон зардлын тоон мэдээ цуглуулах” болон Beegle (2010)-ийг үзнэ үү.

²³ ӨНЭЗС 2018-ын Хүнсний хэрэглээний тоон мэдээлэлд хийсэн шинжилгээнээс үзэхэд хотын өрхүүдэд залхах байдал түгээмэл байлаа. Шинжилгээнээс харахад дунджаар 2018 оны ӨНЭЗС-д хамрагдсан өрхүүдийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл цаг хугацаа өнгөрөх тусам багасаж байсан ба 10 хоног тутам судлаач очиж байсан боловч сайжрахгүй байв. Гэсэн хэдий ч өрхүүдийн хүнсний хэрэглээг дутуу тайлагнасан нь ядуурлын тооцооллод асуудал үүсгээгүй байх талтай. Харин 2020 оны ӨНЭЗС судалгаанд мэдээллийг богино хугацаагаар цуглуулсан учраас хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ болон хэрэглэсэн калорийн хэмжээгээ дутуу дулимаг мэдээлэх байдал бага байлаа.

ОРЛУУЛГЫН АРГА ЗҮЙ

2020 оны өрхийн хэрэглээ, ядуурлын түвшинг өмнөх жилүүдтэй харьцуулан тооцох үүднээс Survey of Well-being via Instant and Frequent Tracking (SWIFT) Plus²⁴ (Yoshida, болон бусад.,2021) буюу орлуулах аргыг ашиглав. 2018 оны ӨНЭЗС-нд хэрэглээг мөнгөн бус үзүүлэлтээр тооцох загвар боловсруулж, энэхүү загварчлалыг 2020 оны хэрэглээ ядуурлыг тооцох зорилгоор 2020 оны ӨНЭЗС-нд ашигласан. ӨНЭЗС-ны 2018, 2020 оны мөнгөн бус үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулах боломжтой байсан тул уг аргыг ашигласан бөгөөд харин хэрэглээний мэдээллийг ашиглах боломжгүй байв.

Аймгийн түвшний үнэлгээг сайжруулах зорилгоор аймгуудыг бүлэглэн тус бүрт өөр өөр загварчлалыг тусгайлан боловсруулсан. Тухайлбал, аймгуудын хот, суурин газар, хөдөөгийн газарзүйн байршил, амьжиргаа, мөнгөн ба мөнгөн бус нийгмийн халамж зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж аймгуудыг хот, хөдөөгийн бүлэгт ангилсан. Аймаг хоорондын хот, суурин болон хөдөөгийн ялгаа их бөгөөд түүврийн хэмжээ нь бага байсан тул аймаг тус бүрээр загвар боловсруулахын оронд ийнхүү бүлэглэсэн. Мөн үнэлгээний үнэн бодит байдлыг нэмэгдүүлэх зорилгоор аймгуудын дамми хувьсагчдыг тооцоонд оруулав. Өрхийн хэрэглээ болон мөнгөн бус үзүүлэлтүүд нь хот, хөдөөд ихэвчлэн ялгаатай байдаг тул загварыг хот, хөдөөд тусад нь бэлтгэв. Түүнчлэн энэхүү аргачлалаар хот, хөдөөгийн ядуурлын түвшинг тодорхойлох боломжтой²⁵. Хэд хэдэн ангиллаар бүлэглэн үзсэний эцэст хотын 8 (Улаанбаатар хот тусдаа 1 бүлэг), хөдөөгийн 6 бүлэг буюу нийт 14 бүлэгт хуваав. 2020 оны тооцооллод 14 бүлгийг хэрхэн ашигласныг Зураг А.1-т харуулав.

Зураг А.1 Хот/Хөдөө аймгуудыг бүлэгт хуваасан байдал

(а) Хотын бүлэг



²⁴ SWIFT Plus нь SWIFT (Yoshida, 2015)-ийн өргөтгөсөн хувилбар ба өрхийн амьжиргаа болон ядууралд үзүүлэх цар тахлын нөлөө гэх мэт эдийн засгийн гэнэтийн шокуудын нөлөөг олж тусгахыг зорьдог.

²⁵ Гэхдээ тус аргаар аймгийн төв, сумын төв болон хөдөөгийн ядуурлын түвшинг тооцон гаргах боломжгүй.

(б) Хөдөөгийн бүлэг



Тайлбар: ӨНЭЭС-нд Орхон, Улаанбаатар нь хот гэж тооцогддог тул хөдөөгийн аль ч бүлэгт хамаарахгүй.

Шигтгээ 1. Ядуурлын тооцоондоо SWIFT plus аргыг ашигласан жишээ:

Өрхийн амьжиргаа, ядуурлыг тооцоход SWIFT аргыг өргөн ашигладаг. Ялангуяа SWIFT Plus (Yoshida, болон бусад., 2021) аргыг Ковид-19 цар тахлын үеийн ядуурлын албан ёсны түвшинг тооцоход ашиглаж байна (Шигтгээ Хүснэгт 1).

Шигтгээ Хүснэгт 1: SWIFT plus аргаар хийсэн ядуурлын тооцоо

Улс	Сэдэв	Арга, аргачлал	Төлөв
Бүгд Найрамдах Ардчилсан Конго	Албан ёсны ядуурлын тооцоо	SWIFT Plus	Хийгдэж байгаа
Ботсвана	Албан ёсны ядуурлын тооцоо	SWIFT Plus	Хийгдэж байгаа
Хондурас	Албан ёсны ядуурлын тооцоо	SWIFT Plus	Хийгдэж байгаа
Зимбабве	Албан ёсны ядуурлын тооцоо	SWIFT 2.0	Хийгдэж дууссан
Зимбабве	Ковид-19-н өндөр давтамжтай утасны судалгаа	SWIFT Plus	Хийгдэж дууссан
Руанда	Ковид-19-н өндөр давтамжтай утасны судалгаа	SWIFT Plus	Хийгдэж дууссан
Сомали	Ковид-19-н өндөр давтамжтай утасны судалгаа	SWIFT Plus	Хийгдэж дууссан
Малави	Ковид-19-н өндөр давтамжтай утасны судалгаа	SWIFT Plus	Хийгдэж дууссан
Этиоп	Ковид-19-н өндөр давтамжтай утасны судалгаа	SWIFT Plus	Хийгдэж дууссан
Сент-Люси	Ковид-19-н өндөр давтамжтай утасны судалгаа	SWIFT Plus	Хийгдэж дууссан
Этиоп	Олон улсын санхүүгийн корпорацийн төсөл: Зорилтот бүлэгт чиглэсэн ядуурлын тооцоо	SWIFT Plus	Хийгдэж дууссан
Нигери	Олон улсын ядуурлын шугам 1.9 PPP долларын ядуурлын тооцоо	SWIFT Plus	Хийгдэж дууссан

Дараах 5 алхмын хүрээнд 14 бүлгийн тооцоолол хийв.

1. Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагчдыг тодорхойлох
2. Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөг хувьсагчдыг тодорхойлох
3. 2018 оны ӨНЭЗС–г ашиглан хувьсагчдыг сонгох, загвар боловсруулах
4. 2020 оны өрхийн хэрэглээг орлуулан тооцох
5. 2016 оны ӨНЭЗС–г ашиглан тооцооллын чанарт үнэлэлт хийн баталгаажуулах

1-р алхам: Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагчдыг тодорхойлох нь

Тооцооллын гажилтгүй зөв байдлыг хангахын тулд өрхийн хэрэглээний харьцуулагдахуйц байдлыг бий болгох нь маш чухал юм. Тиймээс бид эхний алхмын хүрээнд 2018 болон 2020 оны ӨНЭЗС-ны хооронд харьцуулагдахуйц цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй болон өөрчлөгддөг хувьсагчдыг авч ашиглалаа. Ингэхдээ ерөнхий 5 бүлэг хувьсагчдыг цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагч болгон ашиглав. Үүнд: аймгуудын дамми хувьсагч, өрхийн хүн ам зүй, өрхийн тэргүүлэгчийн шинж байдал, амьдарч буй сууцны нөхцөл, өмчилж буй мал/хөрөнгө зэрэг багтана. Эдгээр хувьсагч нь бага болон дундаж орлоготой орнуудын өрхийн хэрэглээтэй сайн уялддаг (Yoshida, 2015). Хэдийгээр эдгээр хувьсагчид нь сүүлийн үеийн шок, эдийн засгийн нөхцөл байдалд хурдан өөрчлөгдөхгүй ч дунд ба урт хугацаанд өрхийн хэрэглээ, ядуурлыг сайн таамагладаг байна.

Дараах нөхцлийн хүрээнд харьцуулагдахуйц байдлыг шалгав: i) асуулга, мэдээллийг цуглуулсан байдал, ii) 2016, 2018, 2020 оны ӨНЭЗС-ны үр дүнгийн дундаж утгын чиг хандлага. Жагсаалтаас цөөн хувьсагчдыг дараах шалтгааны улмаас аймгийн бүлгээс хасав. 1) Цаг хугацааны дундаж утга тогтвортой бус, 2) Хэт бага (хүн амын 5 хувиас бага) эсвэл хэт өндөр дундаж утга (хүн амын 95 хувиас их), 3) Мультиколлинеар байдал.

2-р алхам: Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөг хувьсагчдыг тодорхойлох нь

Хоёрдугаарт, бид 2018 болон 2020 оны ӨНЭЗС-ны хооронд харьцуулагдахуйц цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөг хувьсагчдыг тодорхойлно. Хэрэглээг илэрхийлэх хувьсагч нь Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдал, эдийн засгийн шок гэх мэт

хүчин зүйлээс ихээхэн хамаардаг нь урт хугацаанд (цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагч) өөрчлөлтийг харуулдаг сууцны нөхцөл, өмч хөрөнгө болон өрхийн амьжиргааны бусад хүчин зүйлс зэргээс ялгаатайгаараа онцлогтой. Тухайлбал, цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагч болох өрхийн тэргүүний боловсролын түвшин эсвэл өрхийн хэрэглэж буй гэрэлтүүлгийн төрөл зэрэгт цар тахлын улмаас богино хугацаанд өөрчлөлт орохгүй. Хэдий тийм ч орлогын эх үүсвэрээ алдсан үед өрхүүд мах, хувцас гэх мэт зүйлсийн хэрэглээгээ танаж эхэлдэг байна. Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагчтай харьцуулахад өөрчлөгддөг хувьсагч нь ядууралтай дундаж хамааралтай байж болох ч, өрхийн амьжиргааны үзүүлэлтийн хэлбэлзлийг илэрхийлэх богино хугацааны өөрчлөлтийг тусгах тал дээр хэрэгцээтэй байдаг.

Энэ алхмын хүрээнд бид 2018, 2020 оны судалгаа хооронд харьцуулагдахуйц өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд илүү мэдрэмтгий үзүүлэлтүүд болох хүнсний хэрэглээ, хүнсний бус хэрэглээ, өрхийн тэргүүний хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг хувьсагчдыг тодорхойлов. 2018, 2020 оны²⁶ ӨНЭЗС-ны хотын өрхийн хүнсний хэрэглээний өдрийн тэмдэглэлд өөрчлөлт оруулсны улмаас хүнсний хувьсагчдыг зөвхөн хөдөөгийн өрхүүдэд ашиглав. Хэрэглээнд гарсан өөрчлөлт нь амьжиргааны өөрчлөлтөөс илүүтэй цар тахлын үеийн хөл хорио эсвэл халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй (чөлөөт цагаа өнгөрүүлэх үйл ажиллагаа, халдвар хамгааллын бүтээгдэхүүн, урьдчилан сэргийлэх тарилга гэх мэт) холбоотой. Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагчдын адил тодорхой тооны цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөг хувьсагчдыг зарим аймгийн бүлгээс дараах шалтгаанаар хасав: 1) Тогтвортой бус, 2) Хэт бага эсвэл хэт өндөр утга, 3) Мультиколлинеар байдал.

3-р алхам: 2018 оны ӨНЭЗС –г ашиглан хувьсагчдыг сонгох, загвар боловсруулах нь

Гуравдугаар алхмын хүрээнд, аймгийн 14 бүлэг тус бүрт 1, 2-р алхамд тодорхойлсон хувьсагчдыг ашиглан 2018 оны өрхийн хэрэглээний загварыг боловсруулна. Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөг (богино хугацаанд өөрчлөгддөг) хувьсагчдаар цар тахлын үеийн ядуурлыг тооцох боломжтой үндсэн загварыг "Ковидын дараах" загвар хэмээн нэрлэсэн. Уг загвар нь өрхийн дунд болон урт хугацааны амьжиргааг нийцтэй байлгахын тулд цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй (удаан өөрчлөгддөг) хувьсагчдын нэг хэсгийг буюу өрхийн хүн ам зүй, өрхийн тэргүүлэгчийн шинж чанар зэргийг багтаасан.


²⁶ Дүн шинжилгээнээс харахад, хотын өрхүүд 7 өдрийн тэмдэглэлийн дэвтэрээс (2020 он) 30 өдрийн тэмдэглэлийн дэвтэрт (2018 он) илүү олон хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл бичих магадлалтай байна.

SWIFT аргачлалын хүрээнд загвар бүрийг боловсруулан хувьсагчдыг үнэлэхдээ “stepwise” аргыг ашигласан. Ингэхдээ өрхийн нэг хүнд ногдох лог-хэрэглээг төлөөлөх “оновчтой” хувьсагчдын багцыг үүсгэхдээ хувьсагчдын олонлогоос араас нь хасах замаар бий болгосон.

Загвар нь зөвхөн 2018 онд төдийгүй цаг хугацааны явцад ядуурлыг зөв тооцоолох чадвартай байхын тулд загварыг яг цав тааруулан боловсруулах асуудлаас зайлсхийн “10-fold cross-validation” аргыг ашиглан ач холбогдлын түвшинг тогтоосон (5-10 хувийн хооронд) ба ингэснээр бодит болон урьдчилан тооцоолсон ядуурлын түвшин хоорондын абсолют утгын зөрүүг багасгасан. Оновчтой ач холбогдлын түвшинг ашиглан хувьсагчдыг тодорхойлохдоо stepwise OLS регрессийн аргыг ашигласан.

Дараа нь тус загварыг Rubin (1987) болон Schafer (1999) нарын боловсруулсан олон удаа орлуулах (Multiple imputation, MI) аргаар өрхийн хэрэглээг таамагласан ба хазайлт болон стандарт алдааг тооцох боломжтой болдог. Тухайлбал, үнэлэгдсэн хувьсагчдад харгалзах коэффициентуудыг ашиглан өрхийн хэрэглээний түвшинг үнэлнэ. Олон удаа орлуулах энэхүү симуляцийн үйл явц нь өрх бүрийн хувьд 20 удаа давтагдах бөгөөд 20 хэрэглээний вектор үүснэ. Хэрэглээний вектор бүрийг ашиглан ядуурлыг тооцохдоо 20 векторын дунджаар тооцно. Уг аргыг аймгийн бүлэг тус бүрт ашигласнаар нийт 14 загвар, мөн ядуурлын түвшинг гаргана.

Зураг А.2 2018 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, бүлгээр



Тооцсон загварын гүйцэтгэлийг үнэлэхдээ 2018 оны хэрэглээ, ядуурлын түвшний орлуулж тооцсон утгыг бодит утгатай нь харьцуулсан. Ерөнхийдөө симуляци хийсэн тооцоо нь бодит утгатай маш ойролцоо байна. Зураг А.2-т үзүүлсэнээр нэг хүнд ногдох хэрэглээ болон ядуурлын орлуулж тооцсон утга нь 2018 оны бодит утгатай ойрхон буюу бүх бүлгийн хувьд 5%-ийн түвшинд статистикийн хувьд ач холбогдолгүй байна.


Бүлэг тус бүрийн тооцоог нэгтгэснээр улс, хот, хөдөө, аймгийн түвшний өрхийн хэрэглээ, ядуурлын түвшинг тооцох боломжтой. Зураг А.3 болон Хавсралт Б.2-оос харахад²⁷ загварууд газарзүйн түвшинд 2018 оны хэрэглээ, ядуурлыг орлуулан тооцсон үр дүнгээс сайн таарсан нь харагдаж байна. Нутаг дэвсгэр тус бүрийн хувьд орлуулан тооцсон ядуурлын түвшин нь 95% итгэх интервалын дотор байна. Ядуурлын түвшин нь улс, хот, орон нутгийн түвшинд бодит түвшингээс (Зураг А.3) 0.1-0.2 нэгж хувиар бага байна. Өмнөговь болон Дархан-Уул зэрэг зарим аймаг дахь ядуурлын түвшингийн зөрүү их байгаа ч 5%-ийн түвшинд статистикийн хувьд ялгаа байхгүй байна²⁸.

Тайлбар: Зураг А.1-ээс аль бүлэгт ямар аймаг байгааг харна уу.

²⁷ Зөвхөн Булган аймгийн орлуулж тооцсон хэрэглээ нь бодит хэрэглээний 95%-ийн итгэх интервалд багтаагүй. Гэхдээ тооцоолсон ядуурлын түвшин нь бодит түвшингээс статистикийн хувьд ялгаатай биш болно.

²⁸ Энэхүү ач холбогдлын шалгалт нь ердийнхөөс илүү хатуу гэдгийг анхаарах хэрэгтэй. Учир нь Олон удаа орлуулах арга нь тооцоолж буй ядуурлын түвшний стандарт алдааг тооцдоггүй.

Зураг А.3 2018 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар



4-р алхам: 2020 оны өрхийн хэрэглээг орлуулан тооцох нь

Өмнөх алхамд ашигласан загварын дагуу олон дахин орлуулах аргаар өрхийн хэрэглээ болон ядуурлыг 2020 оны түвшинд үнэлэх боломжтой. Өмнөх алхамын адил үр дүнд нь 20 хэрэглээний вектор үүсэх ба хэрэглээний вектор бүрийг ашиглан ядуурлыг тооцоходоо 20 векторын дунджаар тооцно. Мөн адил аймгийн бүлгүүдийг нэмж, бүлгүүдийн дунжийг авах замаар улс, хот, хөдөө болон аймгийн түвшний тооцооллыг хийнэ.

Хүснэгт А.1-т 2020 оны ядуурал болон хэрэглээний түвшинг орлуулгын аргаар үнэлсэн байгааг харуулсан ба ядуурлын түвшин 27.8 байгаа нь 2018 онтой харьцуулахад 0.6 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Хот болон хөдөөгийн ядуурлын түвшин 2018-2020 оны хооронд бага зэрэг буурсан боловч улс, хот, хөдөөгийн өөрчлөлт нь 5%-ийн түвшинд статистикийн хувьд ач холбогдолгүй байна. Хэдийгээр 2018-2020 оны хооронд ядуурлын түвшин их хэмжээнд өөрчлөгдөөгүй ч цар тахалгүй үед ядуурал ямар түвшинд байхыг таамагласан “Ковид-19 цар тахлын өмнөх” загвараас харахад цар тахлаас үүдэж ядуурлын түвшин өссөн байж болзошгүй байна (Шигтгээ 2). Мөн загвараас үзэхэд хэрэв цар тахалгүй байсан бол ядуурлын түвшин 2020 онд одоогийн үзүүлэлтээс 3.5 нэгж хувиар буурахаар байв.

Хүснэгт А.1 2018 оны бодит болон 2020 оны орлуулж тооцсон хэрэглээ, ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар

	Нэг хүнд сард ногдох хэрэглээ					Ядуурлын түвшин				
	2018 оны бодит	Стандарт алдаа	2020 оны тооцоолсон	Стандарт алдаа	2018-2020 өөрчлөлт	2018 оны бодит	Стандарт алдаа	2020 оны тооцоолсон	Стандарт алдаа	2018-2020 өөрчлөлт
Улсын дундаж	310.4	3.8	311.1	3.3	0.7	28.4	0.7	27.8	0.7	-0.6
Хот	326.5	5.6	328.0	4.6	1.5	27.2	0.9	26.5	0.9	-0.7
Хөдөө	278.9	3.0	276.6	3.3	-2.2	30.8	0.8	30.5	1.1	-0.3
Улаанбаатар	339.8	7.8	339.1	6.4	-0.7	25.9	1.2	25.4	1.2	-0.5
Дорнод	241.5	10.3	270.0	12.3	28.4**	42.5	3.1	37.1	3.8	-5.5
Сүхбаатар	321.5	11.0	311.3	11.7	-10.2	30.2	2.5	24.3	3.2	-5.9**
Хэнтий	274.3	12.6	270.3	11.5	-4.0	38.0	3.1	36.6	3.6	-1.4
Төв	357.5	10.9	343.8	13.8	-13.7	20.5	2.2	19.3	2.7	-1.2
Говьсүмбэр	202.0	8.1	239.6	11.1	37.6**	51.9	4.8	39.8	5.1	-12.0**
Сэлэнгэ	266.4	8.5	274.0	13.9	7.7	34.0	2.5	34.0	4.1	-0.0
Дорноговь	315.4	9.5	329.2	11.8	13.8	23.4	2.5	19.8	2.7	-3.6
Дархан-Уул	276.8	14.3	301.1	15.3	24.3	32.8	4.0	26.7	4.0	-6.0
Өмнөговь	344.8	10.7	329.9	11.5	-14.9	11.8	2.0	16.4	2.9	4.5**
Дундговь	336.0	10.6	285.0	11.4	-50.9**	21.7	2.5	30.7	3.7	8.9**
Орхон	331.9	16.5	332.6	13.6	0.7	25.1	3.2	23.7	3.0	-1.4
Өвөрхангай	262.7	7.1	246.2	7.6	-16.5**	34.1	2.4	36.2	3.1	2.1
Булган	234.3	7.7	247.0	9.2	12.7	36.8	3.1	38.7	4.1	2.0
Баянхонгор	284.4	11.3	253.9	10.3	-30.5**	29.6	2.3	35.7	3.7	6.1**
Архангай	240.7	7.1	261.1	9.5	20.4**	38.2	2.3	32.7	3.1	-5.6**
Хөвсгөл	295.5	10.3	300.0	11.4	4.5	25.3	2.8	26.0	3.1	0.7
Завхан	285.6	7.8	270.4	8.2	-15.2	25.7	2.5	29.2	3.2	3.4
Говь-Алтай	222.4	8.8	227.4	7.7	5.0	45.1	3.3	42.4	3.5	-2.7
Баян-Өлгий	315.0	10.2	321.1	12.6	6.1	24.3	2.2	22.8	2.9	-1.5
Ховд	238.1	7.2	244.7	8.9	6.6	40.9	3.0	39.7	3.3	-1.1
Увс	265.0	7.0	273.5	8.2	8.4	29.6	2.5	30.9	3.1	1.2

Тайлбар: ** - Ач холбогдлын түвшин 5% байгааг илэрхийлнэ

Шигтгээ 2. “Ковид-19 цар тахлын өмнөх” загварыг ашиглан 2020 оны цар тахалгүй үеийн ядуурлыг тооцох нь

Хэдийгээр Ковид-19 цар тахалгүй үеийн ядуурлын түвшинг тооцох боломжгүй ч гэсэн “Ковид-19 цар тахлын өмнөх” загварыг ашиглан загварчлан үзүүлэх боломжтой. Энэхүү ядуурлыг тооцох арга нь “Ковид-19 цар тахлын дараах” загвартай адил боловч цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагчдаар хязгаарлагдана. Дараах шат дарааллын дагуу явагдана :

1. Цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй хувьсагчдыг тодорхойлох
2. 2018 оны ӨНЭЗС-г ашиглан хувьсагчдыг сонгох, загвар тооцоолох
3. 2020 оны өрхийн хэрэглээг орлуулан тооцох
4. 2016 оны ӨНЭЗС-г ашиглан тооцооллын чанарт хяналт хийн баталгаажуулах

Хэрэглээ, хөдөлмөр эрхлэлтийн хувьсагчаас ялгаатай нь, өрхийн амьжиргаатай их хамааралтай өрхийн хүн ам зүй, сууцны шинж байдал, хөрөнгийн өмчлөл зэрэг үзүүлэлт нь эдийн засгийн шокын үед ч хялбар өөрчлөгддөггүй байна (Yoshida, болон бусад., 2021). Тухайлбал, айл өрхүүд гэнэтийн шоконд өртсөн ч барагтай бол амьдарч буй сууцаа өөрчлөх эсвэл ховор эд, хөрөнгөө зардаггүй байна. Ковид-19 цар тахлын нөлөөллийг тодорхойлох зорилготой өрхөд суурилсан судалгааны дүнгээс харахад нийт өрхийн 3 хүрэхгүй хувь нь цар тахлын сөрөг нөлөөллийг даван туулах зорилгоор хөрөнгөө зарсан байна. Тиймээс цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөггүй буюу аажим өөрчлөгдөх хувьсагчаар л 2020 оны хэрэглээний түвшин, ядуурлын тооцоог хийх боломжтой юм.

Шигтгээ Хүснэгт 2. 2018 оны бодит болон 2020 оны орлуулж тооцсон хэрэглээ ба ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, суурьшлаар

	2018 Бодит	SE	2018 Тооцсон	SE	2020 Тооцсон	SE	2018 оны тооцсон-бодит өөрчлөлт	2020 тооцсон-2018 бодит өөрчлөлт
Улсын дундаж	28.4	0.7	28.5	0.9	24.3	0.7	0.1	-4.1
Хот	27.2	0.9	27.4	1.1	23.5	0.9	0.2	-3.7
Хөдөө	30.8	0.8	30.5	1.1	25.9	0.9	-0.3	-4.8
Улаанбаатар	25.9	1.2	26.0	1.4	21.4	1.2	0.1	-4.5
Аймгийн төв	30.1	1.2	30.6	1.3	28.7	1.2	0.5	-1.3
Сумын төв	28.9	1.0	29.5	1.2	23.7	1.2	0.6	-5.2
Хөдөө	32.9	1.3	31.7	1.7	28.3	1.5	-1.3	-4.6

Дараах газар зүйн 4 байршилд “Ковид-19 цар тахлын өмнөх” загварыг ашиглан тооцоолол хийв. Үүнд: Улаанбаатар, аймгийн төв, сумын төв болон хөдөө орно¹. Шигтгээ Хүснэгт 2-г үзнэ үү. 2018 оны бодит болон орлуулгын аргаар тооцсон ядуурлын түвшний хоорондох ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна. Мөн 2018 оны “Ковид-19 цар тахлын өмнөх” болон “Ковид-19 цар тахлын дараах” загваруудын ядуурлын түвшин маш ойролцоо байна.

Нөгөө талаар, “Ковид-19 цар тахлын өмнөх” болон “Ковид-19 цар тахлын дараах” загваруудын ядуурлын түвшний ялгаа нь өндөр бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой байна. Цар тахалгүй байсан бол ядуурлын түвшин 2020 онд 3.5 нэгж хувиар бага байхаар байв. Эдгээр тооцооллын зөрүүгээс үзэхэд цар тахал нь өрхийн хэрэглээний түвшин, хөдөлмөр эрхлэлтэд бодитоор нөлөө үзүүлсэн байна. Мөн “Ковид-19 цар тахлын дараах” загварт цаг хугацаанаас хамаарч өөрчлөгддөг хувьсагчуудыг оруулсан нь цар тахал нь өрхийн амьжиргаа, ядуурлын түвшинд хэрхэн сөргөөр нөлөөлснийг харуулж байна.

¹ Мэдрэмжийн шинжилгээнээс үзэхэд байршил, аймгийн бүлгийн загварууд нь улс, хот, орон нутаг дахь ядуурлын түвшинг маш ойролцоо тооцож байна.


2020 оны орлуулж тооцсон ядуурлын үр дүнгээр аймгуудын талаас илүү хувьд нь ядуурлын түвшин 2018-2020 оны хооронд буурсан байна (Хүснэгт А.1). Хэдий тийм ч Говьсүмбэр, Сүхбаатар, Архангай зэрэг цөөн аймгийн хувьд ядуурлын түвшин буурсан үзүүлэлт нь 5%-ийн түвшинд статистикийн ач холбогдолтой байгаа бол Өмнөговь, Дундговь, Баянхонгор аймгуудад ядуурлын түвшин статистикийн ач холбогдолтой байгаа нь өссөн байна.

5-р алхам: Үнэлэлт хийн баталгаажуулах нь

Тавдугаар алхмын хүрээнд бид 2018 загварын тогтвортой байдлыг шалгана. Тодруулбал, 2018 загвар нь ядуурлын түвшинг бусад онуудаар үнэн зөв тооцож чадах эсэхийг үнэлэхийн тулд загварыг 2016 онд ашигласан. Ингэснээр бид өмнөх оны ядуурлын бодит түвшинг орлуулж тооцсон түвшинтэй харьцуулах боломжтой болно. Мөн 2018 оны загвар нь 2020 оны ядуурлын түвшинг орлуулж тооцоход хэр үнэн зөв байх талаар ойлголтыг өгнө. Ялангуяа 2016 он нь Монгол Улсын хувьд зуд, макро эдийн засгийн хүнд хямралд, айл өрхүүд улс орон даяараа өртсөн жил байсан тул 2016 он дээр шалгахад зохимжтой юм.

Зураг А.4-өөс харахад 2018 оны “Ковид-19 цар тахлын дараах” аймгийн бүлгийн загвар нь 2016 он дээр сайн ажиллаж байгаа нь харагдаж байна. 2016 оны аймгийн бүлгүүдийн ядуурлын бодит болон орлуулсан түвшний хооронд ялгаа ерөнхийдөө бага бөгөөд статистикийн ач холбогдолгүй байна. Онцлох зүйл гэвэл 2016 оны хотын 6-р бүлэг болон хөдөөгийн 3-р бүлгийн хувьд ядуурлын түвшин нь 95% итгэх интервалаас давсан байна. Хэдий тийм ч бүх зөрүүтэй байдал нь 10%-ийн түвшинд ач холбогдолгүй байна.


Зураг А.4 2016 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, бүлгээр



Тайлбар: Зураг А.1-ээс аль бүлэгт ямар аймаг байгааг харна уу.

Улс, хот, хөдөөгийн 2016 оны ядуурлын бодит болон орлуулж тооцсон түвшин ойролцоо байсан ба хоорондын зөрүү нь 5%-ийн түвшинд статистикийн хувьд ач холбогдолгүй байв (Зураг А.5). Мөн 2018 оны аймгийн бүлгийн загварууд нь ядуурлын түвшинг аймгаар тооцоход ерөнхийдөө сайн тохирч байгаа нь харагдаж байна. Завхан, Увс аймгаас бусад аймгийн хувьд орлуулж тооцсон ядуурлын түвшин нь 95%-ийн итгэх интервалд багтаж байна. Тухайн хоёр аймгийн хувьд 2016-2018 онд ядуурлын түвшин нэлээд өөрчлөлттэй гарч байжээ. Тухайн онуудад Завхан аймагт ядуурлын түвшин хамгийн их буурч (21.8 нэгж хувиар) байсан бол Увс аймагт хамгийн ихээр өсч (5.5 нэгж хувиар) байжээ. Ийнхүү 2 жилийн хооронд ерхийн амьжиргаанд нөлөөлсөн томоохон өөрчлөлт гарсан нь 2018 оны загвараар 2016 оны ядуурлын түвшинг тооцоход энэ хоёр аймгийн хувьд тохиромжгүй болсон байх магадлалтай. Хэдий тийм ч 2018-2020 онд чиг хандлага тогтвортой байсан учраас 2018 загварыг ашиглан 2020 оны Завхан, Увс аймгуудын ядуурлын түвшинг зөв тооцох боломжтой хэмээн үзэж байна.

Зураг А.5 Баталгаажуулалт: 2016 оны бодит болон орлуулж тооцсон ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар




ТЭГШ БУС БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ НЬ

Аймгийн бүлэг тус бүрийн загвар нь 2020 оны амьжиргааг үнэн зөв симуляцилж чадах эсэх, мөн тэгш бус байдлыг үнэлэх боломжтой эсэх нь үлдсэн асуулт болж байна. Кернелийн график нь бодит лог-хэрэглээ болон орлуулж тооцсон 20 векторын тархалтыг харьцуулж харуулж чадах ба Зураг А.6-д үзүүлснээр тархалт маш ойролцоо төстэй байгаа бол мөн 2020 оны орлуулж тооцсон векторын тархалт маш адилхан байгааг Зураг А.6 (б)-аас харж болно.

Зураг А.6 Орлуулж тооцсон нэг хүнд ногдох лог-хэрэглээний тархалт

(а) 2018 оны нэг хүнд ногдох сарын бодит болон орлуулж тооцсон лог-хэрэглээ

(б) 2020 оны нэг хүнд ногдох сарын орлуулж тооцсон лог-хэрэглээ



Хэдийгээр 2018 оны орлуулсан тооцсон болон бодит хэрэглээний тархалт төстэй харагдаж байгаа боловч Жини коэффициент гэх мэт тэгш бус байдлын хэмжүүр нь тархалтын оройн хэсэгт байгаа утгад мэдрэмтгий байж болно. Орлуулж тооцсон үр дүнгээр гаргасан Жини коэффициентүүдийг бодит утгатай нь харьцуулсаныг Хүснэгт А.2-оос үзнэ үү. Үүнээс үзэхэд аймгийн загварууд нь 2016, 2018 оны хэрэглээний түвшний тархалтыг улс, хот болон хөдөөгийн түвшинд маш нарийн тооцсон нь харагдаж байна. Жини коэффициент нь тооцсон он бүрт суурьшлаар бараг ижил байгаа бол хөдөөгийн түвшинд таамагласан коэффициент нь бодит утгаасаа ялимгүй бага байна. 2020 оны орлуулсан тооцооллоор тэгш бус байдал улс, хотын түвшинд тогтвортой байсан бол хөдөөд бага зэрэг буурсан байна.

Хүснэгт А.2 Бодит болон орлуулж тооцсон Жини коэффициент

	2016		2018		2020
	Бодит	Тооцсон	Бодит	Тооцсон	Тооцсон
Улсын дундаж	0.323	0.323	0.323	0.323	0.323
Хот	0.331	0.331	0.331	0.334	0.334
Хөдөө	0.296	0.290	0.296	0.290	0.286

ХАВСРАЛТ Б.

Хүснэгт Б.1 2018 оны нэг хүнд ногдох сарын бодит болон орлуулж тооцсон дундаж хэрэглээ ба ядуурлын түвшин, бүлгээр

	Нэг хүнд ногдох сарын хэрэглээ					Ядуурлын түвшин				
	Бодит	Стандарт алдаа	Тооцоолсон	Стандарт алдаа	Тооцоолсон-Бодит өөрчлөлт	Бодит	Стандарт алдаа	Тооцоолсон	Стандарт алдаа	Тооцоолсон-Бодит өөрчлөлт
Хотын бүлэг 1	306.4	7.1	303.3	5.3	-3.1	25.9	1.2	25.3	1.3	-0.6
Хотын бүлэг 2	235.9	10.0	235.0	10.5	-0.9	37.3	3.1	39.1	3.1	1.8
Хотын бүлэг 3	275.4	9.3	272.7	9.5	-2.8	28.6	2.3	28.7	2.7	0.1
Хотын бүлэг 4	294.3	10.1	294.3	10.2	0.0	19.6	1.9	21.8	2.5	2.2
Хотын бүлэг 5	224.5	10.7	221.9	10.9	-2.6	46.6	3.0	44.4	3.3	-2.2
Хотын бүлэг 6	262.7	8.1	263.7	10.5	1.1	30.4	2.5	30.9	2.9	0.5
Хотын бүлэг 7	223.4	12.1	223.1	11.0	-0.3	40.8	4.0	39.4	3.4	-1.5
Хотын бүлэг 8	304.8	10.6	304.0	11.2	-0.8	22.3	2.3	22.8	2.3	0.5
Хөдөөгийн бүлэг 1	279.7	7.6	280.1	8.8	0.4	20.0	2.2	21.1	2.4	1.1
Хөдөөгийн бүлэг 2	226.4	6.2	226.4	6.2	0.0	35.5	2.1	36.1	2.7	0.6
Хөдөөгийн бүлэг 3	260.7	7.6	259.6	8.1	-1.1	33.9	2.1	32.7	2.4	-1.2
Хөдөөгийн бүлэг 4	286.7	6.7	285.4	7.9	-1.4	24.9	1.7	25.0	2.1	0.0
Хөдөөгийн бүлэг 5	229.6	3.7	228.0	4.2	-1.6	34.4	1.7	33.1	2.2	-1.3
Хөдөөгийн бүлэг 6	244.9	6.6	243.4	6.6	-1.5	30.8	2.0	31.4	2.6	0.6

Тайлбар: ** - Ач холбогдлын түвшин 5%-д байгааг илэрхийлнэ. Зураг А.1-ээс аль аймаг аль бүлэгт байгааг харна уу.

Хүснэгт Б.2 2018 оны нэг хүнд ногдох бодит болон орлуулж тооцсон дундаж хэрэглээ ба ядуурлын түвшин, улс, хот, хөдөө, аймгаар

	Нэг хүнд ногдох сарын хэрэглээ					Ядуурлын түвшин				
	Бодит	Стандарт алдаа	Тооцоолсон	Стандарт алдаа	Тооцоолсон-Бодит өөрчлөлт	Бодит	Стандарт алдаа	Тооцоолсон	Стандарт алдаа	Тооцоолсон-Бодит өөрчлөлт
Улсын дундаж	279.9	3.4	278.0	2.8	-1.9	28.4	0.7	28.2	0.7	-0.2
Хот	294.4	5.0	292.0	3.9	-2.4	27.2	0.9	27.0	0.9	-0.2
Хөдөө	251.4	2.7	250.5	3.1	-1.0	30.8	0.8	30.7	1.1	-0.1
Улаанбаатар	306.4	7.1	303.3	5.3	-3.1	25.9	1.2	25.3	1.3	-0.6
Дорнод	217.8	9.3	215.4	9.3	-2.4	42.5	3.1	43.4	3.4	0.9
Сүхбаатар	289.9	9.9	287.4	12.2	-2.5	30.2	2.5	27.8	3.4	-2.3
Хэнтий	247.3	11.3	243.9	10.0	-3.4	38.0	3.1	36.3	3.0	-1.7
Төв	322.3	9.8	310.5	11.6	-11.8	20.5	2.2	20.7	2.8	0.2
Говьсүмбэр	182.1	7.3	187.0	10.3	4.8	51.9	4.8	51.9	5.7	0.0
Сэлэнгэ	240.2	7.6	250.0	10.7	9.8	34.0	2.5	32.3	3.5	-1.6
Дорноговь	284.4	8.6	287.1	11.5	2.7	23.4	2.5	22.9	3.0	-0.5
Дархан-Уул	249.6	12.9	248.2	13.2	-1.4	32.8	4.0	35.3	4.2	2.5
Өмнөговь	310.9	9.7	312.8	11.0	1.9	11.8	2.0	15.4	2.6	3.6
Дундговь	302.9	9.5	297.1	10.8	-5.8	21.7	2.5	22.7	3.0	1.0
Орхон	299.3	14.9	295.0	14.0	-4.2	25.1	3.2	24.6	2.9	-0.4
Өвөрхангай	236.9	6.4	234.9	7.0	-1.9	34.1	2.4	33.5	2.6	-0.6
Булган	211.3	6.9	229.8	7.7	18.6**	36.8	3.1	35.1	3.7	-1.7
Баянхонгор	256.4	10.2	250.3	9.4	-6.2	29.6	2.3	28.6	3.5	-1.1
Архангай	217.0	6.4	216.3	7.8	-0.8	38.2	2.3	40.5	3.5	2.2
Хөвсгөл	266.4	9.3	263.6	9.2	-2.9	25.3	2.8	26.7	3.1	1.5
Завхан	257.5	7.0	262.6	7.3	5.1	25.7	2.5	23.5	2.7	-2.2
Говь-Алтай	200.5	8.0	196.1	6.4	-4.4	45.1	3.3	46.3	3.1	1.2
Баян-Өлгий	284.0	9.2	276.8	9.3	-7.3	24.3	2.2	24.5	2.9	0.2
Ховд	214.7	6.5	216.0	7.7	1.3	40.9	3.0	41.1	3.3	0.2
Увс	239.0	6.3	246.6	7.2	7.7	29.6	2.5	31.1	2.9	1.5

Тайлбар: ** - Ач холбогдлын түвшин 5%-д байгааг илэрхийлнэ.